




United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



British Embassy
Tashkent



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ СЭТГҮҮЛ ЗҮЙД.

СЭТГҮҮЛЧ БОЛОН СЭТГҮҮЛ ЗҮЙН БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА.

Узбекистаны хэвлэл мэдээллийн хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр бүтээсэн
ЮНЕСКО-гийн цуврал эмхэтгэл

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ СЭТГҮҮЛ ЗҮЙД.

СЭТГҮҮЛЧ, СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА.

UDC 070:004
BBK 76.01
М 96

Муратова, Нозима.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол сэтгүүл зүйд: сэтгүүлч , сэтгүүлзүйн багш нарт зориулсан гарын авлага [Зохиогчид] / Н. Муратова, А. Гриззл, Д. Мирзахмедова. - Ташкент: Бактрия хэвлэл, 2019 он. - 128 х.

ЮНЕСКО-гийн МЭДЭГДЭЛ

Энэхүү гарын авлагад ашигласан тэмдэглэгээ, танилцуулга зэрэг нь ЮНЕСКО-гийн зүгээс аливаа улс орон нутаг дэвсгэр, хот, талбай эсвэл тэдгээрийн эрх баригчид, эсвэл тэдгээрийн хил хязгаарыг талаар илэрхийлж буй байр суурь биш болно.

Гарын авлагад илэрхийлсэн санаа, үзэл бодол зэрэг нь зохиогчдын бөгөөд тэдгээр нь ЮНЕСКО-д хамаарна гэсэн үг биш, уг байгууллагаас тэдгээрийн төлөө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү номыг Ташкент дахь Британийн Элчин сайдын яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэв. Ингэснээр уг ном нь Британийн Элчин сайдын яамны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй.

Редактор: Алтон Гриззл
Тусламж хамт Хуулбарлах: Денис
Суреев Дизайн: Андрей Холматов

2

Төслийн зохицуулагч: Санжарбек Аллаяров

Төслийн туслах ажилтан: Баргида Муминжонова



Энэхүү номыг Attribution - ShareAlike 3.0 IGO (CC-BY-SA) даруу нээлттэй хандах, ашиглах боломжтой. 3.0 IGO Тусгай зөвшөөрөл (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>). Номд багтсан агуулгыг ашигласан аливаа этгээд ЮНЕСКО-гийн Нээлттэй сангийн дүрмийг хүлээн зөвшөөрнө (<http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en>).

2019 онд Нэгдсэн Үндэстний Боловсролын, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллагаас хэвлэв. 7, Газар де Фонтеной, 75352 Парис 07 SP, Франц улс

ЮНЕСКО-гийн Ташкент дахь оффис Ташкент, 100170,
Эргашев гудамж, 9, Узбекистан Хэвлэсэн: Мега Басим

Монгол хэлнээ орчуулсан: Хэвлэлийн Хүрээлэн, 2024 он

© Н.Муратова, А.Гриззл , Д.Мирзахмедова, 2019 он
© Baktria press, 2019 он
© ЮНЕСКО, 2019 он

Шүүмжлэгч нар:

Олунифеси Сураж, PhD

Олон нийтийн мэдээллийн харилцааны тэнхимийн ахлах багш
Лагосын Их Сургууль, Нигери улс

Зохицуулагч, ЮНЕСКО Их сургуулийн Сүлжээ , Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол & Соёл хоорондын яриа хэлцэл (Нигерийн Бүлэг).

Томас Дуран-Бесерра, PhD

Барселонагийн Автономит их сургуулийн сэтгүүл зүй, мэдээлэл харилцааны доктор, ЮНЕСКО-UNAOC MILID Сүлжээний гишүүн.

Колумбын CUN Их сургууль, Үндэсний Судалгааны газрын Захирал.

Рамзон Р. Туазон

Азийн Сэтгүүл зүй, мэдээлэл харилцааны хүрээлэнгийн (AIJC)Ерөнхийлөгч.

Филиппинын Манила дахь Хэвлэл мэдээлэл харилцаа холбооны төвийн (AMIC) Ерөнхий нарийн бичгийн дарга.

Доктор Маха М. О. Башри

Нэгдсэн Арабын Эмиратын Их сургуулийн Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны коллеж, Хэвлэл мэдээлэл, бүтээлч үйлдвэрлэлийн тэнхимийн дэд профессор Аль Айн, АНЭУ.

Профессор Маркус Лийнинг

Винчестер, Их Британийн Дижитал хэвлэл мэдээлэл боловсролын их сургуулийн профессор

Проф. Лиза Жанике Хинчлиф

Урбана-Шампэйн дахь Иллинойсын Их сургуулийн профессор, АНУ.

Акбар Нурматов, PhD

Узбекистаны Сэтгүүл зүй, олон нийтийн мэдээллийн харилцааны их сургуулийн Хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн, хэвлэн нийтлэлийн тэнхимийн эрхлэгч

Венера Каюмова

“Узбекистан дахь Гадаад Хэл» цахим сэтгүүлийн Шинжлэх ухааны болон уран зохиол редактор

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 6

Шүүмжлэлтэй, чанартай сэтгүүл зүйн төлөөх хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол 6

ОРШИЛ..... 10

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол ба сэтгүүл зүйн тухай ЮНЕСКО-ийн гарын авлагын онцлог 10

I ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН НҮДЭЭР 15

1.1 Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын үндсэн ойлголт ... 16

1.2. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын ач холбогдол 22

1.3 ЮНЕСКО-гийн ХММСБ-ын таван дүрэм 24

1.4. ХММСБ мэдээллээс хамгаалах хэрэгсэл байхаас хөгжлийн хамтрагч болох хүртэл..... 25

II ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ СЭТГҮҮЛ ЗҮЙН БОЛОВСРОЛД 33

2.1. Сэтгүүл зүйн оюутан, сургагч багш нарт зориулж хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын чадавхыг тодорхойлох нь 34

2.2. Цензур, шахалтыг ХММСБ-оор даван туулахуй: иргэдийн бие даасан байдлыг хангах шүүн тунгаах сэтгэхүй..... 43

2.3 Хэвлэл мэдээллийн агуулгыг ажиглаж, тайлбарлах замаар иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах нь 45

2.4 ХММСБ-ыг дэмжин сурталчлах замаар хэвлэл мэдээлэл болон номын сангийн хамтын ажиллагааг дэмжих 46

2.5 Уламжлалт бус мэдээллийн эх сурвалжтай ажиллахуй..... 50

2.6 ХММСБ жендэрийн тэгш байдлыг дэмжих хэрэгсэл болох нь 56

2.7. Нээлттэй өгөгдлийн эринд мэдээлэл цуглуулах нь 63

2.8. Мэдээллийг дүрсжүүлэх: сэтгүүл зүйн шинэ онцлог 65

III ХЭСЭГ. ХММСБ БА ПРАКТИК СЭТГҮҮЛ ЗҮЙ 69

3.1 ХММСБ сэтгүүл зүйд яагаад чухал вэ? ХММСБ-оор дамжуулж хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг бэхжүүлэх тухай 70

3.2. ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлж буй хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоо, ТББ, зохицуулах байгууллагууд 77

3.3 ХММСБ ба сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүй 83

3.4 ХММСБ-ын хөгжлийн талаар сурвалжлах арга техник 85

3.5 ХММСБ-ын талаар редакцын бодлого боловсруулж, хэрэгжүүлэхүй .. 90

3.6 Цахим орчин дахь хүний эрх. Сэтгүүл зүй ба ХММСБ иргэний боловсролыг дээшлүүлэх хэрэгсэл болох нь	92
3.7 Хэвлэл мэдээллийн агуулга: ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлэх зорилго, арга зүй	94
3.8 ХММСБ практикт: өөрийгөө үнэлэх дасгал	97

IV ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ГАРЫН АВЛАГА	101
4.1. Хянах хуудас №1: ХММСБ-ыг хэрхэн сурталчлах вэ?	103
4.2. Хянах хуудас № 2: сэтгүүлчийн сурвалжилгад ХММСБ-ыг хэрхэн нэгтгэх вэ?	104
4.3. Хянах хуудас №3: эх сурвалж дээр ажиллах.....	105
4.4. Хянах хуудас №4: сэтгүүл зүйн бичвэр хэрхэн бэлтгэх вэ?.....	105
ТАЙЛБАР ТОЛЬ.....	114
НОМ ЗҮЙ.....	119
ХАВСРАЛТ 1.....	121

ШҮҮМЖЛЭЛТЭЙ, ЧАНАРТАЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН ТӨЛӨӨХ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ

Хэл үгүй бол хүн төрөлхтөн үгүй. Сэтгүүл зүй үгүй бол ардчилал үгүй. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол (ХММСБ) үгүй бол ардчилсан, хүмүүнлэг яриа хэлэлцээ үгүй.

Хэвлэл мэдээллийн нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцоо гүнзгийрэн эрчимжиж, мэдээллийн урсгал хурдацтайгаар нэмэгдэж буй цаг үед сэтгүүл зүй ба ХММСБ хоорондоо нэгдэн уусах нь ардчилсан, олон нийтийн яриа хэлэлцээний хамгийн чухал баталгаа болох юм. Тийнхүү нийтийн яриа хэлэлцүүлэгт оролцох мэдлэг, боловсрол нь иргэдэд эрхээ ээ хэрэгжүүлэх боломжийг сайжруулахад шийдвэрлэх үүрэгтэй.

Тиймээс, ойрын ирээдүйд сэтгүүл зүйн чанарыг баталгаажуулахад ХММСБ болон сэтгүүл зүйн хамтын ажиллагааг хангах нь үндсэн асуудал болоод байна. Энэ асуудал нь энэхүү гарын авлагын гол сэдэв юм. Өөрөөр хэлбэл өнөөгийн сэтгүүл зүйд зайлшгүй шаардлагатай шинэчлэлийн гол түлхүүр болоод буй ХММСБ-ыг сэтгүүл зүйн практик, сургалтын үйл ажиллагаанд хэрхэн нэгтгэх тухай энэхүү гарын авлагад өгүүлнэ.

Чанартай сэтгүүл зүй ба ХММСБ-ын хооронд хамтын ажиллагаа өрнүүлэх бүрэн боломжтой, учир нь тэдний үнэ цэн, зорилго ижил юм. Аль аль нь хүмүүсийн бие даасан байдал, шүүмжлэлт сэтгэлгээг хүндлэх зарчмыг баримталдаг. Аль аль нь үнэнийг эрэлхийлж, мэдээллийг нягтлахыг эрхэмлэдэг. Аль аль нь олон нийтийн яриа, хэлэлцүүлгийг дэмжиж, хүмүүс хоорондын ойлголцлыг эрэлхийлдэг, мөн олон ургалч үзэл, олон талт байдлыг ямар ч цензургүйгээр хамгаалдаг.

Гэвч, өдийг хүртэл сэтгүүл зүй ХММСБ-ыг үл тоомсорлосноор ирснийг дурдах хэрэгтэй. Саяхныг хүртэл сэтгүүлчид зөвхөн мэдээ бэлтгэж түгээх, мөн хүмүүсийн санаа бодлыг бүрдүүлж, шүүмжлэлтэйгээр удирдан чиглүүлэхэд анхаарч байв. Энэ бол тэдний гүйцэтгэх ёстой дан ганц үүрэг гэдэгт итгэж байв. Сэтгүүлчид өөрсдийгөө ертөнцийн бодит байдлыг хэрэглэгчид хүргэж, мэдээллийг зуучлах үүрэгтэй хэмээн ойлгож байсан. Сэтгүүлчид мэдээллийг дамжуулж, хэрэглэгчид (иргэд) идэвхгүй хүлээн авагчийн үүргийг гүйцэтгэх загвар саяхныг хүртэл ноёрхож ирсэн.

Харин өнөө үед байдал эрс өөрчлөгдсөн. Тоон технологийн хөгжлийг даган хүний амьдралд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг эрчимтэй нэмэгдсэнээр уламжлалт идэвхгүй хэрэглэгч идэвхтэй оролцогч болох, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах, өөрийн мэдээллийг бий

болгох, тэр болгон сэтгүүл зүйн зуучлалгүйгээр харьцангуй эрх чөлөөтэй мэтгэлцэх боломжтой болсон.

Энэ шинэ нөхцөлд сэтгүүл зүйн үүрэг өөрчлөгдөх ёстой бөгөөд сэтгүүл зүйг дахин шинээр бүтээх шаардлага хэрэгцээ бий болоод байна. Хэвлэл мэдээллийн гүйцэтгэх шинэ эрхэм зорилго бол мэдээлэл өгөх онцгой эрхийг хадгалах биш, харин найдвартай лавлахын үүрэг гүйцэтгэх, үнэн зөв мэдээллийн баталгаа болох явдал юм. Тиймээс хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг бий болгож, энэ итгэлийг алдахгүй хадгалах нь маш чухал юм.

Сэтгүүл зүй нийгмийн тоглолтын агуу гоцлогч нь байхаа больсон. Сэтгүүл зүйн шинэ үүрэг зорилго бол иргэдэд дуу хоолойгоо нийтэд хүргэх, олон нийтийн ярианд тэгш эрхтэй оролцох, харилцан яриа өрнүүлэх боломжийг олгох, ардчилсан хэлэлцүүлгийг дэмжих явдал юм. Сэтгүүл зүйн шинэ эрхэм зорилго бол нийгмийн найрал хөгжмийн зохиролд хувь нэмрээ оруулахыг хичээх явдал юм. Энэхүү найрал хөгжим нь аажмаар өргөжин улам олон өнгөөр баяжих ба түүнд аливаа иргэн хувь нэмэр оруулах боломжтой юм.

Эдгээрийн алийг ч ХММСБ-гүйгээр хэрэгжүүлэх боломжгүй.

Иргэд олон нийтийн хэлэлцүүлэгт чанартайгаар оролцохгүй бол чанартай сэтгүүл зүй гэж үгүй. Тийм ч учраас хэвлэл мэдээлэл, мэдээллийн ур чадвар, чадавхыг нийт иргэдийн дунд тэгш дээшлүүлэх хэрэгтэй.

Сайн хөрс үгүй бол үр соёолох боломжгүйтэй адил хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн тухай хангалттай мэдлэг бүхий иргэдгүйгээр сайн сэтгүүл зүй цэцэглэн хөгжихгүй. Хамт олны нэг хэсэг нь чимээгүй байгаад байвал сайхан яриа өрнөхгүй.

7

Олон жилийн өмнө сэтгүүлч, Нобелийн утга зохиолын шагналт Альберт Камю (Африк, Европын аль алины хүн) шүүмжлэлтэй (өөрөөр хэлбэл чанартай) сэтгүүл зүйд тавигдах гурван шаардлагыг тодорхойлсон: 1) **сайн мэдээлэх**: яарахгүйгээр, тэвдэхгүйгээр; 2) **мэдээг ойлгоход хувь нэмэр оруулах**: ажиглалтын аргаар, эх сурвалж, зорилго нь тэр бүр ил тод байдаггүй мэдээллийн цар хүрээг яг тогтоох; 3) **олон нийтэд мэдээллийн техник, стратегийн талаар мэдлэг олгох**, үүний зорилго нь “амьдралыг нь хөнгөвчлөхөөс илүү шүүмжлэлт оюун санааг нь хамгаалах” юм. Ийнхүү Камю, *avant la lettre* (уг ойлголт бий болохоос өмнө), сайн сэтгүүл зүй нь ил тод байдлыг хангахын тулд өөрийн үйл ажиллагааг тайлбарлан зааж сургах хэрэгтэйг чухалчилсан бөгөөд, тухайн үедээ хэрэглэгчдийн шүүмжлэл сэтгэлгээ буюу ХММСБ-ын ач холбогдлыг онцолж байжээ.

Өнөөдөр сэтгүүлчид болон ХММСБ-ыг дэмжигчдийн хамтын ажиллагаа аль хэдийн зайлшгүй хүлээх үүрэг хариуцлага болсон. Түүнчлэн олон нийтийн/иргэдийн шүүмжлэлт сэтгэлгээ, бие даасан байдлыг хүндлэх, тэдний мэдээллийн хэрэгсэл ашиглах чадавхаас сайн сэтгүүл зүйн мөн чанар шалтгаалах болсон тул ХММСБ нь нийгэм дэх яриа хэлэлцүүлгийг чанаржуулахад зайлшгүй шаардлагатай зүйл болоод байна.

Энэхүү үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхийн тулд таван чухал зарчимд анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд эдгээрийг энэхүү гарын авлагад тусгасан болно:

1. Үнэн гэдэг зүйл сэтгүүлчдийн ч, иргэдийн ч, бүх хүний дунд бий болдог: үнэн гэх зүйл нягтлан шалгах, ялгарах, харилцан ойлголцох, шүүмжлэх зэрэг системтэй ажлын үр дүн юм. Энэ ажлыг сэтгүүл зүй, ХММСБ-ын хөдөлгөөн хамтдаа хийх ёстой.

2. Худал хуурмагийн эсрэг тэмцэхийн тулд өрөөсгөл, хэвшмэл ойлголт, хаалттай сэтгэлгээний эсрэг тэмцэх шаардлага гардаг: хэвшмэл сэтгэлгээ нь бидний ойлголтод үл нийцэх, сэтгэл тавгүйдүүлэх санаа оноог хүлээн зөвшөөрөхөд саад болдог. Энэ нь нэг төрлийн чимээгүй цензур тогтоохтой адил. Үнэн гэдэг зүйл нийтлэг санаа бодлын урсгалыг сөрөх, өөрийн бодол санаанд байнга шүүмжлэл, сэрэмжтэй хандах, анхааралтай дүн шинжилгээ, арга зүйн эргэлзээн дунд бий болдог. Тиймээс сэтгүүл зүй ба ХММСБ хоёулаа үл нийцсэн байдлаараа, хариултаас илүү асуултад ач холбогдол өгдгөөрөө нэгддэг.

3. Ёс зүй, шударга ёс, хариуцлагагүйгээр сэтгүүлчид итгэх итгэл гэж үгүй: Итгэлцэл сэтгүүлчид болон хэрэглэгчдийн хоорондын хүндлэл, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх зан үйл, мэргэжлийн шударга үйл ажиллагаа дээр тогтдог. Дүрэм журам, хэм хэмжээг бүх хүн мэдэхгүй бол, эдгээр дүрмийг баримтлахад чиглэсэн хамтын сонор сэрэмж үгүй бол ёс зүй, харилцан хүндлэлийг бий болгох боломжгүй. ХММСБ нь сэтгүүл зүйн нийтлэг дүрэм, хариуцлага, хамтын зохицуулалтыг баримтлан дэмжих шүүмжлэлт соёлыг бий болгох замаар чанартай сэтгүүл зүйг дэмждэг.

4. Олон нийт/иргэдийн оролцоогүйгээр чанартай сэтгүүл зүй гэж үгүй: Өнөөдрийн сэтгүүл зүй нэг урсгалтай байхаа больсон. Сэтгүүл зүйг иргэдийн оролцоогүйгээр төсөөлөх боломжгүй бөгөөд, сэтгүүл зүйг идэвхжүүлэн сэргээгч нь нийгмийн харилцан яриа болоод байна. Сэтгүүл зүй хүмүүсийн бүтээлч чадавх, тэдний оролцооноос ашиг тус хүртэхийн нэгэн адил хүмүүс ч сайн сэтгүүл зүйн үр шимийг хүртэх учиртай. Иймд ардчилал болон сэтгүүл зүйн чанар хүмүүсийн оролцооны чанараас шалтгаална. Тийм ч учраас чанартай сэтгүүл зүйг хөгжүүлэхийн тулд иргэдийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн чадавхыг дээшлүүлэх нь маш өндөр ач холбогдолтой. ХММСБ хөгжихийн хэрээр л сэтгүүл зүй урагшилж чадна.

5. Чанартай сэтгүүл зүй болон ХММСБ-ын аль аль нь хүний эрхийг тэгш, ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэгжүүлэх арга хэрэгсэл бөгөөд зорилго болох ёстой: Үүний тулд сэтгүүл зүй ба ХММСБ нь улс төр, эдийн засгийн болон бусад төрлийн аливаа эрх мэдлийн нөлөөнд автахгүй байх ёстой. Ингэснээр иргэд улс төрийн арга заль, бизнесийн шахалт, эдийн засгийн ашиг хонжоо хөөх зэрэг дарамт шахалтад автахгүй.

Чанартай сэтгүүл зүйн хэрэгцээ нийгэмд улам бүр өсөн нэмэгдэж байна. Эдгээр таван зарчимд тулгуурлан сайн сэтгүүл зүй болон ХММСБ-ыг дэмжих хөдөлгөөний хооронд нягт холбоо тогтоож болно.

Энэ бүхнээс хүчтэй эвсэл үүсгэж болох бөгөөд, хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын дэлхийн холбоо (GAPMIL) болон олон улсын ХММСБ ба соёл хоорондын яриа хэлэлцээний их сургуулийн сүлжээ зэргийг жишээ болгон дурдаж болно. Дээр зарчмуудыг сэтгүүлчдийн болон иргэдийн сургалтыг сайжруулахад ашиглаж, нийгмийн яриа хэлэлцүүлгийг шинэ түвшинд өрнүүлэхэд түлхэц болж болох юм.

Таны гарт очиж буй энэхүү гарын авлага бол сэтгүүл зүйн чанарыг сайжруулах, ХММСБ-ыг боловсронгуй болгоход тус нэмэр болох маш сайн хэрэгсэл юм.

Хосе Мануэль Перес Торнеро

ЮНЕСКО-гийн Чанартай сэтгүүл зүйн төлөөх ХММСБ –ын
тэнхимийн захирал,
Барселоны автономит их сургууль.ЮНЕСКО- НҮБ-ын
соёл иргэншлийн холбооны ХММСБ ба соёл хоорондын яриа
хэлэлцээний их сургуулийн сүлжээний гишүүн.

ОРШИЛ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН ТУХАЙ ЮНЕСКО-ИЙН ГАРЫН АВЛАГЫН ОНЦЛОГ

Интернэтээр хэсүүчлэх, гэмгүй яриа хөөрөө өрнүүлэх урьдын зан үйл мэдээллийн орчны цахим хувьслын явцад өөрчлөгдөж мушгин гуйвуулах, тогтворгүй байдлыг бий болгох өгөгдлийн олборлолт болж хувираад байна. Энэ нь хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын ач холбогдол улам бүр чухал болж байгааг онцолж буй. Боловсролын энэ хэлбэрийг ярихын тулд хэвлэл мэдээллийн мөн чанар, түүнийг бүтээж буй улс төр, ёс зүйн үндэс суурийг эргэн харах шаардлагатай болоод байна.

Дивина Фрау-Мейгс

*“Тогтвортой дижитал хөгжлийн эрин үед
бүтцийн өөрчлөлт хийх ЧАДВАР”.*

10

Уг гарын авлага нь боловсрол ба сэтгүүл зүйн практикийг нэгтгэх зарчимд тулгуурласан болно. Номын эхний хэсэгт хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын үндсийг тайлбарлахыг зорив. Ингэхдээ “хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэсэн нэр томъёог хоёр хэмжээст авч үзсэн. Нэгдүгээрт, мэдээллийн хэрэгсэл бол өөрөө тодорхой бүтэц бүхий институц, “Дөрөв дэх засаглал” мөн. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, сайн засаглал, хөгжил дэвшилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнд радио, телевиз, онлайн болон офлайн сонин мөн Интернэт дэх сэтгүүл зүйн контент орно. Хоёрдугаарт, мэдээллийн хэрэгсэлд харилцаа холбооны олон төрөл хэлбэрийг хамруулна. Тухайлбал, өргөн нэвтрүүлэг, кабелийн телевиз, радио, сонин, кино, видео тоглоом, ном, сэтгүүл, Интернэтийн зарим хэрэглээ гэх мэт. ХММСБ нь эдгээр бүх хэлбэрийг хамардаг. ЮНЕСКО мэдээлэл, мэдээнд онцгой анхаарал хандуулдаг ч энтертайнмент, хүмүүс хоорондын харилцаа холбоо, зар сурталчилгаа зэрэг бусад контентыг ч харгалзан үзэх шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг.

Энэхүү гарын авлагад “Мэдээлэл нийлүүлэгч” гэсэн нэр томъёо мэдээллийн удирдлага, мэдээллийн агентлаг, санах ой, соёл, цахим мэдээллийн байгууллагад хамаарна. Үүнд номын сан, архив, музей, мэдээллийн менежментийн байгууллага, ашгийн төлөө бус болон ашгийн төлөөх мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч, сүлжээ, онлайн контентын ханган нийлүүлэгч болон бусад оролцогчид багтана.

“Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол ХММСБ-ын хөгжлийн түнш” хэмээх бүлэг болон гарын авлагын зарим бусад хэсгүүдийг харьцангуй шинэ сэдэв гэж үзэж

болно. Эдгээрт сэтгүүлчид хэвлэл мэдээллийн суурь боловсролыг хэрхэн түгээн дэлгэрүүлэх талаар задлан шинжилсэн юм.

“Сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутан, багш нарт хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын чадавхыг төлөвшүүлэх нь” бүлэгт мэдлэгт суурилсан нийгэм, бүх нийтээр цахимжсан эрин үед сэтгүүлчдэд чухал ач холбогдолтой чадавхын талаар хөндсөн. Түүнчлэн, ХММСБ дахь жендерийн сэдэв, мөн жендерийн тэгш байдлыг дэмжихэд ХММСБ-ын гүйцэтгэх үүрэг, ХММСБ-ээр дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бий болгох асуудлыг онцлов.

Энэхүү эмхэтгэлд ХММСБ-ын редакцын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх сэдвийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулан дэвшүүлсэн нь өнөөг хүртэл ХММСБ-ын талаарх ном, гарын авлагад тусгагдаагүй цоо шинэ зүйл юм. Гарын авлагын төгсгөлийн хэсэгт оруулсан практик хэрэгсэл нь гарын авлагаас олж авах мэдлэгийг батжуулахад зориулсан болно.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн болон өөрийн зохицуулалтын чиглэлээр ажиллаж буй сэтгүүл зүйн багш, оюутан, сэтгүүлч, мэргэжилтэн бүр хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх ойлголт, үнэлэмжээ сайжруулж, өөрийн ажил, судалгааны хэм хэмжээ болгон баримтлах ёстой. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол нь сэтгүүл зүй чанартай, ёс зүйтэй байх боломжийг бүрдүүлж, иргэд, засгийн газар, хэвлэл мэдээллийн түншлэлээр дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бий болгож, иргэдийн оролцоог идэвхжүүлж чадна.

Энэхүү гарын авлага нь сэтгүүлч, сэтгүүл зүйн багш, хэвлэл мэдээллийн эрх зүйч, иргэний нийгмийн байгууллагуудад мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг дэмжин хөгжүүлэхэд чухал практик хэрэглүүр болох зорилготой юм.

Олон улсын түвшинд худал, ташаа мэдээллийг таньж мэдэх, харьцах, худал хуурмагийг илрүүлэх зэрэг сэдвээр сэтгүүлч, сэтгүүл зүйн багш нарт зориулсан төрөл бүрийн нийтлэлийг бэлтгэж түгээсэн байдаг. Жишээлбэл, Олон Улсын Сэтгүүлчдийн Төв (ICFJ) саяхан “ташаа мэдээлэл, худал мэдээлэл”-ийн түүх, худал мэдээллийн талаарх товч гарын авлагыг хэвлүүлсэн бөгөөд зохиогчид худал ташаа мэдээллийн өнөөгийн хямралын цаг хугацааны тоймыг харуулсан байдаг. Уг нийтлэлд Клеопатрагийн эрин үеэс Кембриж Аналитика¹ хүртэлх түүхэн цаг үеийг онцолсон. Худал ташаа мэдээлэл, тэдгээрийн эсрэг хамгаалалтын хариу арга хэмжээний хямрал өрнөж буйн хэрээр олон янзын харах өнцөг бүхий бичвэрүүд хэрэгтэй болоод байна.

Бразилын баримт шалгах платформ болох Аос Фатосын 2017 оны 4-р сард нийтэлсэн “Фредийн баримт ташаа мэдээлэл, худал мэдээлэлд автдаггүй” хэмээх гарчиг бүхий удирдамжид цахим орчинд ямар хялбар бөгөөд хурдтайгаар тархаж болохыг тодорхой харуулсан. Уг бүтээлд худал, ташаа мэдээллийн асуудлыг хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролтой холбон авч үзсэн байна.

1 Julie Posetti, Alice Matthews. A Short Guide to the History of 'Misinformation and disinformation' and Disinformation. <https://www.icfj.org>

Худал ташаа мэдээллийн талаарх сүүлийн үеийн нийтлэлийн жишээ болгож ЮНЕСКО-гийн *Journalism* сэтгүүлд 2018 онд хэвлэгдсэн “*Ташаа мэдээлэл ба худал мэдээлэл*”: сэтгүүл зүйн боловсрол, сургалтын гарын авлага”-ыг дурдаж болно. Энэхүү эх сурвалж шинээр болон дахин сэргэж буй, сэтгүүл зүйн чанар, нөлөөлөл, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх болсон хэд хэдэн үзэгдэлд анхаарал хандуулсан бөгөөд үүнд худал мэдээллийн тухай хэсэгт голлох үүргийг гүйцэтгэж байна. Эх сурвалж сэтгүүлчдэд худал болон ташаа мэдээлэл, хортой мэдээлэлтэй тэмцэх олон арга замыг санал болгосны дотор хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролоор дамжуулан тэмцэх арга ч бас оржээ.²

“Давхар хяналт сэтгүүлчид болон хэрэглэгчдэд нөлөөлөх нь” хэмээх өөр нэгэн бүтээл 2017 оны 11-р сард хэвлэгдсэн. Софи Шове, Эммануэль Марти нарын бүтээлд үндэслэсэн энэхүү нийтлэлд олон улсын сэтгүүл зүйн туршлага, хэвлэл мэдээллийн хэрэгслээс түүвэрлэсэн жишээнд анхаарал хандуулж, сэтгүүлчийн анхаарах ёстой зарим бодит нөхцөл байдлыг тайлбарласан болно.

Уншигч танаа толилуулж буй энэхүү «Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол сэтгүүл зүйд. Сэтгүүлч, сэтгүүл зүйн багш нарт зориулсан гарын авлага”-д багтсан агуулгыг практик хэрэглээнд ойртуулах, бодит жишээнд суурилахад дээрх нийтлэлүүд ихээхэн тус дөхөм болсон юм. Энэхүү гарын авлага нь Узбекистан, Орос, Каракалпак, Англи дөрвөн хэлээр хэвлэгдсэн нь Узбекистаны үндэсний өвөрмөц нөхцөл байдлыг харгалзан үзэхийн зэрэгцээ энэхүү хэрэглүүрийн олон улсын ач холбогдол, хэрэглээг хангах зорилгод нийцэж байгаа юм. Гарын авлагын агуулга нь практик асуудлуудыг хамарч, бие даан суралцахад зориулагдсан, мөн олон тооны түлхүүр үг, практик дасгал, жишээ багтаасан болно.

Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд зориулан боловсруулсан ихэнх хэрэгсэл, гарын авлагад хэвлэл мэдээллийн агуулгын чанарыг хэрхэн сайжруулах асуудалд анхаарал хандуулсан байдаг. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллээс гарч буй бүтээгдэхүүн, нийлүүлэлтийн асуудлыг хөнддөг. Энэхүү гарын авлага нь хэвлэл мэдээллийн салбарынханд мэдээллийн эрэлт хэрэгцээ, хэрэглээнд илүү идэвхтэй анхаарахыг санал болгож буй юм. Өөрөөр хэлбэл, мэдээлэл хүлээн авагч талын хүрээг өөр өнцгөөс судлах, өөрөөр хэлбэл иргэд болон тэдний хэвлэл мэдээлэл хүлээн авах, мэдээллийн харилцаанд оролцох үйл ажиллагааг судлах гэсэн үг юм. Мэдээллийн хэрэгслийн чиг үүрэг, мөн эдгээр чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлийн талаарх мэдлэг, ойлголтыг мэргэжилтнүүд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын гурван өргөн хүрээний чадавхаар хэмжиж байна.³ Номын сангууд он жилийн туршид мэдээллийн суурь боловсролыг тууштай түгээн сурталчилж ирсэн. Харин хэвлэл мэдээллийн түүхэнд ХММСБ-ын чадавхыг дэмжих тогтвортой дотоод бодлого, хөтөлбөрүүд хэзээ ч байгаагүй. Европ

2 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000265552>. 2019 оны 7-р сарын 20-нд хандсан. Шерилин Айретон, Жули Позетти нар олон зохиогчийн бүтээлээс багтаасан энэхүү эх сурвалжийг засварласан.

3 Grizzle, A. (2018). Assessing Citizens' Responses to Media and Information Literacy Competencies through an online course: An Empirical Study and Critical Comparative Analysis of Experts' Views. Doctoral Dissertation. ISBN: 9788449084775: <http://hdl.handle.net/10803/666860>. Tesis Doctorals en Xarxa (TDX). Autonomous University of Barcelona, Spain.

болон Хойд Америкийн зарим үндэсний өргөн нэвтрүүлэгчид богино хугацааны туршилт, төслүүдийг хэрэгжүүлж байсан. Эдгээрээс ВВС-ийн хэвлэл мэдээллийн суурь боловсролын тухай цувралыг онцлон тэмдэглүүштэй. Мөн Дэлхийн Сонины Холбооноос сургуулиудад мэдээний тухай суурь мэдлэг олгох хөтөлбөрийг бизнесийн загвар болгон тогтмолжуулж байсан бөгөөд сонин уншигчдын тоо буурсантай холбоотойгоор хөтөлбөрөө дуусгавар болгожээ. ХММСБ өнөөгийн сэтгүүл зүйд онцгой хэрэгцээтэй байгаа олон шалтгаан бий ч, гол гурван шалтгааныг дурдвал: (1) хэвлэл мэдээллийн хэрэгслийг ташаа/худал мэдээлэл түгээх платформ болгон ашиглах болсон, тиймээс мэдээний хэрэглэгчид үнэн худлыг ялгах чадвартай байх хэрэгцээ үүссэн; (2) мэдээллийн хэрэгслийг буруу ташаа мэдээлэл түгээх, үзэн ядалт, хэт туйлшралд ашиглаж байна; (3) олон оронд мэдээллийн хэрэгсэлд үл итгэх байдал нэмэгдэж байна.⁴

Үүнээс гадна, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүл зүйн боловсролын байгууллагаас бүх нийтийн ХММСБ-ыг хөгжүүлэх явдлыг дэмжих, чиглүүлэх олон улсын арга хэрэгсэл одоогоор гараагүй байна. Энэхүү гарын авлага нь энэ цоорхойг нөхөхөд нэмэр болох зорилготой юм. Европын Комиссоос Европ дахь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулан олон нийтийн мэдээний суурь мэдлэгийг хэрхэн дээшлүүлэх тухай гарын авлага боловсруулах төлөвлөгөөтэй бөгөөд одоо байгаа гарын авлага нь Хойд Америкийн нөхцөлд зориулагдсан хэмээн тайлбарлажээ. “ХММСБ сэтгүүл зүйд” хэмээх энэхүү гарын авлагыг ЮНЕСКО-гийн иж бүрэн, чөлөөтэй хэрэглэж болох уламжлалт зарчимд тулгуурлан бүтээсэн бөгөөд гишүүн орнууд дэлхийн өнцөг булан бүрд өөрийн нөхцөлд тохируулан хэрэглэх боломжтой. Энэ гарын авлагад дан ганц хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төдийгүй сэтгүүл зүйн боловсролд анхаарал хандуулсны зэрэгцээ ХММСБ-ын талаар тогтвортой дотоод бодлого, хөтөлбөр боловсруулахын тулд хэвлэл мэдээлэл болон номын сангуудын хооронд гүүр босгох тухай зэрэг сэдвийг хөндсөн. Нэг талаар энэхүү гарын авлага нь ХММСБ болон хэрэглэгчийн үүсгэсэн агуулгыг сурталчлах зорилгоор ЮНЕСКО-оос 2008 онд хэвлэсэн өргөн нэвтрүүлэгчдэд зориулсан гарын авлагын шинэчилсэн хувилбар юм. Гэхдээ мэдээлэл, харилцаа холбооны шинэ орчин нөхцөлд харгалзуулан олон өнцөг, агуулгыг шинээр багтаасан юм.

Энэхүү гарын авлагыг хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүл зүйн багш, номын сан, мэдээллийн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулсан болно. Эдгээр талуудын оролцоо нь гарын авлагыг байгууллагын түвшинд тогтвортой ашиглах хандлагыг баталгаажуулах зорилготой.

Түүнчлэн энэхүү гарын авлага сэтгүүл зүйн багш, сэтгүүлчдийг практик удирдамж, материалаар хангахад чиглэсэн. Үүнд 1) иргэний эрх мэдэл, оролцоог дорвитой хангах зорилго бүхий хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын тухай, 2) ХММСБ-ыг сэтгүүл зүйн сургалтад хэрхэн нэгтгэх, 3) хэвлэл мэдээлэл болон иргэд/хэрэглэгчийн хооронд яриа хэлэлцээг хэрхэн идэвхжүүлж мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бий болгох тухай агуулгыг дурдаж болно.

Эдгээр арга барилыг ашиглаж, тодорхой өнцөг, сэдэвт анхаарал

4 UNESCO Word Trends on Freedom of Expression and Media Development 2017/2018

хандуулснаар хэвлэл мэдээллийн салбарт чанартай, шударга контент боловсруулахад туслахуйц гарын авлага үгүйлэгдэж буйг нөхөх зорилго тавьсан болно. Уг гарын авлагад ХММСБ-ын талаарх ЮНЕСКО-гийн нийлмэл үзэл баримтлалыг ашигласан. Энэхүү үзэл баримтлал нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад болон хэрэглэгчид мэдээллийг нягтлах ажлыг хэрхэн хамтран шийдвэрлэх талаар авч үздэг. Мөн орчин үед мэдээллийн хэрэгслийн ихэнх нь цахим орон зайд оршиж буй, дижитал орон зайд биет орон зай хэрэгтэй байдгийн адилаар биет орон зайд дижитал орон зай хэрэгтэй бодит байдал, мөн нийгэм дэх мэдээллийн соёлын орчин нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, технологийн орон зайн хөгжилд нөлөөлдөг зэргийг харгалзан үздэг юм. Гарын авлагын зохиогчдын нэг нь судлаачийн хувьд дараах асуудлыг онцлон дэвшүүлсэн байдаг: “Узбекистан дахь цахим мэдээллийн хэрэгслийн хөгжил нь олон үндэстний мэдээллийн шинэ орон зай бүрэлдэн бий болох урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж байна. Үүнтэй зэрэгцээд, ерөнхий боловсролын агуулгад аль хэдийн тусгагдсан байх шаардлагатай хүн амын мэдээллийн соёлын асуудал онцгой ач холбогдолтой болж байна. Нийгэм, нийгмийн бүлэг, хувь хүмүүст үзүүлэх Интернэтийн нөлөө улам бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор хүн амын хэвлэл мэдээллийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх асуудлыг тавих шаардлага үүсээд байна.”⁵


ХММСБ-ын ерөнхий үзэл баримтлал, сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжтай ажиллах зарчимд үндэслэн энэхүү гарын авлагад баримт шалгах үйл ажиллагааг мөн тусгасан. Тухайлбал, хэрэглэгчид баримтын үнэн зөв эсэхийг шалгах, баримт шалгалтын хамгийн тохиромжтой хэлбэрийг сонгох, баримтыг харьцуулах, шалгахад нээлттэй өгөгдлийг ашиглах боломж олгож зохих хэрэглүүрийн талаар танилцууллаа.

Гарын авлагад мөн «ташаа мэдээлэл» болон “худал мэдээлэл”-ийн талаарх ойлголтыг сайжруулах, энэ тухай мэдээлэхэд туслах шилдэг туршлага, дасгал, унших материал, даалгавар зэргийг багтаав. Гарын авлагыг сэтгүүлч, сэтгүүл зүйн сургагч, багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрт нэмэлт материал болгон ашиглаж болохуйц байдлаар бүтээсэн, мөн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн сургуулиудад ч ашиглах зориулалттай юм. Мөн энд цуглуулсан онол, практикийн материал нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдад дүн шинжилгээ бүхий материал бичих, эрэн сурвалжлах сэтгүүл зүйд ашиглах зэрэгт хэрэг болно.

Гарын авлагад багтаасан хянах хуудас, зураглалыг сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлага, ерөнхий редактор, блог хөтлөгчид, нийгмийн идэвхтэн, хэвлэл мэдээллийн ажилтнууд, эрдэм шинжилгээний хүрээлэн болон боловсролын байгууллагын мэргэжилтнүүд, нийгмийн сүлжээний идэвхтэй хэрэглэгчид бие даан суралцахад ашиглаж болно.

Түүнчлэн, бид энэхүү гарын авлага нь мэдээлэл харилцааны судлаач, хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын сургагч багш нарт үнэ цэнтэй эх сурвалж болно гэж найдаж байна.

⁵ Julie Posetti, Alice Matthews. A Short Guide to the History of 'Misinformation and disinformation' and Disinformation. <https://www.icfj.org/information-market/>. / Abstract of Diss. NUUz, 2011. The online version is available at: <http://site.ziyounet.uz/ru/>



І ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ
МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН
НҮДЭЭР

1.1 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Дэлхийн улс орнууд болон хөгжлийн байгууллагууд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөөр байна. ХММСБ-ыг чухалчлах болсон нь дэлхий даяарх худал мэдээллийн тэсрэлтэд үзүүлж буй тогтвортой бөгөөд үр дүнтэй хариу үйлдэл юм. Худал мэдээлэл тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ), ардчилал, сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд аюул заналхийлэл учруулж байна. Худал мэдээлэл баримт болон өгөгдлийн талаар зөрчилдөөн үүсгэж, нөлөө бүхий үзэл бодол, баримтын хоорондох зааг ялгааг бүдгэрүүлэхийн зэрэгцээ баримтын нэр хүндтэй эх сурвалжид хүртэл итгэх итгэлийг алдагдуулж байна.⁶ ХММСБ нь хүмүүст мэдээлэлтэй байх, оролцох, шийдвэр гаргахдаа шүүмжлэлтэй сэтгэх боломжийг олгодог. ХММСБ-ын эрэлт хэрэгцээ, ач холбогдол дэлхий даяар өсөж буй цаг үед ЮНЕСКО-гоос ХММСБ-ын хөгжлийг манлайлж буй олон улсын байгууллагын хувьд стратегийн шинжтэй шинэлэг арга хэмжээ авсаар ирсэн. Гэвч хэвлэл мэдээлэл, технологийн зуучлагчид болон бусад мэдээлэл нийлүүлэгчидтэй өргөн цар хүрээтэй, тогтвортой хамтын ажиллагаа одоог хүртэл хэрэгжээгүй, эсвэл энэ талаар дорвитой арга хэмжээ үгүйлэгдсээр байна.⁷

16 Худал мэдээлэл мэтийн нийгмийн сорилтуудаас гадна ЮНЕСКО соёл хоорондын яриа хэлэлцээ, жендерийн тэгш байдал, энх тайван, хүний эрх, шинжлэх ухаан/өгөгдлийн суурь мэдлэг, тогтвортой хөгжил гэх зэрэг нийгмийн хөгжлийн боломжийг нэмэгдүүлэхийн төлөө ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлэх дэлхийн чиг хандлагыг манлайлж байна.⁸ Хэвлэл мэдээлэл, технологийн зуучлагчид болон хөгжлийн бусад түншүүд ТХЗ-д хүрэхэд зайлшгүй шаардлагатай, салбар дундын арга барилаас илүү гүнзгий, салбар дамнасан хөгжлийн арга барилд шилжих хөтөлбөрийг нэг чухал хөшүүрэг бол ХММСБ хэмээн үзэж байна.⁹

Мэдээлэл, технологи, хэвлэл мэдээллийн хүртээмжийн асуудлыг ТХЗ-ын 16 дугаарт буюу “Энхтайван, шударга ёс, хүчтэй институт”-ийг хөгжүүлэх зорилтод тусгасан.¹⁰ Зорилго 16.10-т мэдээлэл олж авах гэх мэт хүний язгуур эрх чөлөөг хангах оролцоонд уриалсан. Мэргэжлийн болон олон улсын стандартад суурилсан ёс зүйтэй сэтгүүл зүйд¹¹ ХММСБ-той ижил төстэй зүйл их бий. Доор 1-р хүснэгтэд жишээ үзүүлэв. Чанартай сэтгүүл зүйг ХММСБ-той

6 A Threat to Policymaking and Democracy. Rand Cooperation. RB10002-RC (2018). www.rand.org. Accessed on 27 July, 2019.

7 Grizzle, A. (2018). Assessing Citizens' Responses to Media and Information Literacy Competencies through an Online Course: An Empirical Study and Critical Comparative Analysis of Experts' Views. Doctoral Dissertation. ISBN: 9788449084775: <http://hdl.handle.net/10803/666860>. Tesis Doctorals en Xarxa (TDX). Autonomus University of Barcelona, Spain.

8 Grizzle, A. (2014). Measuring Media and Information Literacy: Implications for the Sustainable Development Goal. In Singh, J., Grizzle, A., et al (2015). Media and Information Literacy for the Sustainable Development Goals. International Clearinghouse on Children, Youth and Media, NORDICOM, University of Gothenburg, Sweden.

9 Өмнөхийн адил, 6-р зүүлт хэсэг

10 World Trends in Freedom of Expression and Media Development, Global Report 2017/2018. UNESCO (Paris). <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000261065>. Accessed on 22 July 2019.

11 White, A. (2008). To Tell You The Truth. The Ethical Journalism Initiative. Brussels, Belgium: International Federation of Journalists.

хослуулах нь илүү шударга, нээлттэй, хүртээмжтэй нийгмийг бий болгоход чухал юм. Ингэж чадсан нөхцөлд ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд ахиц гарна.

Хүснэгт 1. Сэтгүүл зүй ба ХММСБ-ын үндсэн зарчмын хамаарал

Сэтгүүл зүйн үндсэн зарчим ¹²	ХММСБ -ын үндсэн зарчим
1. Үнэнийг мэдээлэх нь сэтгүүл зүйн тэргүүн үүрэг юм.	1. Үнэнийг эрэлхийлэх үйл явцад үр дүнтэй оролцох боломжийг олгоно.
2. Иргэдийн эрх ашигт үнэнч байна.	2. Иргэдийг чадавхжуулахад гол анхаарлыг хандуулна.
3. Сэтгүүл зүйн мөн чанар нь нягтлан шалгах сахилга бат юм.	3. ХММСБ нь хувь хүний нягтлан шалгах дадлыг хөгжүүлнэ.
4. Сэтгүүлчид сурвалжилж буй эх сурвалжаас хамааралгүй, хараат бус байх ёстой.	4. ХММСБ нь хүнд юу бодох, хэрхэн бодохыг заах бус, аливааг эргэцүүлэн бодох дадалд сургах тухай юм.
5. Эрх мэдлийг хараат бусаар хянах үүргийг гүйцэтгэнэ.	5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь 4 дэх засаглал бол ХММСБ 5 дах засаглалыг (иргэдийн) бий болгодог.
6. Олон нийтийн шүүмжлэл, зөвшилцлийн талбарыг хангана.	6. ХММСБ нь олон нийтийн яриа, хэлэлцүүлэгт оролцох боломжийг олгодог.
7. Чухал ач холбогдолтой зүйлийг сонирхолтой бөгөөд хамааралтай болгоно.	7. ХММСБ хүний сониуч зан, технологийн эрэл хайгуулыг идэвхжүүлж, мэдээлэл, хэвлэл мэдээлэл яагаад хамаатай бөгөөд чухал болохыг ойлгуулдаг.
8. Бүрэн дүүрэн, тэнцвэртэй мэдээлнэ.	8. ХММСБ нь мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон төрөл байдгийг ойлгуулна.
9. Сэтгүүлчид хувийн мөс чанараа илэрхийлж болно.	9. ХММСБ нь хүн бүрд заяагдсан ухамсар, хүн чанарыг дэмждэг.

Эх сурвалж: Grizzle, A. (2018), Нийтлэгдээгүй бүтээл.

¹² White, A. (2008). To Tell You The Truth. The Ethical Journalism Initiative. Brussels, Belgium: International Federation of Journalists

ХММСБ-ын бусад зарчим

- 1) ХММСБ нь олон салбарыг дамнан хамарч буйгаараа онцлог юм.
- 2) Хэвлэл мэдээлэл ба мэдээллийн салбарын аль алиныг нь хамарна.
- 3) Хүний эрхийн асуудалд төвлөрнө.
- 4) Шүүн тунгаах сэтгэхүйг үндсэн чадавх хэмээн үзнэ.
- 5) Соёл хоорондын яриа хэлэлцээнд анхаарал хандуулна.
- 6) Бүх хүйсийн баримжаа, бүх насны хүмүүст хүртээмжтэй байх ёстой.
- 7) Онлайн болон офлайн орчны аль алинд нь түгэн дэлгэрэх ёстой.
- 8) Оролцогч талууд нь тогтвортой хөгжлийн арга зүйг баримтлах ёстой.

ХММСБ-ын үзэл баримтлал нь хүний нийтлэг эрхэд суурилдаг. Хувь хүн, олон нийт, бүхэл бүтэн улс үндэстэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхээ эдлэхийн тулд хангагдах ёстой үндсэн нөхцөл нь ХММСБ юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана”¹³ хэмээн заасан байдаг.

Энэ зарчмын үүднээс бүх улс оронд хүний үндсэн эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, иргэд ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйлд үр дүнтэй оролцох боломжийг бий олгоход ХММСБ чухал ач холбогдолтой хэмээн ЮНЕСКО үзэж байна.

ЮНЕСКО-оос ХММСБ-ын талаар хэвлүүлсэн бүтээлүүдэд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролтой иргэд бүх хэлбэрийн мэдээллийг хүлээн авах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах, шүүмжлэлтэйгээр үнэлж цэгнэх, агуулга бүтээх, ашиглах, түгээх чадвартай байдгийг онцолж байна.¹⁴ Тэд мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллах тал дээр өөрсдийн эрхийг ойлгож, мэддэг, түүнчлэн үнэ төлбөргүй, хараат бус, олон талт чанартай мэдээлэл, хэвлэл мэдээллийн тогтолцоог шаардах эрхтэйгээ ч бас мэддэг. Хэвлэл мэдээлэлтэй харилцахдаа тэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг хариуцлага, тэрхүү үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг ойлгодог. Тэд мэдээлэл солилцож, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцдог бөгөөд, үүнд «мэдээллийн хүртээмж, ашиглалтыг тойрсон ёс зүйн асуудлыг ойлгох, мөн тэгш байдал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдал, соёл хоорондын болон шашин хоорондын яриа хэлэлцээ, энх тайвныг сурталчлах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, МХХТ-ийг ашиглах»¹⁵ чадамж ч хамаарна.

13 НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 19-р зүйл (1948). <http://www.un.org/en/documents/udhr/index.shtml>

14 Media and Information Literacy in Knowledge Societies / Author Kuzmin E.I., Parshakova A. V. – М.: МЦБС, 2013. p. 29.

15 Grizzle, A, Moore, P. et al (2013). Media and Information Literacy Policy and Strategy Guidelines. UNESCO, Paris. ЮНЕСКО-гийн бусад хэвлэлийг дараах холбоосоор хүлээн авна уу. <http://www.unesco.org/new/en/communication-and-information/media-development/media-literacy/publications/>

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын хүрээнд эзэмшсэн байвал зохих чадварыг үндсэн таван хэсэгт хувааж болно:

- Мэдээлэл хайх, олж авах
- Дүн шинжилгээ хийх, ойлгох
- Шүүмжлэлтэйгээр үнэлж цэгнэх
- Хэрэглэх
- Бүтээх, оролцох


Эдгээр таван үндсэн хэсэг нь сэтгүүл зүйн үндсэн 5W ба 1H-тэй холбоотой буюу юу, хэн, хэзээ, хаана, яагаад, яаж гэсэн асуулттай дүйцэх юм.

Зарим судлаач дараах асуултаар ХММСБ-ын үндсэн асуудлуудыг тодорхойлдог: мэдээлэл эсвэл агуулгыг хэн бүтээсэн бэ? Зорилго нь юу вэ? Зорилтот хэрэглэгч нь хэн бэ? Гол санаа нь юу вэ? Ямар мэдээллийг багтаасан, ямрыг хассан байна? Мэдээлэл хэнд ашигтай вэ? Хэнд ашиггүй вэ?

Түүнчлэн мэдээний (news) суурь мэдлэг хэмээх ойлголтод гол анхаарлыг хандуулдаг судлаачид цөөнгүй бий (Зураг 1-д харуулсан). ХММСБ-ыг ойлгохын тулд эхлээд суурь боловсрол гэсэн түлхүүр үгийг авч үзэх хэрэгтэй.

Суурь боловсролын ойлголтыг тодотгосон, энд нэмж болохоор өөр ямар нэр үг байж болох вэ, та юу гэж бодож байна?

Зураг 1. Мэдээний суурь боловсролын тухай ойлголт



Эдгээр ойлголтууд зургийн төвд байгаа «суурь боловсрол» хэмээх түлхүүр үгтэй холбогдон тодорч байна. Урьдын цагт суурь боловсролын талаарх үзэл баримтлалд хувь хүний боловсролыг (бичгийн соёл, аман ярианы чадавх, сэтгэлгээний болон үзэл бодлын цар хүрээ) голчилдог байв. Эдүгээ суурь боловсролын тухай ойлголт нь мэдээлэл, хэвлэл мэдээлэл, дижитал хэвлэл мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа гэх зэргээр хүний үйл ажиллагааны олон салбарыг хамарч байна. Өөрөөр хэлбэл суурь боловсролын тухай ойлголт өргөжин тэлсэн. Зарим мэргэжилтэн суурь боловсролын тухай ярихдаа олон төрлийн суурь мэдлэгийг (multiliteracy) хамруулан ярих болжээ.¹⁶

Суурь боловсрол бол ХММСБ-д хамаарах гол ойлголтуудын нэг юм. Үүнийг Зураг 2-т үзүүлсэнчлэн, мэдлэгийн олон төрөл зүйлтэй харилцан уялдаатай, нэгдмэл ойлголт хэмээн үзэх нь зүйтэй.

Зураг 2. Суурь боловсролын онцлог шинж чанарууд



Эх сурвалж: ЮНЕСКО-гийн “Багш нарт зориулсан хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол олгох сургалтын хөтөлбөр”-өөс.

Зураг дээрх ангилал бүр нь өөрийн гэсэн ялгаа, өөр өөрийн онцлог утга агуулгатай бөгөөд бусад төрөл зүйлийг нөхөж тодотгосон, давхардсан шинж чанартай байх нь цөөнгүй тохиолддог. Жишээлбэл, компьютерын суурь мэдлэг гэж компьютер ашиглах чадварыг хэлнэ. Тэгвэл мэдээллийн технологийн үндэс, дуу дүрсний болон дүрсний суурь мэдлэгт дуу дүрсийг орон зай, цаг хугацаанд шинжлэх, нэгтгэх чадварыг илэрхийлнэ. Энэ нь дуу дүрс бүхий мэдээллийн хэрэгслийн текст «унших» нэг төрлийн чадвар, дуу дүрсний техник төхөөрөмжийг ашиглах чадвар болон дуу дүрсний соёлын үндсэн мэдлэг бөгөөд эдгээр нь нийлээд хэвлэл мэдээллийн чадавхын нэг бүрэлдэхүүн хэсэг болж буй юм. Зарим мэргэжилтэн мэдээллийн суурь мэдлэг хэмээх ойлголтод дээрх бүх ойлголт ерөнхийдөө багтдаг хэмээн үздэг. Өөрөөр хэлбэл мэдээллийн суурь мэдлэг бол бүх төрлийн мэдээлэлтэй танилцах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх чадвар мөн гэж үздэг аж. Өөр судлаачид болохоор хэвлэл мэдээллийн суурь мэдлэг бол дээр дурдсан бүх зүйлээс ялгаатай бөгөөд хэвлэл мэдээллийн бодит байдалд дүн шинжилгээ хийх, нэгтгэх чадвар, хэвлэл мэдээллийн текстийг ашиглах, ойлгох, хэвлэл мэдээллийн соёлын үндсэн мэдлэгийг хэлнэ гэж маргадаг. Аль ч тохиолдолд өнөөгийн дижитал орчинд суурь боловсролын харилцан уялдаатай талууд ойртон нэгдэж байна.

Хэвлэл мэдээллийн суурь мэдлэг ба мэдээллийн суурь мэдлэг нь цахим технологийн нөлөөлөлтэй нягт холбоотой. Өмнө нь Интернэтийн хэрэглээ


ердөө л сайтаас сайт хэсэх, чатлах зэргээр хязгаарлагдаж байсан. Тэгвэл одоо цагт цахим орчинд мэдээлэл солилцох нь өдөрт тутмын ердийн хэрэглээ болж, ухаалаг утас ертөнцийг харах онцгой нэгэн цонх болжээ. Ухаалаг утас хэрэглэж буй хэн бүхэн өнөөдөр мэдээллийн идэвхтэй хэрэглэгч, түгээгч, бүтээгч болсон. Цахим хөгжлийн үйл яцад явцад “просьюмер”-ууд бий болж, улам бүр олширч байгаа тухай 1980 онд Элвин Тоффлер бичжээ. Энэхүү нэр томъёог продюсер (producer) буюу мэдээлэл үйлдвэрлэгч, консьюмер (consumer) буюу мэдээлэл хэрэглэгч хэмээх хоёр үгний нийлбэрээр бий болгосон бөгөөд контент бэлтгэх болон хэрэглэх үйл явцын аль алинд оролцдог шинэ төрлийн оролцогч тал бий болсныг илэрхийлсэн аж.

Мэдээллийн шинэ бодит байдал, өндөр ачаалалтай хэвлэл мэдээллийн ертөнцөд шинэ мэдээллийн хэрэгслийн (цахим болон хөдөлгөөнт мэдээллийн хэрэгсэл, нийгмийн мэдээллийн сүлжээ гэх мэт) хэрэглэгч нь сүлжээний ур чадвар, эвлүүлэх, хуваалцах, татаж авах, контент болон мультимедиа үүсгэх, түгээх, зөв ашиглах чадвартай байх шаардлагатай болоод байна. Тийм ч учраас хэвлэл мэдээллийн шинэ орчин нөхцөлийг (медиа экосистем) тодорхойлсон дижитал суурь мэдлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслийн суурь мэдлэг, мультимедиа суурь мэдлэг гэх зэрэг шинэ ойлголтууд гарч ирсэн юм.

Өнөөдөр их хэмжээний мэдээллийн сүлжээний (hypertextuality) тухай ойлголт нь зөвхөн тоон мэдээлэлд төдийгүй сүлжээний хэрэглэгчдэд ч хамаатай. Сүлжээ гэдэг нь амьд болон амьгүй бүх зүйлийг тоон технологиор холбох зарчим болохын зэрэгцээ хүн ба машин, машин ба программ, робот болон бусад тоног төхөөрөмжийн хоорондох харилцаа холбооны нэг хэлбэрийг илэрхийлдэг. Эдгээр шинэ тутам хөгжилтэй холбоотой шинээр үүсэж буй чадавхыг судлаачид доорх байдлаар тодорхойлжээ (Зураг 3):¹⁷

21

Зураг 3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролтой холбоотой шинэ чадавхууд



Хэвлэл мэдээллийн суурь мэдлэгийн талаар судлаачид “шаардлагатай ур чадварын хүрээ өргөжсөөр байна... их өгөгдөл, хувийн мэдээллийн нууцлал, Интернэтэд ашигладаг алгоритмын талаарх мэдлэг, Интернэт орчин дахь мэдээллийн харилцаанд оролцох, эсэх оролцохын тэнцвэрийг барих

17 Rayimjanov R.Z. Requirements for Media Competencies in New Media Enviroment. Media, Human, Society in Asia. Korea & Uzbekistan. Seoul, South Korea, April 21–26, 2019. — P. 119–124.

чадвар нь шинэ медиа боловсролын суурь бүрэлдэхүүн хэсэг юм»¹⁸ хэмээн онцолжээ. Ганц жишээ дурдахад, хэн нэг нь “онлайн” эсвэл “офлайн” горимд буйг илэрхийлэх тэмдэглэгээ өнөөдөр хүн хоорондын харилцааны чухал хэрэглүүр болсон бөгөөд, хүнтэй харилцах, мэдээлэл солилцоход энэхүү горимыг мэдэх, тохируулах чадвар хэрэгтэй болжээ.

ХММСБ-той холбоотой өөр нэг чухал ойлголт бол netiquette буюу Интернэтийн ёс журам (дигитал ёс журам – digital etiquette) юм. Энэ бол Интернэт хэрэглэгчдийн баримтлах соёлтой харилцааны дүрэм юм. Дигитал ёс журмыг дагаж мөрдөх нь мэдээлэл, харилцааны шинэ орчинд хэвлэл мэдээллийн хэрэгслийг чадварлаг ашиглахад тавигддаг заавал биелүүлэх шаардлага болоод байна.

1.2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Хүмүүсийг мэдлэгт суурилсан нийгэмд амьдрахад бэлтгэх асуудал олон улсын хамтын нийгэмлэг, ялангуяа олон улсын байгууллагуудын санааг зовоосон асуудал байсаар ирсэн. ЮНЕСКО нь хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг сурталчлах ажлыг “хүртээмжтэй, нээлттэй, оролцоотой, олон ургалч мэдлэгийн нийгмийг бий болгох урьдчилсан нөхцөл” гэж үздэг.¹⁹

Мэдээллээр баялаг нийгэмд, мэдээллийн урсгал хязгааргүй болсон цаг үед асуудалд бодитоор хандах сэтгүүлчдийн чадвар, тэдний иргэний боловсролын түвшин, хэрэглэгчдэд ХММСБ-ыг сурталчлахад оролцож буй байдал зэрэг нь тулгамдсан асуудал болоод байна.

Сэтгүүлч, редакторууд баримт шалгах шинэ, баталгаатай, үр дүнтэй арга зүй болон худал, ташаа мэдээллийг таньж илрүүлэх, нягтлан шалгах ур чадвараа байнга дээшлүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр. Үүний зэрэгцээ сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагууд хуурамч мэдээллийн эсрэг хамтран ажиллаж, иргэдийн ХМССБ-ыг дээшлүүлэх нь онцгой чухал болоод байна.

Грюнвальдын тунхаглалд ЮНЕСКО “сонсогч, үзэгч, уншигчдын шүүмжлэлтэй сэтгэлгээг хөгжүүлэхэд эцэг эх, сурган хүмүүжүүлэгч, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон шийдвэр гаргагчид өөрсдийн үүрэг оролцоог ухамсарласан тохиолдолд хэвлэл мэдээллийн боловсрол хамгийн үр дүнтэй байх болно. Боловсрол, хэвлэл мэдээллийн тогтолцоо, харилцаа холбооны хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх нь боловсролын үр ашгийг дээшлүүлэхэд чухал алхам болох нь дамжиггүй”²⁰ хэмээн онцолсон байдаг.

21-р зууны эхний арван жилд ЮНЕСКО хэвлэл мэдээллийн суурь мэдлэг болон мэдээллийн суурь мэдлэгийн үзэл баримтлалыг хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол болгон нэгтгэх онолын үндэслэлийг гаргасан. **Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол нь мэдээлэл, хэвлэл**

18 Media and Information Literacy in Knowledge Societies / Author: Kuzmin E.I., Parshakova A. V. — М.: МЦБС, 2013. P. 29.

19 Media and Information Literacy in Knowledge Societies / Author: Kuzmin E.I., Parshakova A. V. — М.: МЦБС, 2013. P. 29.

20 Media and Information Literacy in Knowledge Societies.

мэдээллийн хэрэгсэл, технологийн чадавхыг хамардаг.²¹ Энэ санаа нь олон улсын цөөнгүй тунхаглал, зөвлөмжид тусгагдсан байдгаас заримыг доор жагсаав:

- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх Фесийн тунхаглал (2011, Марокко)
- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх Олон улсын номын сангийн холбооны (IFLA) зөвлөмж (2011, Гааг, Нидерланд; 2012, Орос).
- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх Түншлэлийн Дэлхийн Холбооны үзэл баримтлалын хүрээ ба үйл ажиллагааны төлөвлөгөө [GAPMIL] (2013, Нигери)
- Дижитал эрин дэх хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын тухай Парисын тунхаглал (2014, Франц),
- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн орчин дахь шилжилтийн үеийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх Ригагийн зөвлөмж (2016, Латви)
- Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх залуучуудын тунхаглал (2016, Бразил)
- “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол нээлттэй засгийн газрын соёлыг төлөвшүүлэхэд” Ханты-Мансийскийн тунхаглал (2016, Орос), ХММСБ-ын хотуудын үзэл баримтлалын дэлхийн хүрээ (2018, Орос).

Эдгээр баримт бичгийг дэлхийн өнцөг булан бүрийн оролцогч талууд хамтран хэлэлцэж баталсан. Тийм ч учраас энэ асуудлыг олон улсын хамтын нийгэмлэг боловсрол, судалгаа шинжилгээний салбарт болон засгийн газрын түвшинд хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, ХММСБ-ын хөгжлийг урагшлуулах тогтвортой механизмыг олоход хүчин чармайлтаа нэгтгэхийн чухлыг онцолсоор ирсэн.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээлэл үйлдвэрлэгчийн хийх ёстой ажлын нэг чухал хэсэг бол хэрэглэгчдийг бодит болон ташаа, худал мэдээллийг ялгаж чаддаг болгох явдал. Орчин үеийн сэтгүүлчид өөрсдөө худал ташаа мэдээллийг олж тогтоох, баримтыг тодруулах, шалгах, үнэн зөвийг тогтоох арга хэрэгслийг ашиглах чадавхтай болоод зогсохгүй иргэдэд ч мөн эдгээр асуудалд туслах чадвартай байх ёстой юм.

Урьдын үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэлхий ертөнцийг харуулж өгдөг байсан. Тэгвэл өнөөдөр мэдээллийг хүлээн авагч хэн бүхэн хэмжээ хязгааргүй олон сэдвээр мэдээлэл бүтээгч болон түгээгч болсон учир хэлэлцэх ярилцах сэдэв хаанаас ч хамаагүй урган гарах боломжтой болоод байна. Тийм ч учраас орчин үеийн сэтгүүлчид мэдээ цуглуулах, бэлтгэх, түгээх үүрэг оролцоогоо эргэн нэг бодох цаг болсон.

21 See Grizzle, A. (2018).

1.3 ЮНЕСКО-ГИЙН ХММСБ-ЫН ТАВАН ДҮРЭМ

ХММСБ-ын эдгээр таван хууль бол үндсэндээ ЮНЕСКО-ийн хүсэлтээр Элтон Гриззл, Жагтар Сингх нарын тодорхойлсон зарчмууд юм.²²

ХММСБ-ын таван хуулийн товч тайлбарыг доор толилуулав. Илүү дэлгэрэнгүй тайлбарыг Grizzle, A. (2018)²³-д үзнэ үү.

Дүрэм 1. *Мэдээлэл, харилцаа холбоо, номын сан, хэвлэл мэдээлэл, технологи, Интернэтийг нийгэм шүүмжлэлтэй хандлагаар ашиглах ёстой. Эдгээр эх сурвалжийн статус ижил бөгөөд аль нь ч бусдаасаа илүү ач холбогдолтой гэж үзэж болохгүй.*

Энд бид «шүүмжлэлт хандлага» буюу сэтгэлгээ ба «статус ижил» гэсэн хоёр түлхүүр үгэнд анхаарал хандуулахыг хүсэж байна. Нэгдүгээр зарчим нь мэдээллийн хэрэглэгч болон бүтээгчид нэгэн адилаар хүлээн авсан мэдээлэлдээ шүүн тунгаах зарчмаар хандах нь ямар чухал болохыг илэрхийлж байна. Хүн хүлээн авч буй аливаа агуулгыг задлан шинжилж үнэлэхдээ хамгийн үнэн зөв, хамгийн шударга мэдээллийг хайж олж мэдэхийг хичээх тухай юм. Бүх мэдээллийн хэрэгслийг эх сурвалжийн хувьд тэгшитгэн үзэж буй нь аль нэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл нөгөөхөөс илүү байх тухай үзэмжээс зайлсхийж, өөр мэдээллийн эх сурвалж хайж мэдээллийг харьцуулахыг хөхиүлэн дэмжих зорилготой юм.

24

Дүрэм 2. *Иргэн бүр мэдээлэл/мэдлэг бүтээгч мөн. Хүн бүр мэдээлэл/мэдлэг олж авах, өөрийгөө илэрхийлэх эрхтэй. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол нь эрэгтэй, эмэгтэй, бүх хүнд хүртээмжтэй байх ёстой бөгөөд хүний эрхтэй нягт холбоотой юм.*

Интернэт болон орчин үеийн хэвлэл мэдээллийн эрин үед хүн бүхэнд мэдээллийн зохиогч, хамтран зохиогч, түгээгч болох боломж бий. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд олон улсын хамтын нийгэмлэг хүн бүрд мэдээллийн хэрэгсэлд хандах тэгш эрхийг хангах арга замыг эрэлхийлж байна. Засгийн газрууд энэ зорилгын төлөө ажиллаж, мэдээлэл солилцох, мэдээлэл хүлээн авах, түгээх эрх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, хувь хүмүүсийн үүрэг, эрх зүйн харилцааг зохицуулах дүрэм журам боловсруулж хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Үүнээс гадна, жендерийн тэгш байдлын тухай хууль боловсруулах, батлах, дагаж мөрдөх нь орчин цагийн заавал биелүүлэх шаардлага болсон юм.

Дүрэм 3. *Мэдээлэл, мэдлэг, харилцаа бүхэн үргэлж төвийг сахисан, хараат бус, шударга байдаггүй. ХММСБ-ын талаар үзэл баримтлал боловсруулж, хэрэглэх, нэвтрүүлэхэд энэхүү илэрхийллийг бүх иргэдэд ил тод, ойлгомжтой болгох нь чухал.*

²² See Grizzle, A. and Singh, J. (2016).

²³ Grizzle, A. (2018). Assessing Citizens' Responses to Media and Information Literacy Competencies through an online course: An Empirical Study and Critical Comparative Analysis of Experts' Views. Doctoral Dissertation. ISBN: 9788449084775: <http://hdl.handle.net/10803/666860>. Tesis Doctorals en Xarxa (TDX). Autonomous University of Barcelona, Spain.

Бид баримтыг сонгож, ангилж эхэлмэгц мэдээлэл, түүний шүүлтүүрт нөлөөлж эхэлдэг. Энэ нь заавал мушгин гуйвуулахтай холбоотой байх албагүй. Харин аливаа агуулгад анхаарал хандуулахдаа бид заримдаа юу голлож, юу нь хоёрдогч болохыг санаатай болон санамсаргүйгээр сонгодог. Энэ нь мөн чанартаа бид ямар ч мэдээллийг хүлээн авах, эсхүл тайлбарлахдаа өөрийн өнцөг, өөрийн хүлээн зөвшөөрч буй байр сууринаас тайлбарлахыг оролддог үйл явц юм. Дээрх хуульд ийм нөхцөл байдал үүсдэг гэдгийг л онцолсон бөгөөд эх сурвалжтай ажиллахдаа, мөн ерөнхийдөө хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээлэл нийлүүлэгчтэй ажиллахдаа ийм зүйл болдгийг анхаарах нь чухал юм.

Дүрэм 4. *Иргэн бүр шинэ мэдээлэл, мэдлэг, мессеж хүлээн авч ойлгох, бусадтай харилцах боломжтой байхыг хүсдэг, гэвч энэ хүслээ тэр бүр илэрхийлдэггүй байж болно. Тэдний эрхийг хэзээ ч зөрчиж болохгүй.*

Энэ зарчмыг бараг бүх улсын хууль тогтоомжид үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг. Гэвч МХХТ хөгжихийн хэрээр технологийн ололт дэвшлийг даган энэ эрх нь улам бүрхэг болсоор байна. Технологийн боломж хүн хоорондын харилцааг өөрчилсөн. Үүнтэй холбоотойгоор, мэдээллийг цахим хэлбэрээр харилцан солилцдог болсон орчин үед буюу тоон шилжилтийн нөхцөлд ч үндсэн хуулиар олгогдсон энэ эрх зөрчигдөхгүй байх нь чухал юм.

Дүрэм 5. *Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг нэг өдрийн дотор эзэмших боломжгүй. Энэ бол байнгын бөгөөд динамик туршлага, суралцах үйл явц юм. Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, технологийн контентын талаарх мэдээллийг ашиглах, бүтээх, дамжуулахтай холбоотой мэдлэг, чадвар, хандлага багтаж байвал бүрэн гүйцэд боллоо гэж үзэж болно.*

Өнөөдөр ХММСБ-ыг хэд хэдэн чадавхын нийлэмж гэж тодорхойлж байна. Эдгээр чадавх нь хүн бүрийн төлөвших явцад аажмаар бүрэлдэн хөгжинө. Судлаачид өнөө үед ХММСБ сургуулийн өмнөх боловсролоос эхлэн хүн бүрд хамаарах болсон тухай онцлон чухалчилдаг. Мэдээлэл хүн бүрийн эргэн тойронд, хаа сайгүй, ямар ч цаг үед байнга байна. Хэрэв айл өрх бүрд байгаа мэдээллийн эх сурвалжийг тоолж үзвэл, ХММСБ-ыг төлөвшүүлэх нь хооллох, хувийн ариун цэврийг сахих гэх мэт хэрэгцээтэй эн зэрэгцэх хүний үндсэн хэрэгцээ мөн гэдэг нь тодорхой болно.

1.4. ХММСБ МЭДЭЭЛЛЭЭС ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ БАЙХААС ХӨГЖЛИЙН ХАМТРАГЧ БОЛОХ ХҮРТЭЛ

Бид энэ хэсгийг гарын авлагын редакторын шог яриагаар эхлүүлж байна. Тэрээр Их Британийн Лестерийн Их Сургуульд олон нийтийн мэдээллийн харилцааны чиглэлээр зайнаас суралцаж байхдаа заавал суух ёстой танхимын семинарт очжээ. Уг сэтгүүл зүйн семинарыг хэвлэл мэдээллийн судалгааны нэр хүндтэй эрдэмтэн, бизнес эрхлэгч багш удирдсан аж. Тэрээр семинарыг дараах үгээр эхлэв:

“Сэтгүүл зүй бол бизнес. Үргэлж бизнес байсан, байх ч болно.”

Энэ бол мэдээж тэр хүний туулсан туршлагаас урган бий болсон бодит байдал байв. Гэхдээ энэхүү ойлголт нь хүн бүрийн бодит байдал мөн үү? Хэвлэл мэдээллийн хэрэгсэл чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөгжилд гүйцэтгэх үндсэн үүрэг хариуцлагаа байх ёстой хэмжээнд нь хадгалж чадаж байна уу? Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмждэг НҮБ-ын тэргүүлэгч агентлагийн хувьд ЮНЕСКО-гийн гүйцэтгэдэг үүрэг, мөн дэлхийн бусад олон байгууллагын үйл ажиллагаа, туршлагаас харахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол том бизнес төдий зүйл биш гэдэг нь илэрхий байна. Ийм санааг дээр дурдсан сэтгүүл зүйн семинар дээр энэхүү гарын авлагын редактор нэрт профессор хэлсэн аж. Өрөөнд байсан гуч орчим оюутны дундаас тэр ганцаараа ийм байр суурьтай байжээ.

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй зарим хүн, хэвлэл мэдээллийн агуулга бол нийгэмд болж зүйлсийн тусгал төдий хэмээн үздэг. Гэхдээ хүн бүр ийнхүү үздэг гэж үү? Мэдээллийг ямар зорилгоор бэлтгэж, түгээснээс шалтгаалж мэдээлэх, соён гэгээрүүлэх, эс бөгөөс нуун далдлах, зөрчил маргаан үүсгэх, төөрөгдүүлэх, хууран мэхлэх зэрэг олон янзын үр дагавартай байж болно. Тиймээс ХММСБ ихэнхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, технологийн зуучлагч болон бусад томоохон бизнес, засгийн газар, мэдээлэл нийлүүлэгчдээс өөрийгөө хэрхэн хамгаалах тухай үзэл баримтлал юм. Нэмж хэлэхэд, ХММСБ гэдэг нь сэтгүүлчид мэдээлэл бэлтгэх, түгээх, хүлээн авах явцад иргэд тэдэнтэй түншлэх боломжтой байх тухай юм. Иргэдийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсрол өндөр байх тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллагууд иргэдийн оролцоог илүү ихээр нэмэгдүүлж хэвлэл мэдээллийн хөгжлөөс хүртэх үр ашгийг дээшлүүлэх боломжтой юм. Эдгээр асуудлыг энэхүү гарын авлагын II, III хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролтой хүн шүүмжлэлт сэтгэлгээ, шүүн тунгаах өндөр чадвартай байдаг.

Шүүн тунгаах сэтгэлгээ нь мэдээлэл, мэдлэгийг ашиглах үйл явцтай холбоотой чадавч юм. Энэ бол дүн шинжилгээ хийх, мэдээллийг харьцуулах, үнэн эсэхэд эргэлзэх, мөн үйл явдал, асуудал, нөхцөл байдлын объект, сэдвийн талаар асуулт асуух чадвар юм. Энэ нь медиа текст буюу мэдээллийг ижил төстэй сэдэв, үйл явдалтай холбож нөхцөл байдлыг бодитой үнэлэх чадвар юм. Хүн шүүн тунгаах чадвараа хөгжүүлснээр бодитой дүгнэлт гаргаж, үндэслэлтэй тооцоолол, тайлбар хийж, үр дүнг нөхцөл байдал, асуудалд зөв ашиглаж чаддаг. Энэ бол иргэд, хэрэглэгчдийн идэвхтэй байр суурь юм. Шүүн тунгаах сэтгэлгээ нь иргэдийг санаатайгаар төөрөгдүүлж чиглүүлэх явдлыг хязгаарлах, түүнчлэн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээлэл нийлүүлэгчдийн талаарх хэт эрээ цээргүй, үл итгэсэн хадлагад шүүмжлэлтэй хандах чадвар юм. Хэдийгээр үл итгэх байдал нь тийм ч хүсүүштэй зүйл биш боловч, үндэслэлтэй эргэлзээ, үл итгэсэн хандлага бол шүүн тунгаах сэтгэлгээний урьдал нөхцөл мөн.

Хэвлэл мэдээллийн бүх төрлийн агуулга, хэлбэртэй харилцаж эхлэх нь мэдээлэл болон мэдээллийн хэрэгсэлтэй ухамсартай харилцаа тогтоохын эхлэл юм. Энэ үйл явцад хүн мэдээлэлтэй учирч, мэдээлэл өөрт нь хэрхэн нөлөөлж байгааг удирдаж, эцэст нь эргээд өөрөө мэдээлэлд нөлөөлөх чадвартай болно. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн боловсролтой болохын тулд хэвлэл мэдээллийн хэрэглээ чухал.

Зураг 4. Хэвлэл мэдээллийн хэрэглээнээс хэвлэл мэдээллийн суурь боловсролтой болох хүртэл



Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын чадавхтай болсноор, өөрөөр хэлбэл мэдээлэл хүлээн авч, дүн шинжилгээ хийж, үнэлэн цэгнэж, ашиглаж сурснаар хүн дан ганц шинэ мэдлэг олж аваад зогсохгүй бас өөрийн ажил, амьдралдаа үр дүнтэй суралцах чадварыг олж авдаг. Тэрээр мэдээллийг янз бүрийн зорилгоор судлах, үнэлэх, системчлэх, ашиглах тал дээр чадвараа улам өргөжүүлэх юм.


Шүүн тунгаах сэтгэлгээг хөгжүүлснээр хүн одоо байгаа мэдлэг, туршлага дээрээ гацахаас зайлсхийж, шинэ баримт, шинэ мэдээлэлд үндэслэн өөрийн үзэл бодлыг цэгнэх боломжтой болдог. Энэ бол ХММСБ-ын чухал тал юм. Бид хувь хүний хүлээн авсан хэсэг мэдээллийн тухай л ярьж байгаа юм биш. Үүнээс илүүтэйгээр, иргэд/хэрэглэгчид юм ойлгож, одоо байгаа мэдээллээ эргэцүүлэн дүгнэж, ингэснээр тэдний үзэл бодлыг бий болгосон суурь ойлголт өөрчлөгдөж болохыг онцолж байна. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл иргэд/хэрэглэгчийн мэдээллээс урган бүрэлдэж буй бодит байдлыг гүйцээн нөхөх, баяжуулах, өөрчлөх боломжтой гэж үздэг.

Энэхүү гарын авлагын 1-р хэсгийн гол санааг хүргэе. ХММСБ бол мэдээллийн хэрэгслээс хамгаалах арга хэрэгсэл хэмээн үзэх хандлага байна. ХММСБ нь иргэд/хэрэглэгчдийг хэвлэл мэдээллийн түнш болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ХММСБ эзэмшсэн нийгмийн хамгаалагч болгох шилжилтийн үйл явц юм. Яагаад гэж та асууж магадгүй. Хэдэн хэдэн шалтгаан дурдъя. ХММСБ нь иргэдийн шүүн тунгаах чадамжийг нэмэгдүүлж, тэдэнд бүх төрлийн мэдээлэл

болон мэдээлэл үйлдвэрлэгч, түгээгчтэй харилцахад шаардлагатай чадавх, эрхээ эдэлж ашиг тусыг нь хүртэх боломжийг олгодог нийгмийн хөгжлийн гол хөдөлгүүр юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаарах ХММСБ-ын зарим чадавхыг доор болон Зураг 6-д толилуулав:

- хэвлэл мэдээллийн ач холбогдол, гүйцэтгэх үүргийг ойлгох;
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нөхцөл
- байдлыг ойлгох;
- хэвлэл мэдээллийн агуулгыг шүүн тунгааж үнэлэх;
- өөрийгөө илэрхийлэх, өндөр чанартай контент хэрэглэхийн тулд янз
- бүрийн мэдээллийн хэрэгсэлтэй харилцах;
- ямар ч медиа контент бүтээх ур чадварыг олж авах.²⁴

Зураг 5. ХММСБ-той холбогдол бүхий харилцан уялдаатай ойлголтууд өөр харах өнцгөөс



24 Zhilavskaya O.P. Media information literacy as a holistic concept in a changing world. // International electronic scientific and educational journal «Media. Information. Communication». <http://mic.org.ru/2016g/16-nomer-2016/562-medijno-informatsionnaya-gramotnost-kaktselostnoe-ponyatie-v-izmenyayushchemsya-mire>.

See also UNESCO Media and Information Literacy Curriculum for Teachers. UNESCO, Paris. Edited by Grizzle, A and Wilson, C. (2011).

1.5 ХММСБ-ЫН ДАДЛАГА: ДАСГАЛ, КЭЙС

Өөрийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол хэр хэмжээнд байгааг сорихыг хүсэж байна уу? Хэрэв тийм бол доорх асуултад хариулна уу. Энэхүү гарын авлагын I хэсэгт хуваалцсан мэдээлэл нь таны цаашдаа мэргэжлийн хувьд өсөн дэвжих эхлэл бөгөөд өөрийн тань ХММСБ-ын салбарт ашиглагдаагүй байсан ур чадварыг нээж өгч ч болох юм.

1. Мэдээлэл гэж юу вэ?

- А. Энэ бол хүмүүс, объект, баримт, үйл явдал, үйл явцын талаарх мэдээлэл юм.
- Б. Тодорхой сэдвийн талаарх үзэл бодол эсвэл илэрхийлэл юм.
- В. Хүмүүс болон объектын тухай хүүрнэлийг мэдээлэл гэнэ.
- Г. Энэ бол хүмүүсийн дамжуулсан мэдээлэл юм.

2. Мэдээлэл тэнцвэртэй байна гэдэг нь ...

- А. Үйл явдал, үйл явц, зөрчилдөөний оролцогч бүх талд үг хэлэх боломж олгосон үед
- Б. Учрыг ойлгох, шийдвэр гаргахад хангалттай гэж үзсэн үед
- В. Хэн нэгний үзэл бодол, дүгнэлтээс хамаарахгүй үед
- Г. Эсрэг тэсрэг хоёр байр суурь илэрхийлэгдсэн үед

3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролд аль нь хамаарах вэ?

- А. Компьютерын суурь мэдлэг
- Б. Зураг дүрсний суурь мэдлэг
- В. Мэдээллийн суурь мэдлэг
- Г. Дээр дурдсан бүх хэсэг

4. Мэдээлэл, харилцааны шинэ орчинд хэвлэл мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах урьдчилсан нөхцөл болдог, хэрэглэгчдийн онлайн зан үйлийн хэм хэмжээг илтгэдэг тэр зүйл юу вэ?

- А. Интернэтийн ёс журам
- Б. Сүлжээ үүсгэх
- В. Хуваалцах
- Г. Тоглох

5. Мэдээллийг шүүн тунгаах гэж юу гэсэн үг вэ? (хамааралтай гэж үзсэн хэдэн ч хариулт сонгож болно)

- А. Өөрөөсөө асуулт асуух
- Б. Бодох/эргэцүүлэх
- В. Эргэлзэх
- Г. Нэмэлт мэдээлэл хайх
- Д. Дүн шинжилгээ хийх
- Е. Мушгин гуйвуулах боломж олгох
- Ё. Хүлээн авсан мэдээллийн ихэнхийг үгүйсгэх

6. Та ХММСБ-ыг нэг өгүүлбэрээр хэрхэн тодорхойлох вэ?

7. Хүн хэдэн наснаасаа мэдээлэл, хэвлэл мэдээллийн дадал зуршилд суралцах ёстой вэ?

- А. 5 настайдаа
- Б. 10 ба түүнээс дээш насандаа
- В. 20 ба түүнээс дээш насандаа
- Г. 25 ба түүнээс дээш насандаа
- Д. Аль болох эрт

8. ЮНЕСКО-гийн ХММСБ-ын 5 зарчим тус бүрийг 1 үгээр тодорхойлно уу

- 1.

- 2.

- 3.

- 4.

- 5.

- 6.

9. Өгөгдөл, мэдээллийн хэмжээ нэмэгдэх нь ХММСБ-ын чадавхыг эзэмших хэрэгцээнд хэрхэн нөлөөлдөг вэ (өөрийн үгээр тайлбарлана уу)

10. “Хэвлэл мэдээллийн өндөр ачаалалтай ертөнц” гэж та юуг ойлгож байна вэ?

Дасгал 1. Мэдээллийн завсарлага.


Энэ дасгал нь мэдээллийн урсгал дахь Таны оролцоог илүү тодорхой болгоход тус болно.


Даалгавар: Та мэдээллийн урсгалд оролцоход зориулдаг цагийнхаа нэг хэсгээс татгалзах шийдвэр гаргаарай. Интернэтийн орчинд байнга хэрэглэдэг бүх төрлийн суваг, нийгмийн харилцаа холбоо “тасарна” гэсэн үг. Завсарлагын хугацаа дууссаны дараах өдөр та өөрийн хэвлэл мэдээллийн хэрэглээ, өөрийн үүсгэсэн эсвэл бусдад түгээсэн мэдээлэл, харилцаа, мөн мэдээллийн орчны хамаарлын тухай тунгаан бодож, дүн шинжилгээ хийнэ. Доорх хүснэгтэд сүүлийн нэг өдөрт өөрийн илгээсэн нийтлэл/пост/мэдээлэл/мессежний тоог бичиж, тэдгээрийн утгыг тайлбарлана уу.

Нийгмийн сүлжээ / медиа сайт/ мессенжер гэх мэт.	Нийт хуваалцсан пост/ мэдээллийн тоо	Чухал мэдээлэл / ач холбогдолгүй мэдээлэл	Нийтийн ач холбогдол/ хувь хүний ач холбогдол/ хувийн ач холбогдол
1			
2			
3			
4			
5			
6			

Дасгал 2. Миний хэвлэл мэдээллийн хэрэглээ ба харилцааны хэв маяг

Та тодорхой хугацаанд ямар төрлийн мэдээллийн хэрэгсэл ашигласан, бусадтай шууд болон техник сувгаар дамжуулан харьцсан харилцаа, хэвлэл мэдээллийн хэрэглээний дадал зуршилдаа дүн шинжилгээ хийнэ. Үр дүнг цаг хугацааны зурвас болгон танилцуулна. Цаг хугацааны зурвас дээр өдрийн аль цагт, ямар зорилгоор, хэр олон удаа, ямар нөхцөлд ихэвчлэн тухайлсан сайт руу орсон, тодорхой мессенжер ашигласан, олон нийтийн сүлжээнд нэвтэрсэн хэнтэй хэрхэн хэр удаан харьцсан, хэнээс ямар харилцаагаар ямар мэдээлэл авсан зэргийн талаар бичиж, дүгнэлт хийгээрэй.





II ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ
СЭТГҮҮЛ ЗҮЙН БОЛОВСРОЛД

2.1. СЭТГҮҮЛ ЗҮЙН ОЮУТАН, СУРГАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛЖ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ЧАДАВХЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Энэхүү гарын авлагын II хэсгийн агуулга үндсэн гурван таамагт суурилж байна. Эхний санаа нь, дэлхий дахинаа маш олон сэтгүүлч сэтгүүл зүйн чиглэлээр албан ёсны боловсрол эзэмшээгүй. Хоёрдугаарт, сэтгүүлч мэргэжилтэй олон хүн олон нийтэд иргэний боловсрол олгох үүрэг хариуцлагаа бүрэн ойлгоогүй байна.²⁵ Зарим улс оронд энэ нь илүү түгээмэл байна. Гуравдугаарт, сэтгүүл зүйн боловсрол, сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлж байж л тэд ХММСБ ажил мэргэжилд нь ямар хэрэгтэй зүйл болохыг ойлгож, мэддэг болно.²⁶

Энэхүү гарын авлагын уншигчид дараах хоёр өөр талбарыг хооронд нь ялгаж ойлгох хэрэгтэй: нэг нь хэвлэл мэдээллийн боловсрол (энэ гарын авлагад ХММСБ гэсэн нэр томъёог ашигласан), нөгөө нь хэвлэл мэдээлэл судлал юм. Хэвлэл мэдээллийн боловсролд (ХММСБ) нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн асуудлыг сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх замаар, шүүн тунгаах сэтгэлгээг хөгжүүлэх, мэдээллийн харилцаа болон хэвлэл мэдээллийн нийгэм соёлын үүргийг тодотгох, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй үр дүнтэй харилцах ур чадварыг хөгжүүлж амьдралын чанарыг сайжруулах зэрэг асуудал хамааралтай. Хэвлэл мэдээллийн онол, үзэл баримтлалын болон эмпирик судалгаа, тэдгээрийн хэрэглээ, нийгэм дэх хамаарал, чиг үүрэг зэргийг хэвлэл мэдээллийг судлах шинжлэх ухааны талбар хамардаг. Энэ нь хэвлэл мэдээлэл судлал шүүн тунгаах сэтгэлгээ, мэдээллийн харилцаа, мэдээллийн тогтолцоо нийгэм, соёлд хэрхэн нөлөөлж буйг харгалздаггүй гэсэн үг биш юм. Энэ гарын авлагад эдгээр хоёр талбарын гол ялгааг орчин нөхцөл, зорилго, үндсэн чиглэл, зорилтот бүлэг зэргээр илүү тодорхой болгохыг хичээв. Хүснэгт 2-ыг үзнэ үү.

25 Cole, P. (2005). Instinct, Savvy and Ratlike Cunning: Training Local Journalists. In Making the Local News: Local Journalism in Context (Editors: Bob Franklin, David Murphy). First published in Routledge. London and New York. Republished in Taylor and Francis e-Library, 2005.

26 Mihailidis, P. (2006, January). Media literacy in journalism/mass communication education: Can the United States learn from Sweden? Journalism & Mass Communication Educator, 60(4), 416-428.

See also, Standards for Journalism Educators, <http://jea.org/wp/home/for-educators/standards/>. Access on 1 December 2019

Towards a Programme for Journalism and Media Literacy (Aidan White). <https://ethicaljournalismnetwork.org/resources/publications/ethical-journalism/media-literacy>. Access on 1 December 2019

Хүснэгт 2. ХММСБ, хэвлэл мэдээлэл судлалын ялгаа

	Орчин нөхцөл	Зорилго	Үндсэн чиглэл	Зорилтот бүлэг
ХММСБ	Иргэд/хүмүүсийн мэдээлэл, хэвлэл мэдээлэл, технологитой харьцдаг байдал. Нийгмийн оролцоо ба харилцан яриа, эрх чөлөө, хүний эрх, хүртээмж. Бүх түвшний боловсрол–гэрийн, албан ба албан бус боловсролын орчин.	Иргэдэд шүүн тунгаах, хараат бусаар сэтгэх боломж олгох; мэдээлэл, хэвлэл мэдээллийн агуулгыг хайх, шүүн тунгааж цэгнэх, ухаалгаар ашиглах, хувь нэмэр оруулах боломж олгох, хэвлэл мэдээлэл, МХХТ-ийг ашиглан эрх тэгш байдал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, соёл /шашин хоорондын яриа хэлэлцээ, энх тайван зэргийг дэмжих.	Мэдээлэл, хэвлэл мэдээлэл, технологийн шүүн тунгаах чадавх (мэдлэг, ур чадвар, хандлага, үнэт зүйлс, үйлдэл). Эдгээр чадавх нь соёлын суурь мэдлэг, санхүүгийн суурь мэдлэг, дэлхийн иргэншил гэх мэт нийгмийн бусад чадавхтай хэрхэн холбогддог тухай.	Мэдээлэл, хэвлэл мэдээлэл, технологийн янз бүрийн хэлбэрийг ашигладаг бүх иргэд.
Хэвлэл мэдээлэл судлал	Хэвлэл мэдээллийн нийгэмд гүйцэтгэх үүрэг: эрх мэдэл, хяналт, улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, соёл гэх мэт. Ихэвчлэн дээд боловсрол, албан орчин.	Нийгэм дэх хэвлэл мэдээллийн чиг үүргийн талаар илүү сайн ойлгох, бодлого боловсруулах талаар судалгаа хийх боломжийг олгох.	Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, нийгмийн талаарх онол, үзэл баримтлалын хүрээ, эмпирик судалгаа.	Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, сэтгүүл зүйн чиглэлээр судалгаа хийдэг эсвэл ажилладаг мэргэжилтэн, хувь хүн.
Хоорондын уялдаа холбоо	Холбогдох орчин нөхцөл ижил боловч ХММСБ-ын хүрээнд илүү олон хүн хамаарна. ХММСБ нь хэвлэл мэдээлэл судлал мэдээллийн хэрэглээ, зан үйлийг судлах шинжлэх ухаанаас гаралтай.	Хэвлэл мэдээлэл судлалд иргэний боловсрол, иргэний оролцооны асуудал арай бага хамааралтай.	ХММСБ-д өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй чадавх илүү хамаатай бол хэвлэл мэдээлэл судлалд нь эрдэм шинжилгээний ажлыг голлодог.	ХММСБ-д бүх насны иргэдээс гадна мэргэжлийн хүмүүс ч хамрагдана. Өөрөөр хэлбэл ХММСБ-ын зорилтот бүлэг маш өргөн хүрээтэй.

ХММСБ-д хоорондоо харилцан уялдаатай, өргөн хүрээний гурван чадавхыг хамаатуулж байна: 1) мэдээлэл эрж хайх, олох, ашиглах чадавх, 2) иргэний боловсрол, иргэний үйл ажиллагаа/бие даасан байдлыг хангах чадавх, 3) мэдээллийг нягтлах, түгээхтэй холбоотой технологийн чадавх.

Сэтгүүл зүй бол хэзээнээсээ мэдээллийг нягтлах салбар байсаар ирсэн. Гэвч сэтгүүл зүйн боловсролд ч, практик сэтгүүлзүйд ч мэдээллийн чадавхыг сайжруулах шаардлага хэрэгцээ улам бүр өндөрсөж байна. Учир нь хэвлэл, мэдээллийн салбарыг гажуудуулж буй суртал ухуулга, худал мэдээлэл, тоглоом шоглоом хийх явдал, дижитал халдлага, троллинг гэх мэт үзэгдэл газар авч, хямрал хурцдаж байна. «Мэдээллийн хэт ачаалал» нь «мэдээллийн тодорхой бус байдлыг» үүсгэдэг. Янз мэдээлэл, бүрийн харилцаа холбооны технологи, арга хэрэгсэл ашиглан хүмүүсийн ухамсраар тоглох болсны улмаас иргэд, тэдэнд өгсөн аливаа мэдээллийг “шууд залгидаг” болж байна. Энэ нь “шүүн тунгаах бие даасан сэтгэлгээ” дутагдсантай холбоотой юм.

Орчин үеийн жирийн иргэд цахим орчинд байнга мэдээлэл солилцож, шинэ онлайн соёлд оролцож буй бодит байдлыг сэтгүүл зүйн боловсрол, практик сэтгүүл зүйд хүлээн зөвшөөрөх ёстой. Энэхүү шинэ соёл нь иргэдэд мэдээлэл бүтээх болон мэдээллийн урсгалд нөлөөлөх илүү эрх мэдэл буюу бие даасан байдлыг өгдөг. Асуудлын гол нь иргэд энэхүү шинэ чадавх, бие даасан байдлаа хэр үнэлж, хариуцлагатайгаар хандах үүргээ хэр мэдэж байна вэ? Ийм учраас сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрт хэвлэл мэдээллийнхэн хэрэглэгчтэйгээ онлайн болон офлайн орчинд харилцах шинэ чадавхыг эзэмшүүлэх агуулгыг багтаах ёстой. Доор, **“Хэвлэл мэдээлэл, мэдээллийн залуу мэргэжилтнүүдийн боловсрол, сургалтад ямар хичээл, чадавх эзэмшүүлбэл зохистой вэ?”** гэсэн хэсэгт зарим ерөнхий чадавхыг санал болгосон болно.

1982 онд ЮНЕСКО-гийн олон улсын симпозиумаас баталсан хэвлэл мэдээллийн боловсролын тухай Грюнвальдын тунхаглалд 19 орны төлөөлөгчид дараах зүйлийг дурджээ: хэвлэл мэдээллийн маргаангүй нөлөөллийг буруушааж, эсвэл сайшаахын оронд бид түүний жинтэй үүрэг, амьдралын бүхий л салбарт нэвтэрч байгааг нь бодит үнэн гэж хүлээн зөвшөөрч, орчин үеийн соёлын салшгүй хэсэг гэж үзэх хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжлийн хөшүүрэг, иргэдийг нийгэмд идэвхтэй оролцуулах хэрэгсэл болж ирснийг сэтгүүл зүй сэргээх ёстой.

Бусдын бүтээсэн өгөгдөл, мэдээллийг хайж олох, задлан шинжлэх, уг өгөгдөл, мэдээллээрээ нийтлэл бичих чадвартай сэтгүүлчид л үүргээ үр дүнтэй гүйцэтгэж чадна. Олон нийтийг хамарсан үйл явдал ямар учиртай болохыг, хэрэглэгчид дараа нь болох зүйлд бэлдэж юу хийж болох талаар хэрхэн задлан шинжилж, тайлбарлахаа мэддэг сэтгүүлчид мэдээллийг чадварлагаар, хэрэглэгчид хүртээмжтэй байдлаар хүргэж чадна.

Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй нь ХММСБ-ын салбарт хоёр чиглэлийн үүрэг, хариуцлага хүлээж байна:

- Нэгдүгээрт, ХММСБ-ыг дээшлүүлэх, нөөц бололцоог хөгжүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх.
- Хоёрдугаарт мэдээллийн хэрэглээнд дүн шинжилгээ хийх, шүүн тунгаах сэтгэлгээ, арга барилыг хялбаршуулан дэлгэрүүлэх, энэ тухай мэдээлэл өгөх, олон нийтэд сурталчлах явдал юм.

Сэтгүүлчдэд зориулсан ХММСБ-ын сургалтын платформууд

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг дэлхийн хэвлэл мэдээллийн ертөнцөд амьдралын боловсрол гэж нэрлэх нь олонтоо тохиолддог. ХММСБ-ын сургалтын эх сурвалжууд сэтгүүлчдийн мэргэжил дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм. ЮНЕСКО энэ чиглэлийн олон хөтөлбөр, төслийн гол санаачлагч, зохицуулагчдын нэг юм. Олон улсын хэвлэл мэдээллийн боловсролын замыг зассан Грюнвальдын тунхаглал (1982) батлагдсанаас хойш ЮНЕСКО ХММСБ-ын чадавхыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр ирсэн. Эдгээр үр дүнтэй алхмууд нь “Парисын хөтөлбөр буюу хэвлэл мэдээллийн боловсролын талаарх 12 зөвлөмж”-ийн хүрээнд боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн юм.²⁷

Доорх хүснэгтэд ХММСБ-ыг бие даан судлах онлайн эх сурвалж, мөн түүнчлэн мэргэжилтэн, судлаачид хоорондоо сүлжээ үүсгэн хөгжүүлэхийг дэмжсэн платформуудыг танилцуулж байна.

	Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын түншлэлийн дэлхийн холбоо (GAPMIL) нь иргэний нийгмийн оролцогч талууд, сүлжээ, холбоод, мөн хэвлэл мэдээлэл, мэдээллийн салбар, судалгааны байгууллага, засгийн газруудыг нэгтгэдэг сүлжээний сүлжээ бөгөөд хамтын хүчин чармайлтаар ХММСБ-ын чадавх болон холбогдох бодлогыг дэлхийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд түлхэц үзүүлэх зорилготой байгууллага юм.
MILID СҮЛЖЭЭ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮНШЛЭЛИЙН ДЭЛХИЙН ХОЛБОО	MILID сүлжээ нь хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол, соёл хоорондын яриа хэлэлцээний чиглэлээр ажилладаг, олон улсын их, дээд сургуулиудын анхны сүлжээ бөгөөд ХММСБТДХ-ны (GAPMIL) судалгааны нэгж юм. Энэ байгууллага судалгаа, боловсрол, ХММСБ-ыг хөгжүүлэхэд оролцох гэсэн гурван чиглэлээр идэвхтэй ажилладаг.

²⁷ Парисын хөтөлбөр буюу хэвлэл мэдээллийн боловсролын 12 зөвлөмжийг ЮНЕСКО-гийн “Хэвлэл мэдээллийн боловсрол - Грюнвальдаас хойших дэвшил, саад тотгор, шинэ чиг хандлага: цар хүрээг өөрчлөх үү?” хэвлэл мэдээллийн боловсролын олон улсын симпозиумд үндэслэн баталсан: Симпозиумын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ЮНЕСКО-гийн “Information for All”, “Message for the media” <http://www.ifap.ru/pr/2007/070625b.htm> үзнэ үү.

	MIL CLICKS бол ХММСБ-ын нийгмийн хэвлэл мэдээллийн инновацын стратеги юм. Энэ стратегийг нийгмийн сүлжээ ашиглах замаар хэрэгжүүлдэг: 1) Хоорондоо холбогдох, харилцах, тоглох, сайт үзэх уур амьсгалд ХММСБ-ын чадавх эзэмших хүсэлтэй хүмүүсийн сонирхлыг татах. 2) Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын (ХММСБ) ач холбогдолд олон нийтийн анхаарлыг хандуулах.
	Дэлхийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын долоо хоног
	ХММСБ-ын төв нь судалгаа хийдэг бөгөөд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн чиглэлийн багш нар, хэвлэл мэдээллийн салбарыг шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх, өндөр чанартай медиа контентыг ашиглах, бүтээх хэрэгслээр хангадаг. Энэ төв нь ХММСБ-ын судалгаа, сурталчилгаа, сургалт, мэргэжлийн хөгжлийн төвийн хэмжээнд орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд ажилладаг.
	Хэвлэл мэдээллийн суурь боловсролын сургалтын үндэсний нийгэмлэг нь үндэсний гишүүнчлэлтэй байгууллага бөгөөд АНУ-д хэвлэл мэдээллийн суурь боловсролын сургалтыг дэмжих зорилготой юм.
	Салбартаа анхдагч Хэвлэл мэдээллийн суурь боловсролын төв (CML) нь хэвлэл мэдээллийн суурь боловсролын сургалтыг сурталчлан, дэмжих зорилгоор байгуулагдсан. Энэ сургалт нь мэдээлэл олж авах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, хэвлэл мэдээллийн контенттой ажиллахад оролцох, контент бүтээх үндэс болдог. Хэвлэл мэдээллийн суурь боловсролын төв нь иргэдэд, ялангуяа залуучуудад, 21-р зууны хэвлэл мэдээллийн соёлтой мөр зэрэгцэн амьдрахад шаардлагатай шүүн тунгаах сэтгэлгээ, медиа контент үйлдвэрлэх чадвартай болоход тусалдаг.

Сэтгүүл зүйн боловсролд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг нэвтрүүлэх явцад хэд хэдэн хичээлийг ул суурьтай, тогтвортой оруулах шаардлагатай. Эдгээрийг нь сэтгүүл зүйн дээд боловсролын болон мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт академик болон богино хугацааны курс хэлбэрээр зааж болно.

Канад улс үндэсний албан боловсролын байгууллагад суралцаж буй хүмүүст хэвлэл мэдээллийн суурь боловсрол олгох шаардлагыг олон жилийн турш тавьсаар ирсэн. Ингэснээр ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургуулиудад ХММСБ-ын янз бүрийн курс, хичээл болон өргөн хүртээмжтэй онлайн сургалт (MEP) зохион байгуулдаг болсон. Онтарио мужийн Боловсролын яам нь хэвлэл мэдээллийн суурь боловсролыг “оюутнуудад хэвлэл мэдээллийн мөн чанар, тэдний хэрэглэж буй арга техник, эдгээр аргын нөлөөлөлд ухамсартай, шүүмжлэлтэй хандах талаар ойлголт өгөх, цааш хөгжүүлэх хэрэгсэл мөн” хэмээн тодорхойлсон. Үүний нэгэн адилаар, ХММСБ-ын сургалт нь оюутнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээлэл нийлүүлэгчид хэрхэн ажилладаг, олон нийтийн санаа бодлыг хэрхэн бүрдүүлдэг, ямар зохион байгуулалттай, бодит байдлыг хэрхэн бүтээдэг талаар ойлгуулах, уг ойлголтыг улам гүнзгийрүүлэхээр зохион байгуулагддаг.²⁸

“Би хэвлэл мэдээллийн суурь боловсролыг амьдралын суурь боловсрол гэж хардаг, учир нь би одоогийн харилцааны хэлбэрийг ойлгож, үр дүнтэй ашиглаж чадахгүй бол иргэний, хувийн болон мэргэжлийн түвшинд үр дүнтэй хүн байж чадахгүй” гэж Нил Андерсон нэгэн ярилцлагадаа хэлжээ. Тэрээр хэвлэл мэдээллийн боловсролын салбарын анхлагчдын нэг бөгөөд багш нарт ХММСБ-ын технологи, чадавхыг сургалтын хөтөлбөртөө нэвтрүүлэхэд нь тусалж, хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг хөгжүүлэхэд асар их хувь нэмэр оруулсан, Ази, Европын олон улсад, мөн Австрали, Канад, АНУ-д боловсролын лекц, семинар зохиож явуулсан хүн юм.²⁹

Боловсролын салбарын сургалтын үйл явцад ХММСБ-ыг нэвтрүүлэх ажил дэлхийн олон улс оронд хурдацтай урагшилж байна. Жишээлбэл, АНУ-ын Стоуни Брүүк их сургуулийг нэг төрлийн мэдээний суурь мэдлэгийн төв (мэдээний суурь мэдлэг) гэж үздэг. Эдний мэдээллийн сэтгүүл зүй дэх хэвлэл мэдээллийн суурь мэдлэг олгох сургалтын хөтөлбөр нь дөрвөн хэсгээс бүрддэг: олон янз мэдээллийн төрлийг тодорхойлох (үүнийг эрдэмтэн багш нар «өөрийн мэдээллийн орчин тойрныг мэддэг байх» гэж хэлдэг); мэдээллийн эх сурвалж, мэдээн дэх эх сурвалжийн үнэлгээ; мэдээ, санал

28 <https://medialiteracynow.org/what-is-media-literacy/>

29 <http://www.medialit.org>. Voices of Media Literacy project, March 4, 2011.

сэтгэгдлийг тодорхойлох; мөн хэвлэл мэдээллийн өрөөсгөл хандлагыг ойлгох, тодорхойлох, түүнчлэн мэдээний хэрэглэгчдийн өрөөсгөл байдал хэвлэл мэдээллийн текстийг хүлээж авахад нь хэрхэн нөлөөлдөг болохыг ойлгох.³⁰

ХММСБ эзэмших, хэвлэл мэдээллийн агуулгыг шүүн тунгаах чадвартай байх нь залуу үеийнхний эрүүл мэнд, сайн сайхан байдал, мөн ирээдүйд улс орны иргэний болон эдийн засгийн амьдралд оролцоход чухал ач холбогдолтой гэж мэргэжилтнүүд үзэж байна. ХММСБ нь практик сэтгүүлчдэд хэр хамаатай болохыг харуулах зорилгоор эрүүл мэндтэй холбоотой хоёр жишээг доор танилцуулав.

“Хэвлэл мэдээллийн суурь боловсрол яг одоо” төслөөс хэвлэл мэдээллийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар судалгаа хийж, хэвлэл мэдээллийн суурь мэдлэг олгох нь эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх гол стратеги мөн хэмээн дүгнэжээ.

АНУ-д эрт нас баралтын гол шалтгааны нэг нь тамхи татах явдал. Тамхинаас болж нас барсан хүмүүсийн 90 хувь нь өсвөр наснаасаа тамхи татаж эхэлсэн байна. Дээрх төслийн хүрээнд хэрэгжүүлсэн судалгаагаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тамхийг дам сурталчилж буй байдал, тухайлбал кино, сурталчилгааны баатар тамхи татдаг байх нь өсвөр насныхны тамхидалтыг ихээхэн нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ.

Мөн хэвлэл мэдээллийн суурь мэдлэгийг багтаасан эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр нь тамхины эсрэг уламжлалт хичээлээс (хэвлэл мэдээллийн суурь мэдлэгийг оруулаагүй) илүү үр дүнтэй болохыг төслийн үр дүнд тогтоожээ.³¹

Энэхүү төслийн тайланд эрүүл мэндийн бусад асуудал, жишээлбэл тамхи татах, архи, мансууруулах бодисын хэрэглээ, таргалалт ба буруу хооллолт, сэтгэцийн эрүүл мэнд, нойрны эмгэг ба сурлагын үзүүлэлт, Интернэт ба нийгмийн сүлжээний нөлөө, харгислал, хүчирхийлэл, биеийн харагдах байдал ба залуучуудын эрүүл мэндийн талаар тусгасан. Уг тайланд эдгээр асуудлын хувьсалд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн хэрэглээний үзүүлсэн нөлөөг тодорхойлсон бөгөөд зөв сонголт хийх, үхлээс урьдчилан сэргийлэх, сайн ирээдүйг бий болгохын тулд залуучуудыг хэвлэл мэдээллийн мэдлэгтэй болгох нь хамгийн үр дүнтэй хэрэгслийн нэг хэмээн дүгнэсэн байна.

Өөр нэгэн жишээ дурдвал, 2011 оноос хойш өсвөр үеийнхний сэтгэл гутрал, амиа хорлолтын түвшин дэлхий дахинд өссөөр байгаа аж. “Залуу үеийнхэн сүүлийн хэдэн арван жилийн турш сэтгэцийн эрүүл мэндийн хямралын хамгийн доод түвшинд ирээд байна гэж хэтрүүлэггүйгээр хэлж болно. Бидний залуусынхаа гарт бариулсан төхөөрөмжүүд амьдралд нь маш ихээр нөлөөлж, тэднийг туйлын аз жаргалгүй болгосон гэсэн баттай нотолгоо бий.³² Сүүлийн

30 Toward 2020: New Directions in Journalism Education/ Ryerson Journalism Research Centre.

31 U.S. Dept. of Health and Human Services, Dept. of Adolescent Health, Adolescents & Tobacco Trends <https://www.hhs.gov/ash/oah/adolescent-development/substance-use/drugs/tobacco/trends/index.html>

32 Jean Twenge, “iGen: Why Today’s Super-Connected Kids Are Growing Up Less Rebellious, More Tolerant, Less Happy—and Completely Unprepared for Adulthood,” 2017.

үеийн бусад судалгаагаар өдөрт 2-оос дээш цаг сошиал медиа ашиглах нь өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, тухайлбал сэтгэл гутрал, түгшүүрийн шинж тэмдэг, амиа хорлох бодол зэрэгтэй холбоотой болох нь харагдаж байна.

Хэвлэл мэдээллийн суурь мэдлэгтэй болсноор оюутнууд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн хариуцлагатай, аюулгүй, ёс зүйтэй ашиглах тухай, тэр дундаа хэт их ашигласны хор уршиг, түүнчлэн хэвлэл мэдээлэл, технологийг ашигласнаар эрүүл мэндэд үзүүлэх нөлөөтэй холбоотойгоор “дижитал хооллолт” гэх ойлголтын тухай мэдэж авдаг гэж мэргэжилтнүүд дүгнэж байна. Энэ нэр томъёог зохиосон Жоселин Брюэрийн хэлснээр дижитал хооллолт хэмээх ойлголт нь «технологийн хөгжлөөр бий болсон медиа контентыг хэрэглээ танин мэдэхүйн, нийгмийн, сэтгэл хөдлөлд хэрхэн нөлөөлж буй (эерэг ба сөрөг), мөн дижитал төхөөрөмжүүд бидний сэтгэл зүйд, ер нь биеийн болон сэтгэцийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг талаар илүү сайн ойлгоход тусалдаг.”³³

Нийгмийн сүлжээтэй харилцах харилцаа, тэдгээрийн нөлөөг илүү гүнзгий ойлгох нь залуучуудад хэрэглээндээ илүү анхааралтай хандаж, амьд холбоог илүү эрэлхийлэх боломжийг олгодог болохыг судалгаа харуулж байна.³⁴

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн салбарт мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөрт ямар чадавхыг хөгжүүлэх хичээл багтаавал зохистой вэ?

Энэ чиглэлээр хэд хэдэн судалгаа хийгдэж байгаа бөгөөд зөвлөмж, батлагдсан туршлага бий. Зарим улс орон аль хэдийн ХММСБ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх идэвхтэй үе шатандаа ороод явж байгаа тул хөгжиж буй орнууд тэдний туршлагаас суралцаж, ирээдүйн сэтгүүлчдийг бэлтгэхдээ ашиглаж болох юм. Доор бид мэдээллийн дөрөвдүгээр хувьсгалын эрин үед сэтгүүлчдэд шаардлагатай ур чадварыг олгох (бидний үзэж буйгаар) зарим сургалт, хөтөлбөрийг санал болгож байна.

- **Media analysis** (Медиа дүн шинжилгээ) — хэвлэл мэдээллийн агуулга нь тэдгээрийг үйлдвэрлэгч, түгээгчдийн үнэт зүйл, үзэл суртлыг тусгасан байдаг. Агуулгын дүн шинжилгээнд үндэслэн сэтгүүлч шалтгаан, зорилго, мэдээллийн эх сурвалж, нөхцөл байдлыг олж харах боломжтой болно.
- **Media reading** (Хэвлэл мэдээллийн хэрэгслийг унших) — хэвлэл мэдээллийн агуулгыг унших, дахин бодох. Хаана? юу? хэмээн асуухаас илүүтэй яаж? яагаад? гэж асуу.
- **Analysis of media manipulation** (Мэдээллийн хэрэгслийн мушгин гуйвуулгын дүн шинжилгээ) — тохиолдлуудад дүн шинжилгээ хийх, мушгин гуйвуулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж буй арга хэрэгслийг судлах.

33 Digital Nutrition by Jocelyn Brewer. <https://www.digitalnutrition.com.au/about/>. Accessed on 22 November 2019. See also P Sharma, MU Rani (2016). Effect of Digital Nutrition Education Intervention on the Nutritional Knowledge Levels of Information Technology Professionals. In Ecology of food and nutrition, 2016 - Taylor & Francis

34 Joni Siani, “Celling Your Soul,” 2013.

- **Creating historical ties** (Түүхэн хэлхээ холбоог бий болгох) — Бид өнгөрсөн үеэс юу сурч болох вэ, өнгөрсөн үе нь өнөөдрийн үнэ цэн, үйлдэл, үйл явдлын өрнөлийг хэрхэн бүрдүүлдэг вэ?
- **Audience engagement analysis** (Хэрэглэгчийн оролцооны дүн шинжилгээ) — хэвлэл мэдээллийн хэрэгслийн зорилтот бүлэг нь хэн байхаас гадна сэтгүүлчид хэрэглэгчидтэйгээ түншлэлийн ямар харилцаа үүсгэж байгаа, итгэлцлийн түвшин ямар байна, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага хэвлэл мэдээллээр дамжуулж буй утга санаанд хэрхэн тусгагдсан зэрэгт анхаарлаа төвлөрүүлэх, гэх мэт.
- **Media forecasting** (Хэвлэл мэдээллийн урьдчилсан таамаглал) — хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хүний үйл ажиллагааны тусгал мөн, түүнчлэн ирээдүйг баримжаалагч, зам заагч, зүг чиг юм. Мэдээллийн урсгал нийгмийг хаашаа хөтөлж байгааг сэтгүүлч мэдэж байх ёстой.
- **Data analysis** (Өгөгдлийн дүн шинжилгээ) — их хэмжээний мэдээлэлтэй ажиллах олон талын чадвар, чиг хандлагыг тусгасан ажилд хэрэг болохуйц мэдээлэл, ердийнхөөс өөр хэв шинж, шинэ таамаглалыг олж тодорхойлох чадвар.
- **Skills of owning and using technical tools** (Техникийн хэрэгслийг эзэмших, ашиглах чадвар) — мэдээллийг хайх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, дүрсжүүлэн харуулахтай холбоотой хэрэгсэл.
- **Online investigative journalism** (Онлайн эрэн сурвалжлах сэтгүүл зүй) — цахим эх сурвалжийг ашиглах, найдвартай баримт олж авах платформ, үнэнийг хайх, онлайн хэрэглүүрийг ашиглан шалтгаан, үр дагаврын эх үүсвэр болох үйл явдлыг дүрсжүүлэн харуулах.
- **FactChecking** (Баримт шалгах) — нийтлэгдсэн баримт болон бодит баримтын хоорондох үл нийцлийг тодорхойлж нягтлан шалгах.
- **Managing the use of click bates and hooks** (Кликбейт ба “урхи”-ны хэрэглээг удирдах) — хэрэглэгчдийг урхидан контент үзүүлж, сонсож уншуулахаас гадна ийм төрлийн контент өөр ямар үр нөлөө үзүүлж болохыг үнэлэх чадвар. Доорх дасгалд зарим жишээг үзүүлэв.

Дасгал 1

Дараах хүснэгтэд үзэгчдийн анхаарлыг татахын тулд ашигладаг “урхи” болон түүний тайлбарыг үзүүлэв. Урхи нь төрөл бүрийн контентыг сурталчлахад үзэгчдийн сэтгэлийг хөдөлгөх нөлөөтэй байдгаараа үр дүнтэй юм.

Хүснэгт 2.

Дүрс тэмдэг	Танихад хялбар дүрс тэмдэг нь тухайн зорилтот бүлгийн онцлогоос хамааран үүрэг хариуцлагын ухамсар, бардам зан, гутранги байдал, үзэн ядалт зэрэг янз бүрийн хүчтэй мэдрэмж, сэтгэл хөдлөлийг төрүүлдэг.
Хошигнол	Баяр баясгалангийн мэдрэмж, ой тойнд үлддэг.

Жирийн хүмүүс	Энэ нь итгэл, ойр дотно байдал, сэтгэлд таатай, эсвэл хамсах сэтгэл хөдлөлийг төрүүлдэг.
Хэт хөөрүү байдал	Эргэлзээ, үл итгэх байдлыг төрүүлдэг. “Шилдэг...”, “хамгийн...” гэх мэт үгс эргэлзээ, сэжиг төрүүлдэг.
Зусардах	Үзэгчдэд таатай сэтгэгдэл төрүүлэхийн тулд ашигладаг, мэдээллийн эзэн/захиалагчид ашигтай сонголт хийхэд чиглүүлдэг.

2.2. ЦЕНЗУР, ШАХАЛТЫГ ХММСБ-ООР ДАВАН ТУУЛАХУЙ: ИРГЭДИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ШҮҮН ТУНГААХ СЭТГЭХҮЙ

Цензур буюу цагдан хяналт бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө (ҮБИЭЧ), мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй шууд холбоотой. ҮБИЭЧ-ий талаарх ЮНЕСКО-гийн Дэлхийн чиг хандлагын тайлан, мөн Freedom House-ийн 2018 оны тайланд дурдсанаар хэвлэл мэдээллийн эрх чөлөө дэлхий даяар буурч байгаа нь засгийн газрын цензуртэй холбоотой байна.³⁵ Нийгмийн мэдээллийн сүлжээний зарим платформ, үйлчилгээг эсэргүүцэж шахах, хаах тухай санаачилгууд улам бүр нэмэгдсээр байна. Бодит байдал ийм байгаа нь сэтгүүлчид болон сэтгүүл зүйн багш нарын санааг зовоож байгаа нь ойлгомжтой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг цензурдэх, эсэргүүцэх үзэгдэлд ээдрээтэй, олон янзын шалтгаан байдаг. Эдгээр шалтгааны ихэнх нь аль хэдийн сэтгүүл зүйн стандарт сургалтын хөтөлбөрийн салшгүй хэсэг болсон. Үүнд:

- Улс төр, сонгууль, засаглалд нөлөөлөх хэвлэл мэдээллийн хүч
- соёлыг түгээн дэлгэрүүлэх, хадгалахад үзүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь нэмэр
- иргэдийн амьдралд үзүүлж болох хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөө
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл, технологийн зуучлагчид ашиг олох зорилгоор мэдээллийн түгээлт болон хэрэглэгчдийн мэдээллийг олон дахин урвуулан ашиглаж буй байдал
- нийгмийн өөрчлөлтийг удирдах, хянах засгийн газрын хүчин чармайлт
- хэвлэл мэдээллийн өмчлөлийн төвлөрөл
- том бизнес болон сонирхлын бүлгүүдийн нөлөө.

Дээрх жагсаалт нь бүрэн гүйцэд биш бөгөөд цааш нь хэвлэл мэдээллийг цензурдэж, эсэргүүцлийн аргаар хянах мянга мянган шалтаг шалтгаанаар баяжих боломжтой. Хэвлэл мэдээлэл, технологийн үйлчилгээ үзүүлэгчдийн сул тал дээр дөрөөлөх нь цензур, бойкотыг дэмжих учир шалтгааны үндэс

³⁵ World Trends in Freedom of Expression and Media Development: Global Report 2017/2018. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000261065>. Accessed on 30 July 2019.

болох нь түгээмэл. Сэтгүүл зүйн боловсролын салбар нь хэвлэл мэдээлэл, Интернэтийг зохих түвшинд зохицуулах шаардлага байгааг хүлээн зөвшөөрч дэмждэг.

Гэвч сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрт ХММСБ-ыг нэвтрүүлснээр цензур болон аливаа хяналт шахалттай хэрхэн тэмцэж болох талаар нухацтай авч үзээгүй, мөн арга хэмжээ аваагүй байна.³⁶

Өмнө дурдсанчлан, ХММСБ нь шашин хоорондын яриа хэлэлцээ, соёлын ойлголцол, тэгш эрх, нийгмийн оролцоо, хүлцэл, энх тайван, тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг олон давуу талыг бий болгодог. ХММСБ нь иргэдэд хэвлэл мэдээллийн эрх чөлөө яагаад зайлшгүй шаардлагатай, хэвлэл мэдээлэл, технологийн үйлчилгээ үзүүлж буй компаниудын өмнө хэрэглэгч ямар эрхтэй, хувийн орон зайн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах гэх мэт зүйлийг ойлгох боломжийг олгодог. Энд нэг зүйлийг санал болгоход, хүмүүст ХММСБ-той болсноор эргээд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалж, хэвлэл мэдээллийн хэрэгслээс чанар, үнэнийг шаардаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцаж, аливаа эх сурвалжийг сонгохдоо мэдлэгтэй, ухамсартай сонголт хийх боломжтой болохыг сэтгүүлчид ойлгох хэрэгтэй юм.

Тиймээс ХММСБ нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын механизмын гол бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн зарим асуудлаар өөрийгөө зохицуулж чадахгүй бол төрийн зохицуулалт нэмэгддэг. Энэ үүднээс авч үзвэл хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарынхан ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлэхдээ салбар дотроо болон гадагшаа чиглэсэн, жишээлбэл шийдвэр гаргагчдад хандсан үйл ажиллагаанд анхаарах ёстой. Дотогшоо болон гадагш чиглэсэн үйл ажиллагааны зарим жишээг доор дурдсан бөгөөд эдгээр нь тэр чигээрээ энэ гарын авлагын сэдэв болж буй юм. Гадагш чиглэсэн арга хэмжээ нь ХММСБ-ын ач холбогдлыг шийдвэр гаргагчдад ойлгуулж, арга хэмжээ авхуулах зорилготой байж болно. Мөн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх замаар иргэд өөрсдөө хэвлэл мэдээллийн цензурыг эсэргүүцэж, Засгийн газраас ХММСБ-д хөрөнгө оруулахыг шаардахтай холбоотой байж болно.

Энэ хүрээнд сэтгүүл зүйн хичээлийн хөтөлбөрт тусгах шаардлагатай зарим асуудал, сэдвийг санал болгож байна:

- Хэвлэл мэдээллийн байгууллага, мэргэжлийн холбоод ХММСБ-ыг сурталчлах замаар хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хэрхэн бэхжүүлэх вэ? Хэвлэл мэдээллийн салбарт шаардлагатай (хүүхдийн эрхийг хамгаалах контентын зохицуулалт, сурталчилгааны зохицуулалт гэх мэт) төрийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах арга нь иргэдийг өргөнөөр оролцуулж, харилцан ярилцах арга зам байж болох юм. ХММСБ бол ийм үйл явцыг идэвхжүүлэх үр дүнтэй арга юм.
- ХММСБ-ын шаардлага хангасан редакцын бодлого боловсруулах.
- Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн сул талыг хэрхэн ил тодоор мэдээлж чадах вэ?

36 Van der Linde, F. (2010). The necessity of a media literacy module within journalism or media studies curricula. *Global Media Journal, African Edition*. Vol 4 (2). <http://dx.doi.org/10.5789/4-2-7>.

- Мэдээ болон бусад хэвлэл мэдээллийн агуулгыг хэрхэн бүтээдэг талаар хүмүүст ойлгуулахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслээс боловсруулж болох арга техник, хөтөлбөрийн төрөл.
- Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн түншлэлийг хөгжүүлэх.
- Олон нийтийн сонирхсон асуудал, олон нийт асуудлыг юу гэж харж байгааг хэрхэн илүү сайн тусгах вэ?
- Хэвлэл мэдээллийнхэн өөрсдийн өмчлөлийн талаар болон ивээн тэтгэгч, зар сурталчилгаа нийлүүлэгчидтэй харьцах харилцааны мөн чанарын талаар ил тод байх тухай
- ХММСБ-ыг сэтгүүл зүйн практикт хэрхэн нэвтрүүлэх, мөн энэхүү гарын авлагын гарчгийн жагсаалтад дурдагдсан бусад сэдэв, асуудлууд.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй агуулгыг ажиглаж, тайлбарлан чилүүлэх, иргэдэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах тухай. Энэ талаар дараагийн хэсэгт товч авч үзсэн болно.

2.3 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГЫГ АЖИГЛАЖ, ТАЙЛБАРЛАХ ЗАМААР ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ НЬ

Чанар муутай сэтгүүл зүй, үндэслэлгүй онлайн контент нь хэвлэл мэдээллийн утга агуулгыг мушгин гуйвуулж, олон нийтийг төөрөгдүүлэх, буруугаар залж чиглүүлэх боломжийг нээдэг. Ийм тохиолдлуудыг цензурин гол үндэслэл болгон ашиглах нь түгээмэл. ЮНЕСКО мэргэжлийн болон ёс зүйтэй сэтгүүл зүй бол цензурээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй бөгөөд тогтвортой арга хэмээн үздэг.³⁷ Иргэдийг хэвлэл мэдээллийн хор хөнөөлтэй агуулгаас хамгаалах хамгийн үр дүнтэй, тогтвортой арга бол хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролоор дамжуулан иргэдийг өөрсдөө өөрсдийгөө хамгаалах чадавхтай болгох явдал мөн. Үүнийг хэвлэл мэдээллийн салбарынхан болон бусад бүх оролцогч тал ойлгож, хамтран ажиллах нь чухал. Нөгөө талаар практик сэтгүүлчдийн иргэний ухамсрыг дээшлүүлэх нь онцгой өндөр ач холбогдолтой.³⁸

Үүний тулд сэтгүүлчид тодорхой төрлийн агуулга хүмүүсийг хэрхэн бусниулж болох талаар мэддэг байх, шаардлагатай үед ёс зүйтэйгээр хариу арга хэмжээг авах, үйл явцыг баримтжуулахад сургах хэрэгтэй юм.

Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн нийтэлж, нэвтрүүлж буй агуулгыг мэргэжлийн үүднээс хянах сонгодог арга бол редакцийн бодлого юм. Асуудлын гол нь сэтгүүлчид мэдээгээ хурдтай цуглуулж, хянаж, нийтлэх шаардлагатай тулгарч буй нь чанарын хяналтад ноцтой хязгаарлалт

³⁷ Professional journalism and self-regulation: new media, old dilemmas in South East Europe and Turkey. UNESCO (2011), Paris. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000190810>. Accessed on 23 November 2019.

See also White, A. (2008). To Tell You The Truth. The Ethical Journalism Initiative. Brussels, Belgium: International Federation of Journalists.

³⁸ Banda, F. (2009). Civic Education for Media Professionals: A Training Manual. UNESCO Series on Journalism Education. UNESCO, Paris.

үүсгэдэг. Тийм ч учраас орчин үеийн сэтгүүлчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй агуулгын болзошгүй сөрөг нөлөөг урьдчилан харж, шаардлагатай үед тайлбарлах, залруулах зэрэгт бэлтгэгдсэн байх нь гурван давхар хамгаалалтыг баталгаажуулна. Энэ хамгаалалт нь хамгийн түрүүнд нийтлэх зарчим, иргэдийг ёс зүйн хамгаалалтад авах, тэдэнд үнэнийг хүргэх зарчмыг тэнцвэржүүлэхэд оршино.

Тиймээс сэтгүүлчдэд үнэн, зөв, хамааралтай, цаг үеэ олсон, тэнцвэртэй, шударга, хараат бус гэх мэт сэтгүүл зүйн суурь зарчмуудыг зааж сургахаас гадна дор дурдсан зарим чадавх, асуудлыг чухалчилж, хэвлэл мэдээллийн агуулгыг илүү сайн ажиглаж, шаардлагатай үед мэргэжлийн хүний хариу арга хэмжээ авах талаар сургах нь иргэдийн ашиг сонирхолд нийцэх юм:

- Танин мэдэхүйн чиглэлээр сэтгэл зүйн анхан шатны сургалт: хүн хэрхэн сэтгэж, шинэ мэдээлэлд хариу үйлдэл үзүүлдэг; мэдээллийг хэрхэн мэдэж, сурч, ойлгодог.
- Сэтгэл хөдлөлийн суурь мэдлэг: иргэд, хэрэглэгчдийн байр сууринаас.
- ХММСБ-ыг хэрэглэгчдийн шүүн тунгаах сэтгэлгээг хөхиүлэн дэмжих арга замын хувьд дэмжин сурталчлах
- Хэрэглэгчидтэй харилцах суваг нээж, зохих хэрэглүүрийг ашиглан тэдний хэвлэл мэдээллийн тодорхой агуулгад өгсөн хариу үйлдлийг үнэлэх, гарсан дүгнэлтийг олон нийтэд нээлттэй болгох, хэрэглэгчээс гарсан санал хүсэлтийг цааш цаашдын агуулгад тусгах замаар ёс зүйтэй ашиглах.

2.4 ХММСБ-ЫГ ДЭМЖИН СУРТАЛЧЛАХ ЗАМААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ БОЛОН НОМЫН САНГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

Хүн төрөлхтөн мэдээллийн нийгэмд шилжиж, шинэ технологийн нөлөөгөөр мэдээллийн урсгал геометрийн прогрессоор нэмэгдэж, хэвлэл мэдээллийн нөлөөлөл хурдацтай өсөж байна. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ хүний бүхий л амьдралд динамик, дэлхий нийтийн шинжтэй болж ирлээ. Өнөөдөр хүмүүс, ялангуяа залуу үеийнхэн шинэ мэдээллийн хэрэгслийн нөлөөнд автсан байна. Өмнө дурдсанчлан, тэд мөн мэдээлэл бий болох явц, мэдээллийн урсгалд ч нөлөөлж байна.

Номын сангууд хэзээнээсээ мэдээллийн сан хөмрөг байсаар ирсэн. Өнөөдөр номын сангууд хөгжиж ном агуулах газар төдий байхаа больсон. Тэнд байгаа асар их мэдээлэл, мэдлэгийн нөөцийг ХММСБ-ын тусламжтайгаар улам бүр өргөжүүлэх боломжтой юм. Номын сангийн ажилтнууд мэдээллийг олох эх адаг нь олдохгүй олон нугачаатай замын хөтчөөр ажилладаг. Тэдэнд одоо гүйцэтгэх хоёр үүрэг байна, нэг нь мэдээллийн агуулахуудыг зохион байгуулах, ингэхдээ тэдгээрийг төөрч будилахгүйгээр олж болохоор хөтөчтэй болгох. Үүний зэрэгцээгээр нөгөө үүрэг нь тэд мэдээллийн нөөцийг хэрэглэж

буй уншигчдад шаардлагатай мэдээллийг асар их хэмжээгээр олоход чиглүүлж өгөх чадвартай байх ёстой.



Номын сангууд нь хүн амын хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг дээшлүүлэх хэрэгслийн хувьд мэдээлэл, хэрэглэгч, хүлээн авах цэгийн хооронд гүүр болж, чухал үүрэг гүйцэтгэдэг.



Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл




Номын сан



Хүлээн авах цэг



Зөвлөгөө



Хэрэглэгч

Хувь хүний мэдээллийн соёл мэдээлэл олж авах цэг дээр бүрэлддэг. Тиймээс номын сан нь хувь хүний төлөвшлийн чухал зангилаа нь болдог. Тэгэхээр яг энд л ХММСБ-ын дадал зуршлыг (мэдээллийн суурь мэдлэг, хэвлэл мэдээллийн суурь мэдлэг, дижитал чадвар) төлөвшүүлэх үйл ажиллагааг нэвтрүүлж өгөх хэрэгтэй юм.

ХММСБ-ын чадавх бүрдүүлэхэд номын сангийн гол давуу тал бол тэнд мэдээлэлтэй ажиллахад бэлтгэгдсэн мэдээллийн урсгалын бодит хөтөч байдагт оршино. Өнөө үеийн шинэ номын сангийн мэргэжилтнүүд өмнөх шигээ хүмүүст мэдээллийн каталогт зүг чигээ олоход нь туслаад зогсохгүй, уншигчдыг замчлан чиглүүлж, эрж хайсан, хүлээн авч буй мэдээллийн шинж чанар, хамрах хүрээ, онцлогийн талаар мэдээлэл өгч чадах зөвлөх, мэргэжилтэн болж байна. Энэ нь номын санч, мэдээллийн мэргэжилтний туршлага нь мэдээллийн хүртээмжийг хангах маркетингийн чухал хэрэгсэл болж байна гэсэн үг.

Энэ яагаад чухал вэ?

Номын сан гэх мэт мэдээлэл, мэдлэгт нэвтрэх цэгүүд нь ХММСБ болон хэвлэл мэдээллийн орчныг бүрдүүлэх боломжтой суваг болдог. Номын сангууд өсвөр үе, залуучуудыг Интернэт, технологийн өргөн боломжоор хангасаар байгаа тул ХММСБ-ын чадавхыг түгээн дэлгэрүүлэхэд ч бас илүү идэвхтэй оролцох нь чухал юм. Худал, ташаа мэдээлэл ямар ч үнэлгээний системгүй хэр нь илүү амархан бөгөөд хурдан тархдаг. Судалгаанаас үзэхэд «дундаж худал мэдээлэл 10 орчим цагийн дотор Твиттерийн 1500 хэрэглэгчдэд хүрдэг бол үнэн мэдээлэл энэ тооны хэрэглэгчдэд хүрэхийн тулд 60 орчим цаг зарцуулдаг.» Номын санчид залуучуудад мэдээллийг үнэлж, нягтлахыг зааж, тухайн үедээ хэвлэн нийтлэгч, редактор, мэргэжилтнүүдийн тоглодог байсан мэдээлэл нягтлагчийн дүрд “тоглох” боломжийг олгож болох юм. Ингэснээр хэвлэл мэдээллийн байгууллагууд болон номын сан гэх мэт мэдээллийн бусад байгууллагууд мэдээлэл цуглуулах, эмхлэх, түгээх нийтлэг зорилготой ч үүнийг гүйцэтгэх цаг хугацаа нь ялгаатай байхыг харгалзан үзэх хэрэгтэй.³⁹

Сэтгүүл зүйн боловсрол олгох хөтөлбөрт номын санчидтай хамтран ажиллах сонирхол, сэдлийг сэтгүүлчдэд бий болгох агуулга багтах ёстой бөгөөд ийм түншлэл нь дараах боломжийг бий болгоно:

- Залуучуудад Интернэт дэх мэдээ болон бусад мэдээллийн “эрүүл” хэрэглээний чадвар хөгжүүлэхэд нь туслах.
- Хуурамч мэдээллийг таних, онлайн мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэх (жишээлбэл, гарчигт итгэхгүй байх, эх сурвалжийг шалгах, гэрэл зурагт үл итгэх, бичсэн зүйлд эргэлзээ байгаа бол сэтгэгдэл бичиж тодруулга авах) гарын авлагаар хангах. Энэ бол нийтийн болон сургуулийн номын сангийн алинд ч тохирох хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын сургалтын нэг хэлбэр юм.
- Мэдээллийг хэвлэл мэдээллийн хэд хэдэн эх сурвалжаас авч зөв хэрэглэх тухай заах.

³⁹ Altschiller, D. (2002). A librarian's plea to journalists: Give us a clue! Columbia Journalism Review, 40(6), 70.

- Сэтгүүлчид номын сангуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, мониторинг хийх арга замыг хайж олох.

Эдгээр үйл ажиллагааны эцсийн зорилго нь мэдээлэлтэй, мэдлэгтэй хэрэглэгч хойч үеийг сургаж авах явдал юм. Энэ хойч үе нь үнэний дараах нийгэмд учраа олж чадах, дэлхий дахинд юу болж буйг сайн мэддэг, үүний хажуугаар номын сангийн нөөц бололцоог үр дүнтэй, өндөр шаардлагатайгаар хэрэглэдэг үе байх юм.

Үүний тулд номын санд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол олгох сургалтын янз бүрийн хэлбэр, аргыг ашиглаж болно:

- Нээлттэй лекц
- Төслийн сургалт
- Илтгэл
- Товхимол
- Зурагт хуудас
- Веб сайтад бичвэр нийтлэх
- Нийгмийн мэдээллийн сүлжээнд нийтлэх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр илтгэл тавих (амаар болон бичгээр), гэх зэрэг өөр олон зүйл байж болно.

Шигтгээ 1. Тогтвортой мэдээллийн соёлыг төлөвшүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй номын сангуудын үйл ажиллагааны сайн жишээ

Залуу уншигчдыг мэдээллийн асар том ертөнцөд чиглүүлэхийн тулд Америкийн номын санчдын холбоо «Хүүхдэд зориулсан агуу вебсайтууд» (<http://gws.ala.org/>) -ийг бүтээсэн бөгөөд энэ нь хүүхдэд зориулсан өндөр чанартай, мэргэшсэн мэдээллийн жагсаалтыг агуулсан эх сурвалж юм.

Италийн Реджио Эмилия хотын оршин суугчид хүүхдүүдийг шинэ санааны эх сурвалж гэж үзсэн байна. Хүүхдүүд бодлоо үг, дүрс, дуу авиа болон бусад аргаар, өөрөөр хэлбэл «хүүхдийн зуун хэл»-ээр илэрхийлдэг. Голландын номын сангийн байгууллага (NBLC) хүүхдүүдтэй харилцах санаа, арга замыг ашигласан хүүхдийн номын сангийн дизайн боловсруулахыг хүсэж байсан.



Дани улсад «Номын санд тоглоё» зэрэг төсөлд ихээхэн ач холбогдол өгч, тоглоомын соёлыг хүүхэд, тэдний эцэг эхчүүдэд үзүүлэх үйлчилгээний агуулга, зуучлалын гол бүрэлдэхүүн хэсэг болгох оролдлого хийж байна. Тоглоомыг бүтээж бий болгоход янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хувь нэмрээ оруулсан байна. Мөн номын сангууд өөрсдөө хүүхдийн тоглоом болон компьютер тоглоомыг ашиглах боломжоор хангадаг бөгөөд ийм аргаар хүүхдийн тоглоомын соёлыг төлөвшүүлдэг аж.

2005 оны долоодугаар сард Япон улсад “Унших, бичих соёлыг дэмжих тухай хууль”-ийг шинээр баталсан. Тус улсын номын сангийн нийгэмлэг нь энэхүү хуулийн эхийг боловсруулсан бөгөөд , уг хуульд хүүхдийн унших, бичих чадварыг хөгжүүлсний бодит үр нөлөөнд анхаарал хандуулсан аж.

Уг хуульд бичих, унших соёлыг дэмжих үндсэн үзэл баримтлалыг тодорхойлж, хуулийг хэрэгжүүлэх хүрээнд үндэсний болон орон нутгийн удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Энэ хуулийн дагуу Ном унших долоо хоногийн эхний өдөр буюу аравдугаар сарын 27-ны өдрийг Унших, бичих соёлын өдөр болгон зарласан.

Узбекистаны үндэсний номын сан ч бас туршилтын журмаар нэгэн төслийг хэрэгжүүлсэн аж. Уг төслийн хүрээнд номын санчид дунд сургуульд хоёр хичээл зааж, хэвлэл мэдээллийн эх бичвэрт дүн шинжилгээ хийж, үүний үндсэн дээр бага сургуулийн сурагчдад хэвлэл мэдээллийн суурь боловсролын чадвар хөгжүүлэх даалгавар өгсөн байна.

Практик жишээ: хэвлэл мэдээллийн агуулгын анализ, синтез гэж юу болохыг тайлбарлахын тулд та хүүхдийн танил зүйлийг хялбархан ашиглаж, эхлээд хэсэг хэсгээр нь салгаад, дараа нь шинэ дүрс угсарч болно. Энэхүү аргаар мэдээ нь салангид хэсгээс бүтдэг, тэдгээрийг өөр өөр янзаар угсарч болдог, тэгснээр өөр өөр утга санаа гарч болно гэдгийг ойлгуулж болох юм.

Лего тоглоом шиг хэсэг хэсгээр нь салгана	Өөр дүрс угсарна
	

Америкийн Номын сангийн холбооны 2016 оны “Америкийн Нэгдсэн Улсын Номын сан” баримт бичигт дурдсанаар номын сангийн үйлчилгээ хэрэглэгчдэд эх сурвалжийг олж өгөхөөс илүүтэйгээр интерактив мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн боловсрол олгох тал руу шилжиж байна. Номын санчид мэдээллийн зөвлөгчийн үүргийг гүйцэтгэж, мэдээлэл олж авах боломжоор хангаад зогсохгүй хэрэглэгчид аль мэдээлэлд итгэж болохыг зааж сургах боломжтой аж.

2.5 УЛАМЖЛАЛТ БУС МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖТАЙ АЖИЛЛАХУЙ

Сэтгүүл зүй бол нисэн өнгөрөх өдөр тутмын үйл явдал дундаас үнэхээр чухал, хүмүүсийн санааг зовоож буй зүйлсийг олж тогтоодог мэргэжил юм.

Ингэснээр сэтгүүлчийн үндсэн үүрэг нь мэдээллийг мэргэжлийн түвшинд цуглуулах, боловсруулах, улмаар мэдээ хэлбэрээр түгээх ажил болдог.

Сэтгүүл зүйн үйл ажиллагаа ямагт баримтжуулсан мэдээлэлд тулгуурлах ёстой. Сэтгүүлчийн ажил баримт, түүний эх сурвалжид дүн шинжилгээ хийхээс эхэлдэг бөгөөд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын зарчим энд хэрэг болно. Ингэснээр энэ салбарт сэтгүүлчийн ажлын үр дүн мэргэжлийн чадавхаас нь шууд хамаардаг. Сэтгүүлчийн эх сурвалжтай ажиллах, баримт боловсруулах, материалд дүн шинжилгээ хийх, шүүн тунгааж задлан тайлбарлах чадвар нь эцсийн бүтээгдэхүүнийг бүрдүүлдэг юм.⁴⁰

Сэтгүүлч мэдээлэл цуглуулахдаа юун түрүүнд анхдагч мэдээлэл хэр бодитой, үнэн зөв эсэхийг шалгах ёстой бөгөөд “баримтын найдвартай байдал нь мэргэжлийн дүгнэлт, шинжээчийн тайлбар, нотлох баримт, үндэслэлээр батлагддаг” гэдгийг үргэлж санаж байх ёстой. Эдгээр шинж чанараараа сэтгүүл зүйн мэдээлэл бусад бүх мэдээллээс ялгардаг.

Бүтээл бичих үе шатын талаар ярихад юуны түрүүнд сонгох сэдвийн талаар эргэцүүлэн бодно гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сэдэв бол сэтгүүл зүйн материалын гол суурь юм. Энэ нь тухайн бичвэрийг зориулж буй дугаарын онцлох сэдэв, тухайн редакцын зорилтот хэрэглэгчдийн онцлогт нийцээх ёстой. Жишээлбэл, хууль эрх зүйн нийтлэлд зохих сэдвийн хүрээнд залуучууд, улс төр, боловсролын болон бусад сэдвийг сонгож болно. Нийтлэл бичихэд мөн хэвлэл мэдээллийн форматад тохирсон сэдвийг хайж олох нь чухал.

Сонгосон сэдвийг олон талаас нь авч үзэх боломжтой бол материалынхаа санааг хэрхэн илэрхийлэхээ бодох хэрэгтэй. Санаа гэдэг нь онол боловсруулагчдын бичсэнээр «зохиогчийн байр суурийн илэрхийлэл, би энэ материалыг юуны тулд бичиж байна вэ?» гэсэн асуултын хариулт юм. Материалыг хэнд зориулж юу бичиж/ бэлтгэж байгаагаа ойлгох нь чухал. Энэ асуултад хариулсны дараа материал, баримт, тайлбар, тодруулга, үндэслэл гэх зэргээр мэдээлэл цуглуулах ажлыг эхэлнэ.

Сэтгүүлч бичвэрээ бичихээс нэлээд өмнө баримт цуглуулах үүрэгтэй. Олон тооны эх сурвалж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан материал, сэдвийн талаарх нийтлэл зэргийг тоймлосноор түүний оюун ухаанд үйл явдал, үзэгдэл, сурвалжлах шаардлагатай сэдвийн зураглал гарч ирдэг.

Хэвлэн нийтлэх гэж буй материалтайгаа ажиллахад мэдээлэл цуглуулах, мэдээллийн талаар дахин эргэцүүлэн бодох гэсэн хоёр үе шат байдаг.

Мэдээлэл цуглуулах янз бүрийн арга бий: хүнтэй ярилцах, ярилцлага хийх, хувийн ажиглалт хийх, архивын баримт бичигтэй ажиллах, социологийн судалгаанд дүн шинжилгээ хийх, бусад мэдээллийн хэрэгслийн, түүний дотор

40 Henderson, H. (2004). Library in a book: power of the news media. New York: Facts On File. Bibliography w/ bio & historical info on media research.

Singh, A. B. (2005, July). A report on faculty perceptions of students' information literacy competencies in journalism and mass communications programs: The ACEJMC survey. College & Research Libraries, 66(4), 294-311.

Интернэтийн контентыг тоймлон судлах гэх мэт.

Мэдээллийн тухай дахин эргэцүүлэн бодох. Баримт бичиг, гэрэл зураг, дуу хоолойн бичлэг - бүгдийг ашиглана. Энэ бүхнийг бас ойлгож, эргэцүүлэн бодно. Анхдагч мэдээлэл дээр өгөгдөл, баримт, эшлэл гэх мэтийг яагаад ахин, дахин шалгах шаардлагатай байдгийг сайтар ойлгох хэрэгтэй.

Мэдээллийг дахин эргэцүүлэн бодох явцад сэдвийг хэрхэн өөр өөр арга ашиглан олон талаас нь харуулах талаар бодож үзнэ. Түүнчлэн мэдээллийн өөр өөр эх сурвалжийг хэрхэн ашиглах талаар сайн анхаарах хэрэгтэй. Зөвхөн оролцогч талуудын ярилцлагад хязгаарлагдах шаардлага байхгүй.

Шаардлагатай баримт материалыг олж авсны дараа түүнийг үндсэн болон хоёрдогч хэсэгт хуваах шаардлагатай. Ингэж хуваах нь үндсэн хэсгийг илүү анхаарч, хоёрдогч хэсгийг бага анхаарна гэсэн үг биш юм. Энэ арга нь үндсэн үзэл баримтлалыг тодорхойлж, гол анхаарлаа хандуулах материалыг сонгох боломж олгодог.

Гол баримтаар шинжээчийн дүгнэлтээр баталгаажсан, нотлох үндэслэлтэй хүчтэй элементийг сонгох хэрэгтэй. Бусад бүх зүйлийг эрэмбэ дарааллаар жагсаахад болно.

Мэдээлэл цуглуулах, текст бичихэд бэлтгэх нь ажлын хамгийн чухал үе шат юм. Тиймээс олж авсан мэдээллээ зохих байдлаар толилуулах нь чухал. Ингээд, баримтаа сонгож, мэдээллээ системчилсэн бол бичвэр дээрээ сууж болно.

Юмыг тэгээс эхлэх үргэлж хэцүү байдаг. Хамгийн чухал зүйл бол ер нь эхлүүлэх явдал юм. Эхний ээлжид бичвэрийнхээ бүтцийг бодож боловсруулаад, ямар төрөл, хэлбэрээр бичихээ шийдэж, зургаа сонгох хэрэгтэй. Мэргэжлийн үндсэн мэдлэг олгох сурах бичгийн орчин үеийн зохиогчид мөн «... инфографик юм уу зургийн цуглуулга (коллаж) хэрэглэх талаар бодож үзээрэй, эдгээр нь текстийн мэдээллийг маш сайн баяжуулдаг элементүүд юм» гэж зөвлөж байна.⁴¹ Дүрсжүүлэх олон янзын арга хэлбэр, түүний элемент, боломжийн талаар энэхүү гарын авлагын “Мэдээллийг дүрсжүүлэх: шинэ боломжууд” хэсэгт илүү дэлгэрэнгүй тайлбарласан болно.


Дасгал 2. «Шалан дээрх асуудлууд».

1. Нийгмийн мэдээллийн сүлжээ, хэвлэл мэдээллийн агуулгад ажиглалт хийж, сүүлийн үед хамгийн ихээр хэлэлцэгдэж буй сэдвийн хүрээг тодорхойлно.
2. Дараа нь хамрах хүрээг багасгаж нэг сэдэв үлдээнэ.
3. Яг юун дээр төвлөрөхөө тодорхойлохын тулд сэдвийг нарийсгаж цөөн хэдэн бүрэлдэхүүн хэсгийг үлдээнэ.

41 Bakanov R.P., Simkacheva M.V., Tumanov D.V., Journalism for beginners: A textbook for university students. — М.: «Aspect-Press», 2018. P. 66.

4. Ингэснээр «хэрэглэгчдийн зовлон»-г тодорхойлох боломжтой, өөрөөр хэлбэл асуудлыг тодорхойлно.
5. Энэ асуудалд ашиг сонирхол нь өртөж буй хүмүүсийг тодорхойлж, уялдаа холбоог тогтоох нь чухал.

Зураг 6 "Таны хөлд байгаа" асуудлууд



Дасгал 3. Мэдээллийн баримтат эх сурвалжтай ажиллах.

Тодорхой сэдвийн материалд мэдээллийн эх сурвалжийн жагсаалт гаргана. Мэдээллийг "Би итгэж байна", "Би итгэхгүй байна" гэсэн хоёр ангилалд хуваана. Баримтыг дор хаяж гурван бие даасан эх сурвалж батлах ёстой.

Сэдэв	Итгэж болох эх сурвалж	Итгэж болохгүй эх сурвалж
Та архи, согтууруулах ундаа худалдаалах зөвшөөрлийг онлайнаар авах боломжтой.	1.	1.
	2.	2.
	3.	3.
Мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн явцад иргэдийн банкны бүх дансыг “царцаах” боломжтой.	1.	1.
	2.	2.
	3.	3.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисын жагсаалтыг өргөжүүлсэн.	1.	1.
	2.	2.
	3.	3.
Узбекистан улсад валютыг сум руу шимтгэлгүй хөрвүүлдэг АТМ ажиллаж эхэллээ.	1.	1.
	2.	2.
	3.	3.
Узбекистан улсад 2.5 литрийн турбо хөдөлгүүртэй шинэ “Малибу”-г танилцууллаа.	1.	1.
	2.	2.
	3.	3.
Сильвестр Сталлоне хорт хавдраар нас баржээ.	1.	1.
	2.	2.
	3.	3.

Интернэтийг мэдээллийн эх сурвалжийн хувьд ашиглах нь

Даян Дэлхийн Вебийн боломж нь сэтгүүлчдэд баримт хайж олох, шалгах, олон нийтэд дэлгэн мэдээлэхэд гарын дор байдгаараа ихээхэн тустай. Өмнө нь аливаа мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн л бол итгэж болохуйц мэдээлэлд ордог байсан. Гэвч Интернэт энэ итгэл үнэмшлийг эвдэж эхэлсэн бөгөөд өнөөдөр худал, буруу мэдээлэл тараасан тухай баримтууд улам бүр нэмэгдсээр байгаа нь сэтгүүлчийг хүртэл төөрөгдүүлж байна.

Цаг хугацаа зарцуулан байж архив, номын сангаас мэдээлэл хайдаг байсан үе виртуал орчинд тоон мэдээллээр хайлт хийдэг эрин үед зайгаа тавьж өгчээ. Эдгээр асар их мэдээллийн санд хандахдаа сэтгүүлчид санамсаргүйгээр алдаа гаргах үе байдаг.

Сэтгүүлчид болон ер нь хүмүүс өнөө цагт хамгийн түгээмэл ашиглагдаж буй нийгмийн мэдээллийн сүлжээнээс хамааралтай болоод байна. Хэвлэл мэдээллийн энэхүү орчинд, ботоор ажиллуулдаг нийгмийн мэдээллийн сүлжээн дэх хуурамч хаяг олширч, зориудаар худал, ташаа мэдээлэл тараахад ашиглагдаж байна. Алгоритмын хөгжил, хиймэл оюун ухааны (AI) хувьсал зэрэг нь сэтгүүл зүйн практикт болон сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрт хөндөх ХММСБ-ын чухал асуудлууд юм. Алгоритм ба хиймэл оюун ухааныг мэдээ, мэдээллийн эх сурвалж болгох, нягтлан шалгахад ашиглах нь улам бүр нэмэгдэж байна.

Судлаачид үнэн, худал мэдээллийг ялгах алгоритмын олон янзын хэрэглээг онцолж байна. Гэвч олон шинжээч «дан компьютерын алгоритм нь нарийвчлалын 100 хувийн баталгааг өгч чадахгүй» гэдгийг тэмдэглэсэн

байдаг.⁴² ХММСБ-оор олж авсан мэдлэг, ур чадвар, хандлага л хүмүүс мэдээлэл, мэдээллийн эх сурвалж, баталгаажуулалтын илүү найдвартай арга механизм руу дэвшин ахихад тусалдаг.

Мэдээллийн эх сурвалжтай ажиллах нь өнөөдөр тусдаа ур чадвар, туршлага шаардсан чадавх болоод байна. Өнөө цагт веб дээр байгаа их хэмжээний мэдээллийн улмаас шинэ төрлийн ажил, албан тушаал бий болж байна. Үүнд SMM-ийн мэргэжилтэн (Сошиал медиа маркетинг - нийгмийн сүлжээнд бизнесийн маркетинг хийдэг мэргэжилтэн), баримт шалгагч, майнинг мэргэжилтэн (мэдлэг хайгч), мөн зөвхөн Интернэт дэх олон нийт, бүлэглэлүүдийг ажиглах үүрэгтэй сэтгүүлч зэргийг дурдаж болно. Ингээд сэтгүүлчдэд мэдээлэл олж авах, мөн түүнийг шалгах боломж олгодог хэд хэдэн эх сурвалжтай танилцъя.

Цаг үеийн, хамгийн их яригдаж буй сэдэв/ үзэгдлийг хайх нэг арга бол блогийн мониторинг юм. Өнөө үед олон янзын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн олон мэргэжилтэн, олон нийтийн санаа бодлын удирдагчид (POL-public opinion leaders) өөрсдийн вэбсайт, блог хөтөлж байна. Гэвч, ийм эх сурвалжийг болгоомжтой ашиглах шаардлагатай. Учир эдгээр бичвэр дангаараа мэдээллийн бодит, үнэн зөв байдлын баталгаа болохгүй юм. Өөрийн хуудасны үнэлгээ, хэрэглэгчдийн тоог өсгөхийн тулд зохиогч найдваргүй мэдээлэл түгээхэд хүрч болох юм.

Тиймээс шууд итгэж болохгүй, сонирхож буй мэдээллээ ахин дахин, давхар давхар шалгах хэрэгтэй.

55

Нэр хүндтэй бичигчдэд ихэвчлэн сенсац хөөх хэрэг байдаггүй, тэд хөндүүр сэдвийг барьж авч бичдэг, тодорхой сэдвээр мэдээлэл хөтөлдөг, дагагчдын тоогоо нэмэгдүүлэх гэж хичээдэггүй. Тэд бол сэтгүүлчид хайж, уншиж, ашиглах ёстой хүмүүс юм. Үүний хажуугаар уг хаягийн дагагчид болон сэтгэгдэл бичсэн хүмүүсийг судалж, зарим мэдээллийг батлах/ үгүйсгэх эх сурвалжийг олж болно.

Мөн блог ертөнцөд хамгийн их яригдаж буй арван сэдвийг судлах нь чухал юм. Өнөөдөр зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд «Өнөөдөр блогт» гэх мэт тусдаа булан хүртэл бий болгосон байдаг бөгөөд тэнд цахим орчны эрэлттэй сэдвийг нийтэлдэг. Блогийн сайн тал нь тэндээс үйл явдлын талаарх албан ёсны байр сууринаас өөр санал бодлыг олж уншиж болдогт байдаг.

Нийгмийн мэдээллийн сүлжээний мониторинг бол эх сурвалжтай ажиллах бас нэг арга юм. Энэ бол сүүлийн үеийн үйл явдлын мэдээллийг тэр даруй мэдэх боломж. ВКонтакте, Твиттер, Фэйсбуукд үргэлж «уншчихмаар сонирхолтой материал» байдаг бөгөөд үүний үндсэн дээр сэдэв сонгох, дүр, шинжээч олох, болж буй үйл явдлын цар хүрээг ойлгох боломжтой. Сэтгүүлчийн ажилд хувь хүмүүсийн нийгмийн хуудаснаас гадна сүлжээний

42 1 Schifferes, S., Newman, N., Thurman, N., Corney, D., Goker, A. S. and Martin, C. (2014). Identifying and verifying news through social media: Developing a user-centred tool for professional journalists. *Digital Journalism*, 2(3), pp. 406-418. doi: 10.1080/21670811.2014.892747

бүлгүүд (олон нийтэд нээлттэй групп) маш их хэрэгтэй байдаг. Нийгмийн сүлжээний тусламжтайгаар сэтгүүлчид ярилцах хүн олохоос гадна онцгой нөхцөл байдлын үеийн нарийн ширийн зүйл, бусад үйл явдлын тухай нэмэлт мэдээлэл олж мэдэх, тэдгээрийн гэрчийг олж, асууж лавлах, хүмүүсийн намтартай танилцах, нийтлэлд зориулж зураг, видео хайх, засгийн газрын гишүүнээс хүртэл шууд асуулт асуух боломжтой.

Нэг сэдвийн дор цугласан хүмүүс буюу групп (*thematic communities*) гэх мэтийн эх сурвалж нь олон нийтийн санаа бодлыг судлах, санал асуулга явуулахад хэрэгтэй байдаг. Түүнчлэн хамтран ажиллах мэргэжилтэн хайж олоод үе үе тодорхой асуудлын талаар санал бодлыг нь авахад үр дүнтэй.

Өөр нэг чухал Интернэт эх сурвалж бол мэдээллийн сан юм. Энд тавигдсан мэдээлэл нь ихэвчлэн мэдээ биш боловч баримтын талаар дэмжих, эсвэл эргэлзэхэд, тоон болон статистик мэдээ хэрэглэхэд маш их хэрэгтэй байдаг. Мэдээллийн сантай ажиллах чадвар нь аналитик, эрэн сурвалжлах сэтгүүл зүйд чухал ур чадвар юм. Интернэт нь асар их хэмжээний цаасан материалаас мэдээлэл хайж цаг алдахгүй байх, харьцуулалт хийх, динамик, чиг хандлагыг тодорхойлох, эргэлтийн цэгийг олох гэх мэтийг хурдан гүйцэтгэх боломж олгодог.

2.6 ХММСБ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИХ ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

56

ХММСБ-ын хүрээнд сэтгүүлчдийг сургах, мэргэжил дээшлүүлэхэд жендерийн мэдрэмж маш чухал. Хэвлэл мэдээллийн агуулгад жендерийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалт байнга илэрдэг. Энэ нь сэтгүүлчдийг зохих ёсоор бэлтгэдэггүйг харуулж байна.

ЮНЕСКО-гийн «Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн хөгжлийн дэлхийн чиг хандлага» тайланд дурдсанаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэвээр байна.⁴³

ЮНЕСКО-гийн саяхан хэвлэгдсэн “Болдогсон бол би ичих байлаа: боловсролоор дамжуулан дижитал чадварын хүйсийн ялгааг арилгах нь” нийтлэлд дурдсанаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дижитал чадварын ялгаа ноцтой, тогтвортой байгаагийн зэрэгцээ энэ зөрүү ихсэж байна. «Эмэгтэйчүүд ухаалаг утас ашиглах, Интернэт хэрэглэх, нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах, дижитал орчинд мэдээллийг хэрхэн хамгаалах тал тал дээр илүү бага мэдлэгтэй байна.»⁴⁴

Эмэгтэйчүүдийн хэвлэл мэдээлэл, технологийн хүртээмж, оролцооны тэнцвэргүй байдал нь олон үр дагавартай. Хамгийн тулгамдсан хоёр

43 UNESCO (2018) World Trends in Freedom of Expression and Media Development, Global Report 2017/2018. UNESCO (Paris). <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000261065>. Accessed on 23 November 2019.

44 West, M., Kraut, R., and Ei Chew. H. I'd blush if I could: Closing Gender Divides in Digital Skills through Education. UNESCO (2019), Paris

асуудал бол онлайн орчинд эмэгтэйчүүдийг дорд үзэх явдал, мөн охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэхдээ шившиглэх, буруутах, дуулиан хөөх хандлага түгээмэл, тэнцвэртэй мэдээлэх зарчим баримтлах нь дутагдалтай, эсвэл бүр баримтлахгүй байна. ЮНЕСКО-оос сэтгүүлчдэд зориулан «Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэх нь» гарын авлагыг хэвлүүлсэн бөгөөд түүнд эдгээр харгис хэрцгий байдлын талаар нэгтгэн оруулжээ.⁴⁵ Энд дэвшүүлсэн санал бол сэтгүүлчдийн ХММСБ-ыг дээшлүүлэх нь эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэлтэй холбоотой яриа хэлэлцээг өрнүүлэх, хэвлэл мэдээлэл, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тустай гэсэн санал юм. ЮНЕСКО-гийн дээрх хэвлэлд дараах сэдвийг багтаасан болно:

- Эмэгтэй сэтгүүлчдийн кибер сүрдүүлэг, онлайн дарамт
- Эрт гэрлэлт эсвэл бага насны гэрлэлт
- Эмэгтэй бэлэг эрхтнийг зэрэмдэглэх/тайрах
- Албадан гэрлэлт
- Хүйсээс шалтгаалсан ургийн болон нярайн аллага
- Бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүчингийн хэрэг
- “Нэр төр бузарласан” гэгч гэмт хэрэг
- Хүн худалдаалах, цагаачдыг хууль бусаар хил нэвтрүүлэх
- Мөргөлдөөний үеийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
- Дотнын хамтрагч эсвэл хуучин хамтрагчийн хүчирхийлэл, гэр бүлийн хүн амины хэрэг

57

ЮНЕСКО-оос хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдтэй хамтран жендерийн мэдрэмжтэй хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан нь “хэрэглэж буй технологиос үл хамааран, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулах зорилготой юм. Гарын авлагад гол анхаарлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх нийгмийн олон янз байдал, үүн дотор тэгш байдал, жендерийн асуудалд хандуулна.”⁴⁶

1995 оны Бээжингийн тунхаглал, Дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурлын үйл ажиллагааны мэдээлэл гарсны дараа ч хэвлэл мэдээллийн салбарт жендерийн тэгш байдлыг хангах хүчин чармайлт орхигдсоор байгаа бөгөөд, энэ чиг хандлагыг өөрчлөхөд сэтгүүл зүйн боловсрол хувь нэмрээ оруулж чадна.

45 Impe, A.-M. (2019). UNESCO (2019). Reporting on Violence against Women and Girls: A Handbook for Journalists. (Ed. Lourenco, M.) UNESCO, Paris.

46 Grizzle, A (2012, Ed.). Gender-Sensitive Indicators for Media. Framework of indicators to gauge gender sensitivity in media operations and content. UNESCO (2012). <https://ru.unesco.org/events/kazakhstan-usilenie-uchebnoy-programmy-po-gendernoy-zhurnalistike>

See also, Gallagher, M. (2014) Feminist scholarship and the debates on gender and communication. In Montiel, V. A. (2014): Media and Gender: A Scholarly Agenda for the Global Alliance on Media and Gender. UNESCO, Paris



Эх сурвалж: Grizzle, A. (2012). *UNESCO Gender-Sensitive Indicators for Media*.

Зохиогч жендерийн асуудлыг хэрхэн харж буйг “Нийлж буй хоёр далай” гэж нэрлэсэн энэхүү зурагт зүйрлэл илэрхийлж байна. Цагаан шугамаар тэмдэглэгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ «хоёр туйлыг» салгаж ч, нэгтгэж ч чадна. Жендерийн мэдрэмжийн үзүүлэлтүүд бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд нэгтгэх зорилгыг хангах лакмусын шалгуур гэсэн үг юм. Эдгээр үзүүлэлт нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шударгаар харуулахад тус болох учиртай. Үүний тулд хэвшмэл ойлголтыг арилгах, жендерийн тэгш байдал, шударга ёсны асуудлыг онцлон харуулах, сурталчилгаа, цэнгээнт агуулгад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг харуулахдаа шударга зарчим баримтлах нь чухал.

ХММСБ-ын үүднээс авч үзвэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх жендерийн мэдрэмж нь соён гэгээрүүлэх үүргийг бас гүйцэтгэх ёстой. Өөрөөр хэлбэл, ХММСБ-ыг жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах хэрэгсэл болгон ашиглаж болно.⁴⁷ Жишээлбэл, сэтгүүлчид жендерийн тэгш байдлыг онцлон тусгахдаа үзэгчдэд урам зориг өгч, энэ асуудалд хүлээцтэй хандах төлөвшлийг суулгах чадвартай байх ёстой.


47 Grizzle, A. (2014). Enlisting media and informational literacy for gender equality and women's empowerment. In Vega Montiel, A. (2014). *Media and Gender: A Scholarly Agenda for the Global Alliance on Media and Gender*. United Nations Educational, Scientific, and Cultural Organization. Paris, France.

Lapayese, Y. V. (2013) Going Against the Grain: Gender-specific Media Education in Catholic High Schools. *Catholic Education: A Journal of Enquiry and Practice*. Volume 15, Issue 2.

Melki, J. and Farah, M. (2014). Educating media professionals with a gender and critical media literacy perspective: How to battle gender discrimination and gender harassment in the media workplace. In Vega Montiel, A. (2014). *Media and Gender: A Scholarly Agenda for the Global Alliance on Media and Gender*. United Nations Educational, Scientific, and Cultural Organization. Paris, France

Жендерийн үзүүлэлтүүд нь нийгэмд тодорхой хугацаанд гарч буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурийн ялгаа, цаг хугацааны өөрчлөлтийг харуулсан чанарын болон тоон мэдээлэл юм. Энд АНУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх жендерийн олон янз байдлын түвшинд дүн шинжилгээ хийсэн жишээг харуулж байна. Энэхүү судалгаа нь жендерийн олон янз байдал, Америк улсад мэдээллийн редакцад ажилладаг эмэгтэйчүүд, цөөнхийн эзлэх хувийг харуулсан (доорх графикт 2018 оны асуулгын дүнг харуулав).⁴⁸

Зураг 8. Ирээдүйн сэтгүүлчийн ойлгох ёстой жендэртэй холбоотой асуудлын багц



Доорх график нь нөхцөл байдал хэдэн жилийн туршид хэрхэн өөрчлөгдсөнийг харуулж байна. Ийм судалгааг юунд зориулж хийдэг вэ?

Зураг 9. АНУ-ын хэвлэл мэдээллийн байгууллага, редакц дахь жендерийн олон янз байдлын өөрчлөлт



48 How Diverse Are US Newsrooms? https://googletrends.github.io/asne/?fbclid=IwAR3qyKcDsJRd6MMry6tuKgUGPgHswN2Jos1X8luwt6_Cyfbdg3Ci4nwySo&view=0

Яг энэ асуулт манай уншигчдад сонирхолтой байж магадгүй юм. Учир нь редакция дахь жендерийн харьцаа сайжирснаар сэдвийг хөндсөн нийтлэлийн тоо нэмэгддэг байна.

Зураг 10. Ирээдүйн сэтгүүлчийн ойлгох ёстой жендэртэй холбоотой асуудлуудын багц



Жишээлбэл, 2010 онд Блумберг ньос (Bloomberg News) агентлаг сэтгүүл зүйг олон тооны эмэгтэйчүүдээр дүүргэх төслийг эхлүүлсэн бөгөөд тэд хөтлөгч, бизнес, зах зээл, улс төр, засгийн газарт сэтгүүлч, редакторын үүрэг гүйцэтгэх байв. Төслийг санаачлагч “Эмэгтэйчүүд хүн амын тал хувийг эзэлж байгаа боловч дэлхийн эдийн засгийн түүхэн хөгжилд үзүүлсэн тэдний нөлөөллийг дутуу үнэлж байна” гэж ээ⁴⁹

Португалийн WAN-IFRA (Дэлхийн хэвлэн нийтлэгчдийн холбоо)-оос жил бүр зохион байгуулдаг «Эмэгтэйчүүд мэдээлэлд» дээд хэмжээний хоёрдугаар чуулга уулзалтаас хэвлэл мэдээллийн ертөнц дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар сэтгэл гонсойлгосон (гэхдээ сэдэлжүүлсэн?) статистик мэдээлэл нийтэлж, тэдний байр суурийг сайжруулахын тулд Gizmodo, BBC зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын хэрэгжүүлсэн алхмуудын талаар онцолжээ. (WAN-IFRA-ийн “Эмэгтэйчүүд мэдээлэлд” санаачилга нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх жендерийн олон янз байдлын талаарх гарын авлагыг эмхэтгэж, үүнд Ботсванаас Их Британи хүртэлх 10 кэйс судалгааг багтаажээ).

49 https://www.bloomberg.com/distribution/blog/2014-03-07/qa-with-lisa-kassenaar-of-thebloomberg-news-womens-project/?fbclid=IwAR04_tzjkH07xjwA-28DnkjkwEIAOK6LDAOG_I8Jdl3xrQ25SWVjnNNElcc


Энэ сэдвийг судалсан Пойнтер (Pointer)-ийн өөр нэг судлаач хэлэхдээ: “Жил бүр сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр төгсөгчдийн гуравны хоёроос илүү нь эмэгтэйчүүд байдаг. Гэтэл хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын гуравны нэг нь л эмэгтэйчүүд байдаг бөгөөд энэ тоо буурсаар байна гэжээ.”⁵⁰

Жендерийн статистик бол хийсвэр эсвэл бодит ертөнцөөс тусгаарлагдсан салбар биш. Харин ч эсрэгээрээ эдийн засаг, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн статистик гэх мэт бусад бүх салбартай холбоотой чиг хандлагыг илэрхийлдэг юм. Хүйсийн статистик нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзэлж буй байр суурийн ялгааг судлах боломжийг олгодог. Энэ статистик жендерийн асуудлыг шийдвэрлэх, жендерийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулахад хэрэгтэй.

Жендерийн мэдрэмжийн асуудал нь бодит байдлыг зөв тусгах, хэвлэл мэдээллийн мэдлэгийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг дээр дурдсан зүйлс харуулж байна.

Тодорхой сэдвийг сурвалжилж буй сэтгүүлчид жендерийн тодорхой үзүүлэлтийн шүүлтүүрээр нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чадвартай байх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл жендерийн зохистой сэтгэлгээ, жендерийн тэгш байдлыг бий болгоход шууд болон шууд бусаар нөлөөлдөг тул хэвлэл мэдээллийн тодорхой нийтлэлийг судлахдаа дараах зүйлийн талаар бодох нь чухал юм.

Зураг 11. Хүйсийн мэдрэмжийн өргөн хүрээний үзүүлэлтүүд



Эдгээр жижиг үзүүлэлт нийтлэлийн жендерийн мэдрэмж болон редакцад жендерийн тэнцвэрт байдлыг хэрхэн баримталж байгааг харуулж чадна.

50 York, K. Women dominate at journalism schools but it is a different story at the editorials. <https://www.poynter.org/business-work/2017/women-dominate-journalism-schools-but-newsrooms-are-still-a-different-story/?fbclid=IwAR33hBugKDXTOhT1Ekz3mPPabBe1NePOpnHbufmcguso632muJxlTQQMrc>

Шигтгээ 3.

Зураг 12. Жендерийн тэгш байдлыг сурталчлах зорилгоор ХММСБ-ыг ашиглах тоглоом

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН (ХММСБ) ЧАДВАРАА АШИГЛАДАГ УУ?
ЭНЭ "ШИРЭЭНИЙ" ТОГЛООМЫГ ТОГЛОЖ, ОНООГОО ШАЛГААРАЙ!



ХММСБ-ЫН ЧАДАВХ



БИ ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ДАРААХ ЗҮЙЛИЙГ ХИЙДЭГ



ОНООГОО НЭМЭЭРЭЙ

Мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгцээг ойлгох, тодорхой илэрхийлэх	Хэвлэл мэдээлэл, ном, түүхэнд эмэгтэйчүүд/охиод, эрэгтэйчүүд/хөвгүүдийн тухай мэдээлэл байх ёстой гэдгийг би ойлгодог. Би хөнгөлийн талаарх тайланд (ажилгүйдэл, мэдээллийн хүртээмжийн гэх мэт) эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаар мэдээлэл оруулж байхыг уриалж байна.	6 ОНОО	Мэдээлэл, медиа контентийг эзлэх, цэгцлэх Контентоос авсан санааг нэгтгэх, ашиглах	Би өөрийн туршлагад үндэслэн эмэгтэйчүүд, охидын эрх мэдэл, тэгш байдлыг хангахад саад болж буй хүчин зүйлсийн талаар мэдээлэл цуглуулж, нээлттэй яриа хэлэлцэх хийхэд ашигладаг.	6 ОНОО
Ардчилсан нийгмийн хэвлэл мэдээлэл бусад мэдээллийн үйлчилгээг үзүүлэгчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг ойлгох	Би мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээллийн үйлчилгээг үзүүлэгчид (БМҮҮ) жендерийн тэгш бус байдлыг тэнцэржүүлэх эсвэл улам тэгш бус болгох хүчтэйг ойлгож, хүлээн зөвшөөрдөг. Би жендерийн тэгш бус байдлыг олон нийтэд ойлгомжтой болгохыг хэвлэл мэдээллийнхэнд уриалж байна.	9 ОНОО	Мэдээллийг эрх, үүргийн дагуу ёс зүйтэй ашиглах	Би үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хамгаалдаг. Эрхээ эдлэхтэй зэрэгцээд тодорхой үүрэг, хариуцааг хүлээх хэрэгтэй би хүлээн зөвшөөрдөг. Жишээ нь, хүйсээр нь ялгаварлаж санаатайгаар худал мэдээлэл тараахгүй байх, эсвэл үзэн ядахгүй байх үүрэг.	15 ОНОО
Уг үүргээ гүйцэтгэх нөхцөлийг ойлгох	Би хэвлэл мэдээллийн эрх чөлөө, бүх насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмждэг.	12 ОНОО		Би өөрийн мэдээлэл, хэвлэл мэдээллийн агуулгыг бүтээн чадвар, бие даасан байдалаа хамгаалж байна, үүнд охид, эмэгтэйчүүдтэй холбоотой контент ч хамаардаг.	
Холбогдох мэдээллийг олж авах, хянах	Би жендерийн холбогдолтой мэдээллийг хайж, олж авдаг. Би эмэгтэйчүүдтэй адил тэгш харьцах тухай засгийн газрын мэдээллийг олж авахын тулд мэдээллийн хүртээмжийн тухай хуулиудыг ашигладаг.	9 ОНОО	МХХТ-ийн чадвараа ашиглан мэдээлэл боловсруулах, харилцаачийн үүсгэсэн контент бүтээх чадвартай байх.	Би жендерийн тэгш байдлыг холбоотой сурталчилгааны контент боловсруулж, түгээдэг. 12	12 ОНОО
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, БМҮҮ-ийн мэдээлэл, агуулгыг нэр хүнд, найдавартай байдал, одоогийн зорилго, болонхгүй эрсдэлийн хувьд шүүмжлэлтэй унших	Би сексизм, жендерийн хэвшмэл ойлголтын хоорондын холбоог олохын тулд медиа мессеж, мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг. Би онлайн мэдээллийг шүүн тунгаадаг, мөн болзошгүй эрсдэлээс зайлсхийхын тулд зан үйлээ хянадаг.	15 ОНОО	Хэвлэл мэдээлэл, БМҮҮ-ийг хамтран ажиллаж, өөрийгөө илэрхийлэх, харилцан яриа өрнүүлж, иргэний нэгдсэн байдал, жендерийн тэгш байдал, бүх хэлбэрийн тэгш бус байдлын эсрэг байх гэх мэт.	Би хэвлэл мэдээллийн гол хэрэгсэл, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Интернетэд хандаж, оролцон, жендерийн тэгш байдлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан сурталчлах, ардчилал, соёлд эмэгтэйчүүдийг оролцуулахыг дэмждэг.	16 ОНОО

Нийт оноо: 100

Таны авсан оноонд тулгуурласан үнэлгээ:



30 оноо	Эхлэл сайн байна! Одоо үйл ажиллагаагаа энэ хэвээрээ үргэлжлүүлээд, гурван сарын дараа дахин тоглоорой!
31-50 оноо	Та сайн ахиж байна! Одоо илүү өндөр оноо авахын тулд үсрэнгүй ахиж, гурван сарын дараа дахин тоглоорой.
51-70 оноо	Маш сайн гүйцэтгэл! Та үнэхээр ХММСБ-ээр дамжуулан жендерийн тэгш байдлын талаар харилцан ярианд оролцож байгаа юм байна. Цаашлаад шинжлэх юм уу мэргэжилтэн болбол яаж байна? Дараа дахин тоглоорой.
71 оноо түүнээс дээш	Онц сайн гүйцэтгэл! Та бол шинжлэх, мэргэжилтэн юм байна. Одоо үе тэнгийн сургагч болж, бусдад туслаарай.

2.7. НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЭРИНД МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ НЬ

Нээлттэй өгөгдөл гэдэг нь төрийн байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Интернэтэд ахин дахин ашиглах боломжтой байх зорилгоор машинд уншигдах форматаар байршуулсан мэдээлэл юм. Тиймээс нээлттэй өгөгдөл бол хэн ч чөлөөтэй олж, ашиглаж, түгээх боломжтой мэдээлэл юм.

Нээлттэй өгөгдөл нь дараах шинж чанарыг агуулах ёстой:

Хандах, унших боломжтой: бүх мэдээллийг хайлтын хүсэлтээр олж, хандахад хялбар, олдсон мэдээллийг хэрэглэгч компьютер дээрээ боловсруулах боломжтой байх ёстой.

Дахин ашиглах, түгээх: Мэдээллийг чөлөөтэй ашиглах, түгээх боломжтой байна. Ганц нөхцөл бол эх сурвалжийн холбоосыг дурдах явдал юм. Үүнээс гадна, өгөгдлийг ашиглах үед гажуудуулж болохгүй.

Бүх нийтийн оролцоо: Мэдээлэлд хандах, ашиглах үед аливаа ялгаварлан гадуурхал байх ёсгүй.

Бүрэн дүүрэн, цаг үеийн байх: мэдээллийн сан нь бүрэн дүүрэн (өөрөөр хэлбэл объектив дүр зураг гаргах) болон цаг үеийн (хуучраагүй) мэдээллээр хангах ёстой.

63

Өгөгдөлтэй ажиллахад шаардагдах чадвар:

- Англи хэлний мэдлэг
- Онлайн хайлтын систем хэрхэн ажилладаг тухай ойлголт
- Хүснэгттэй ажиллах чадвар. MS Excel төрлийн программд их хэмжээний дижитал болон текст өгөгдлийг боловсруулах чадвар
- Математик, статистикийн мэдлэг
- Хууль эрх зүйн мэдлэг

Орчин үеийн технологи ашиглах чадвартай байх нь сэтгүүлч, идэвхтэн, ТББ-ын ажилтнуудад ихээхэн давуу тал олгодог. Өнөө үед энэ нь сонголт байхаа больж, зайлшгүй шаардлага болсон байна. Сонирхолтой, орчин үеийн сэтгүүл зүйн/ нийтлэл/ мэдээллийн материал бүтээх, сэтгүүл зүйн эрэн сурвалжилга хийх, тэр ч байтугай сурталчилгааны кампанит ажил явуулах нь шинэ хандлага, шинэ мэдлэг шаарддаг.

Өнөөдөр сэтгүүлч хүн ямар нэг хэмжээгээр технологийн мэдлэгтэй байх ёстой бөгөөд үүнийгээ илүү чөлөөтэй, хараат бус байдлаар ашиглаад зогсохгүй техникийн мэргэжилтнүүдтэй «өөрсдийнх нь» хэлээр харилцах чадвартай байх ёстой юм. Программчлалын хэлний анхан шатны мэдлэгтэй байх нь дэлхий даяар сэтгүүлчдийн стандарт болж байна. HTML хэлний мэдлэг, программчлалын хамгийн энгийн хэл болох “R” хэлийг ашиглан программчлах чадвар бол сэтгүүлчийн шинэ түвшний эрх чөлөө, хараат бус байдал юм.

Дасгал 4.

1. Энэ хүснэгтийг MS Excel программд оруул.

ДНБ-ий үйлдвэрлэл эдийн засгийн үйл ажиллагааны төрлөөр

	Тэрбум сум		Биет	ДНБ-ий
	1-6 сар, 2018	1-6 сар, 2019	эзлэхүүний индекс, %	өсөлтөд нөлөөлөх, %
ДНБ-нийт	175367,5	222022,0	105,8	5,8
Үүнд:				
Нийт нэмүү өртөг (ННӨ)	153273,9	199857,5	105,8	5,1
ХАА, ойн аж ахуй, загасны аж ахуй	41767,0	48552,4	102,1	0,5
Аж үйлдвэр	41548,5	60601,6	106,9	1,6
Барилгын салбар	11226,7	15215,9	120,0	1,3
Худалдаа, байр, хоолны үйлчилгээ	12178,2	14360,7	104,1	0,3
Тээвэрлэлт, хадгалалт, мэдээлэл, харилцаа холбоо	14170,4	16401,6	102,1	0,4
Бусад үйлчилгээний салбар	32383,1	44725,3	105,4	1,0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	22093,6	22164,5	105,9	0,7

- ДНБ-ий хэмжээгээрээ хамгийн өндөр хөгжилтэй гурав, буурай хөгжилтэй гурван бүсийг ол.
- Дүн шинжилгээ хий. Ямар өгөгдлийг харьцуулж болох вэ, ямар шалгуураар? Дүгнэлт гарга.

Жишээ: Узбекистан улсын статистик мэдээлэл, бусад мэдээлэл авахад дараах эх сурвалж хэрэг болж болно.

- Статистикийн агентлаг - <https://stat.uz/ru/>
- Дэлхийн банкны мэдээлэл - <http://databank.worldbank.org/data/home.aspx>
- Олон улсын байгууллагын мэдээлэл - <https://stat.uz/ru/ofitsialnaya-statistika/>
- [mezhdunarodnaya-statistika/mezhdunarodnye-statisticheskie-sluzhby](https://stat.uz/ru/mezhdunarodnaya-statistika/mezhdunarodnye-statisticheskie-sluzhby)

2.8. МЭДЭЭЛЛИЙГ ДҮРСЖҮҮЛЭХ: СЭТГҮҮЛ ЗҮЙН ШИНЭ ОНЦЛОГ

Орчин үеийн сэтгүүлчийн ажилд дүрсжүүлсэн контент ашиглахын ач холбогдол улам бүр өндөр болж байна. Энэ нь ийм хэлбэрийн мэдээллийг ойлгож хүлээн авах нь илүү хялбар байдагтай холбоотой юм. Сэтгэл судлалын салбарт хийсэн олон тооны шинжлэх ухааны судалгаагаар хүн физиологийн хувьд нүдээрээ харсан зүйлийг илүү хурдан ойлгож, боловсруулдаг аж (жишээ нь тексттэй харьцуулахад).

Мэдээллийн технологи, ялангуяа компьютер, ухаалаг гар утасны хөгжилтэй холбоотойгоор орчин үеийн хэрэглэгч асар их хэмжээний мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас хүлээн авдаг бөгөөд энэ нь тэдний хүлээн авч ойлгох чадварт нөлөөлдөг.

Өнөөдөр бид ихэнх мэдээллийг хаанаас авч байгааг та анзаарсан уу? Тиймээ, дэлгэцээр: телевизорын дэлгэц, компьютерын дэлгэц, утасны дэлгэц гэх мэт. Тэр ч байтугай сониныг ч бид одоо дэлгэцээс уншдаг. Энэ хандлага цаашид ч үргэлжилнэ. Гэвч харилцаа холбооны суваг өөрчлөгдөхөд мэдээллийг хүлээн авч ойлгох зан үйл ч өөрчлөгддөгийг тэмдэглэх нь зүйтэй.

Дэлгэцээс мэдээлэл хүлээн авч ойлгох үйл явц уншихаас илүүтэйгээр текстийг гүйлгэж харах, ерөнхийд нь үзэхэд суурилдаг. Түүнчлэн, цааш дэлгэрэнгүй унших материалыг сонгоход ч урьдчилан гүйлгэж үздэг тул ийм үед дүрс дагалдуулж байж л хүний анхаарлыг татах боломжтой болдог. Тийм ч учраас өгөгдлийг дүрсжүүлэх нь өнөөдөр асар их ач холбогдолтой болсон.

Дүрсжүүлэлт гэж юу вэ? Мэргэжилтнүүд дүрсээр харилцахыг “нэг талаас харааны хэлээр (зураг, тэмдэг, дүрс, хэвлэмэл, инфографик) харилцах (мэдээлэл дамжуулах), нөгөө талаас хараагаар мэдээлэл хүлээн авч ойлгох (харааны эрхтэн, хүртэхүйн сэтгэл зүй) үйл явц гэж тодорхойлдог.”⁵¹

Орчин үеийн мэдээллийн хэрэглэгч нь нүдэнд харагдах хэд хэдэн объектод анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд энэ нь өнөөдөр өгөгдлийг үзүүлэх хамгийн үр дүнтэй аргын нэг юм. Дүрсжүүлэлт нь агуулгыг бүрэн ойлгох үйл явцыг гүнзгийрүүлж, ойлгоход хэцүү өгөгдлийг хурдан бөгөөд тодорхой тайлбарладаг. Чадварлагаар бүтээсэн дүрс нь текстээр илэрхийлэхэд хэцүү мэдээллийг гэрэлтүүлэн тодруулж өгдөг.

Сэтгүүлчид, олон нийттэй харилцах мэргэжилтнүүд түгээмэл ашигладаг хамгийн уламжлалт дүрсжүүлсэн контентыг дурдвал:

- тайлбар зураг;
- гэрэл зураг;
- инфографик (график, хүснэгт, диаграмм гэх мэт);
- мультимедиа контент (видео, клип, флаш хөдөлгөөнт дүрс, слайд шоу, флаш танилцуулга гэх мэт);
- орчин үеийн дүрсжүүлсэн контент (мийм, селфи).

51 Rodkin, P. Visual communications // <http://www.prdesign.ru/text/2010/visual-communications.html>

Цогц агуулгыг танилцуулах хамгийн түгээмэл бөгөөд үр дүнтэй аргын нэг бол инфографик юм. Инфографик гэдэг нь нэгдүгээрт, дүрсний элемент, хоёрдугаарт, дүрсний элементийг тайлбарласан текст бүхий мэдээлэл юм. Мэдээллийн ийм хэлбэр нь сэдвийн талаарх ойлголтыг бүрдүүлж өгдөг гэж хэлж болно.⁵²

Инфографик нь сэдвийн хамааралтай, сонирхолтой, утга учиртай байх мөн их хэмжээний мэдээллийг уншиж, ойлгоход хялбар байдлаар дүрслэх ёстой юм.⁵³

Инфографик контент нь дараах элементийг агуулж болно:

- диаграмм
- график
- хүснэгт
- карт
- Альтернатив инфографик — тайлбар зураг.⁵⁴

Дүрсжүүлсэн контент түгэн дэлгэрэхэд түлхэц болсон нэг хүчин зүйл бол нийгмийн мэдээллийн сүлжээний хурдацтай хөгжил юм. Энэ үед олон эх сурвалжаас асар их мэдээллийн урсгал бий болсноор сэтгүүлчид, уншигчид, захиалагчид, дагагчид энэхүү мэдээллийн шинэ орчинд дасан зохицох хэрэгтэй болсон. Мэдээллийн урсгал нэмэгдэх хэрээр хүмүүс текст уншихад улам л бага цаг зарцуулах болж, 140 тэмдэгтэд багтсан товч мессеж (Твиттер) уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хүчтэй өрсөлдөх болов.

66 Өмнөх даалгавар руу буцаж очъё. Статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийсний дараа уг тоог дүрсжүүлэн харуулах график шийдлийг олох гээд үзээрэй. Энэ нь диаграмм, дугуй диаграмм, пирамид гэх мэт байж болно.

ДНБ-ий үйлдвэрлэл эдийн засгийн үйл ажиллагааны төрлөөр				
	Тэрбум сум		Биет	ДНБ-ий
	1-6 сар, 2018	1-6 сар, 2019	эзлэхүүний индекс, %	өсөлтөд нөлөөлөх, %
ДНБ-нийт	175367,5	222022,0	105,8	5,8
Үүнд:				
Нийт нэмүү өртөг (ННӨ)	153273,9	199857,5	105,8	5,1
ХАА, ойн аж ахуй, загасны аж ахуй	41767,0	48552,4	102,1	0,5
Аж үйлдвэр	41548,5	60601,6	106,9	1,6
Барилгын салбар	11226,7	15215,9	120,0	1,3


52 Muratova, N. Characteristics of Visual Information and Its Impact on the Audience. Materials of the workshop on Internet journalism. Т.: 2016.
 53 Buzinova A.A. Visual content of modern PR text. // Mediascope, an electronic scientific journal. Issue №4. 2013 <http://www.mediascope.ru/issues/477>
 54 The course on visual journalism at Stanford University «Journalism in the Era of Data // <http://datajournalism.stanford.edu/>

Худалдаа, байр, хоолны үйлчилгээ	12178,2	14360,7	104,1	0,3
Тээвэрлэлт, хадгалалт, мэдээлэл, харилцаа холбоо	14170,4	16401,6	102,1	0,4
Бусад үйлчилгээний салбар	32383,1	44725,3	105,4	1,0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	22093,6	22164,5	105,9	0,7

Статистик материалыг дүрсжүүлэхээр бэлтгэхдээ дүрсжүүлэлтийн гол зорилго бол мэдээллийг хүлээн авч ойлгоход хялбар, хурдан болгох явдал гэдгийг санах нь чухал юм. Сонгосон формат, графикийн төрөл нь үүнд нэмэр болох ёстойгоос саад болж болохгүй.

Жишээлбэл, дугуй диаграмд 3-5 тооноос дээш тоо орж байвал графикийг унших боломжгүй болно. Энэ тохиолдолд ердийн баганаан график сонгосон нь дээр. Дугуй диаграмм амжилтгүй болох өөр нэг тохиолдолд бол категорийн нийлбэр 100% биш байх явдал юм. Энэ тохиолдолд өгөгдөл гажуудах тул энэ нь бүдүүлэг алдаа болно.⁵⁵

График 3. Дүрсжүүлэх хэлбэр, форматыг зөв сонгох нь чухал.



Орчин үед инфографик бүхий материал нийтлэхийн тулд тусдаа сервер, эсвэл мэдээллийн технологийн нарийн зохион байгуулалт шаардлага үгүй, өндөр мэргэжлийн программчлагч, дизайнеруудаас бүрдсэн том бүрэлдэхүүн ч хэрэггүй. Үнэхээр том төсөлд (жишээ нь “Панамын баримт бичиг” эсвэл “Эмч нарт зориулсан доллар”) бол мэдээллийн технологийн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг ажиллуулах шаардлагатай нь үнэн. Гэхдээ бэлэн байгаа аппликэйшн, шийдлүүдийг мэддэг, ашиглаж чаддаг сэтгүүлчид хэзээд давуу байдалтай байх болно.

⁵⁵ Bazaleva, O. 11 rules of data visualization. <https://habrahabr.ru/company/netologyru/blog/341364/>


Даалгавар: дүрсжүүлсэн материал бэлтгэх дараах үйлчилгээг үзээд, тус бүрд нь дүн шинжилгээ хий. Тус бүрд нь дүйцэх тохирлыг олоорой.

Infogram Pictochart.com	Цаг хугацааны зурвас
Timeline JS	Өдрийн тоо Баримт ба тоо Инфографик Дүрсжүүлэлт Энгийн хүснэгт
Jpen Street Map	Үгийн үүл (Word cloud) Асуулт-хариулт Google Maps Animaps.com Толь бичиг Шалгах хуудас Холбоос сонгох
Tagul.com	Статик газрын зураг
Tagxedo.com	Интерактив газрын зураг Аяллын хөдөлгөөнт газрын зураг
Storymap JS	Газрын зураг ба цаг хугацааны зурвас Эшлэлийн түүвэр Рейтинг

Зураг 13. Инфографикийг хийхэд хэцүү байдлын түвшин



Хийхэд хэр хэцүү байхаас хамааран инфографикийг программчлалын тусламжтайгаар боловсруулж болно. Ердийн статик инфографик бүтээхэд маш хялбар бол программ хангамжийн тусламжтайгаар түүнийг гурван хэмжээст болгон хувиргах боломжтой.



III ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛ
БА ПРАКТИК СЭТГҮҮЛ ЗҮЙ

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа Интернэтийн орчинд ажиллаж буй мэдээллийн хэрэгсэл ХММСБ-ыг бүх нийтийн иргэний боловсролын хөдөлгөөн болгон сурталчлахад голлох үүргийг гүйцэтгэх учиртай. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хараат бус, олон ургалч байдлыг сахин хамгаалах нь чухал хэдий ч, хараа бус байдлаа алдахгүйгээр оролцогч талуудтай үр дүнтэйгээр хамтран ажиллах боломж бий. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (радио, телевиз, сонин) болон бусад контент нийлүүлэгчид ХММСБ-ын асуудлыг олон нийтийн анхааралд байнга байлгаж, иргэдийн мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцах бүхий л чадварыг хөгжүүлэхэд тусалж чадна. ХММСБ-ыг сурталчлах замаар хэвлэл мэдээллийнхэн үзэгч, уншигч, сонсогчидтой харилцаагаа бэхжүүлж, тэдний хэрэглээний дадал зуршлыг сайжруулж, улмаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бий болгох ёстой.

Үүний тулд суурин газрын төдийгүй хөдөө орон нутгийн иргэдэд зориулан хөгжүүлж, өргөн хүрээнд ашиглаж болох агуулга, хөтөлбөрийн хязгааргүй олон сонголт бий.

3.1 ХММСБ СЭТГҮҮЛ ЗҮЙД ЯАГААД ЧУХАЛ ВЭ? ХММСБ-ООР ДАМЖУУЛЖ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ИТГЭХ ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТУХАЙ

Вох 4. ХММСБ сэтгүүл зүйд яагаад чухал .вэ?

70

Эх сурвалж: Өргөн нэвтрүүлгээр ХММСБ, хэрэглэгчийн контентыг дэмжих ЮНЕСКО-гийн удирдамжаас. Мартин Скотт (2019)

1. Шүүмжлэлт мэдээлэл, мэдээллийн хэрэгсэл, технологи болон хэрэглэгчдийг дэмжинэ

- Зарим жишээг доор болон гарын авлагын бусад хэсгүүдээс үзэж болно.

2. Хэвлэл мэдээлэлд итгэх итгэл үнэмшлийг бий болгоно

- Хэвлэл мэдээллийн хэрэглэгчидтэй харилцаа холбоогоо өргөжүүлж тэдний итгэл, үнэнч байдлыг бэхжүүлнэ.
- Хүмүүсийн хүсэл сонирхолд илүү идэвхтэй хариу үйлдэл үзүүлнэ.
- Иргэд хэвлэл мэдээллийн боловсролтой бол чанартай мэдээллийн эрэлт хэрэгцээ илүү өндөр байх болно. Энэ нь сэтгүүл зүйд төдийгүй хэвлэл мэдээллийн бизнест тустай.

3. Иргэдийн дуу хоолойг дэмжинэ

- Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн олон ургалч байдлыг хүлээн зөвшөөрч, дэмжинэ.
- Дуу хоолойгоо илэрхийлж чадаж байгаа болон чадахгүй байгаа иргэдийн оролцооны ялгааг багасгана.
- Хэрэглэгчдийнхээ талаар илүү сайн мэдлэг ойлголттой болно.
- Хэрэглэгчидтэй идэвхтэй харилцаж, тэдний санал бодлыг илүү

харгалздаг болно.

- Үзэгч, сонсогч, уншигчдыг контент бүтээх мэдлэгтэй болгох нь тэдэнд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад аль алинд нь тустай.
- Зарим үед сэтгүүлчид тэр бүр олж авч чадаагүй мэдээлэл, зураг дүрсийг иргэдээс шуурхай авч мэдээлэлдээ ашигласнаар хэвлэл мэдээллийн зах зээлд онцгой байр суурийг эзлэх боломжтой.

4. Иргэдийг ардчиллын үйл явцад идэвхтэй оролцоход нь дэмжинэ

- ХММСБ нь ардчилалд амин чухал учир хэвлэл мэдээллийн хувьд ХММСБ-ыг дэмжих нь түүний үндсэн үүрэгт багтана.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ХММСБ-ыг дэмжиж, түгээн дэлгэрүүлснээр олон нийтийн хэлэлцүүлэгт иргэдийг татан оролцуулахад гол үүргийг гүйцэтгэнэ.

5. Ирээдүйн хэрэглэгчдээ дэмжинэ

- Бүтээлчээр контент бэлтгэх чадварыг хөгжүүлэх нь хэвлэл мэдээллийн ирээдүйн хөгжилд тустай.
- Мэдээллийн олон төрлийн талаарх мэдлэг, ойлголттой иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж буй контентыг үнэлэх чадамж илүү өндөр байна.

6. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол найдвартай эх сурвалж хэмээх ойлголтыг бий болгоно.

- Хэвлэл мэдээллийн байгууллагууд ХММСБ-ын тухай агуулгыг нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын хүрээнд тогтмол түгээн дэлгэрүүлснээр нийгмийн сайн сайхны төлөө ажилладаг найдвартай эх сурвалж гэх итгэл үнэмшлийг хэрэглэгчдийн дунд бий болгоно.
- Энэ нь тухайн сувгийн хэрэглэгчдийн хүрээг өргөжүүлэхэд тустай.

71

Вох 5. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ХММСБ-ыг үйл ажиллагаанд аа хэрхэн нэвтрүүлэх вэ

Эх сурвалж: Өргөн нэвтрүүлгээр ХММСБ, хэрэглэгчийн контентыг дэмжих ЮНЕСКО-гийн удирдамжаас. Мартин Скотт (2019)

1. ХММСБ-ын стратеги төлөвлөгөөг дотооддоо хэрэгжүүлэх

- ХММСБ, хэрэглэгчдийн контентыг дэмжин түгээн удирдамжийг баталж, дагаж мөрдөх
- Хэрхэн ажилладаг тухайгаа олон нийтэд тайлбарлаж, үйл ажиллагааныхаа ил тод байдлыг нэмэгдүүлэх
- Олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх үүргийнхээ хүрээнд алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх, нягт нямбай мэдээлэх редакцын бодлого хэрэгжүүлэх

- Үндэсний хэмжээний мэдээллийн хэрэгслийн бодлого, агуулгад ХММСБ-ын асуудлыг хэр их хөндөж буйг шинжлэн дүгнэх

2. Хэрэглэгчдэд ХММСБ олгох

- Хэрэглэгчдийн ХММСБ-ыг дээшлүүлэх нь байнга, олон түвшинд хэрэгжих үйл явц юм.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн ач холбогдлыг иргэдэд ойлгуул. Хэвлэл мэдээллийн үнэ цэнийг мэддэг иргэд үнэнч хэрэглэгч байхаас гадна хөндлөнгийн нөлөөлөл, цензурын эсрэг тэмцэх шаардлагатай үед дэмжигч тань байна.

3. Иргэдэд контент бүтээх, санаа бодлоо илэрхийлэх боломж олго

- Уншигчийн булан, мультимедиа хөтөлбөртэй болж, тэдэнд өөрийгөө илэрхийлэх боломж олго.
- Видео хэрхэн бүтээх, мэдээ, өгүүлэл хэрхэн бичих тухай зэргийг зааж, хэрэглэгчдээ чадавхжуулах видео контент бэлтгэж түгээ.
- Ялангуяа залуу хүмүүст камер ашиглах, зураг тест засварлах, мэдээ бичих зэргийг заах үйл ажиллагааг санаачил.
- Мэдээллийг хэрхэн нягтлан шалгах тухай контент бэлтгэж түгээ.

4. Хэвлэл мэдээллийн хэрэглэгчидтэй харилцаа холбоогоо бэхжүүл

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон үзэгч, сонсогч, уншигчдын харилцаа холбооны давуу ба сул талыг ойлгуул.
- Мэдээлэл авах, санал шүүмжлэл илэрхийлэх үр дүнтэй механизм бий болгож, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дэмжих замаар тэдний ХММСБ-ыг дээшлүүл.
- Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын дунд ХММСБ-ын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, хэвлэл мэдээллийн талаарх иргэдийн боловсролыг дээшлүүлэхэд татан оролцуул.

5. Ялангуяа орон нутаг, алслагдмал газрын иргэд, орхигдсон бүлгүүдэд хүрч тэдний ХММСБ-ыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах олон янзын боломж бий. Жишээлбэл:

- Орон нутгийн болон хүйн хэвлэл мэдээллийн байгууллага, нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Интерактив сэтгүүл зүйг хэрэгжүүлэх
- Орон нутгийн иргэдэд сургалт, үйл явдал зохион байгуулах
- ХММСБ-ыг сурталчилж, иргэдийн мэдлэг ойлголтыг сайжруулах аян өрнүүлэх
- Залуучууд болон сэтгүүлчдийн сүлжээ байгуулах

Воп 6. Дэлхийн бусад улс оронд хэвлэл мэдээллийн байгууллагууд ХММСБ-ыг хэрхэн дэмжиж байна вэ?


- Хийж байгаа ажлаа болон учир шалтгааныг нь иргэдэд тайлбарла. Buzz Feed News саявтар ёс зүйн дүрмээ шинэчилж, юуг яагаад өөрчилснөө олон нийтэд тайлбарласан. Тийнхүү ёс зүйн хэм хэмжээгээ нарийвчлан тайлбарласнаар иргэдэд тэдний эрх ашгийг ямар өндөр хэмжээнд хүндэтгэж, хамгаалахын төлөө ажилладгаа ойлгуулах боломжийг ашиглажээ.
- ХММСБ-ыг дэмжих зорилгоор сургуулиудтай хамтран ажиллах. Чех улсад хэвлэл мэдээллийн боловсрол нь ерөнхий боловсролын албан ёсны сургалтын хөтөлбөрт багтсан байдаг. Тиймээс сэтгүүлчид сургуулиудтай хамтран ажиллаж, сэтгүүл зүйн мэдээ бэлтгэх үйл явц, редакцын үйл ажиллагааг тайлбарлах, мөн мэдээллийг гуйвуулах ямар боломж байдгийг ойлгуулж өгдөг.
- Бичих, нягтлан шалгах арга зүйг заах: New York Times баримтыг нягтлан шалгах тухай тусгай булан нээж, олны танил хүмүүсийн хэлсэн зүйлсийг нягтлахаас гадна уншсан, сонссон зүйлдээ шууд итгэхгүй байхын чухлыг таниулдаг аж.
- ХММСБ-ын талаарх яриа хэлэлцүүлэгт оролцох. Жишээлбэл Зүүн Өмнөд Европ болон Турк улсад хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сэтгүүлчид ХММСБ-ын бодлого, стратегийн асуудал хэлэлцэх үндэсний зөвлөлдөх уулзалтуудад идэвхтэй оролцдог аж.
- Сургалтын нэвтрүүлэг бэлтгэх, түгээх: Зүүн Европын олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд ХММСБ-ын сургалтын нэвтрүүлгүүдийг хөтөлбөртөө багтааж цацаж байна.
- Залуучуудын контент бүтээх ур чадварыг дээшлүүлэх: Global Girl Media хэмээх санаачилга Их Британи, Косово, Өмнөд Африк, Марокко зэрэг улсуудад түгэн дэлгэрчээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд 16 – 25 насны охид бүсгүйчүүдэд сургалт явуулж, видео контент бүтээх, засварлах, бичих зэргийг зааж, өндөр түвшний контент бүтээхэд нь дэмжлэг үзүүлдэг аж.
- Al Jazeera сэтгүүлчдийн баг Йордан улсын Заатари дахь дүрвэгсдийн төвд арван хоног ажиллаж, өсвөр үеийнхэнд 360 видео контент хэрхэн бүтээхийг зааж өгсөн байна. Ингэснээр дүрвэгсдийн өдөр тутмын амьдралыг харуулсан бодит түүхийг сургалтад оролцогсод бүтээжээ.
- EBU (Европын Өргөн Нэвтрүүлгийн Холбоо) залуучуудын дунд сэтгүүл зүйн сургалт зохион байгуулах дэмжлэгийг гишүүддээ олгодог.
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах омбудсманыг дэмжих
- Snapchat, Instagram зэрэг нийгмийн мэдээллийн сүлжээний суваг ашиглаж залуучуудыг татан оролцуулах. The Economist болон The Telegraph зэрэг томоохон хэвлэл Instagram, Snapchat-ыг ашиглаж, сонирхолтой агуулга түгээхийн сацуу залуу хүмүүсийг өөрсдийн тухай бичих, хэлэлцэж буй сэдвээр санал бодлоо илэрхийлэхийг уриалдаг аж.

- Тоглоомын аргаар худал мэдээлэлтэй хэрхэн тэмцэхийг залуу хүмүүст заах: Их Британийн BBC өргөн нэвтрүүлэг iReporter хэмээх тоглоомын тусламжтайгаар мэдээллийг шүүн тунгаах, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, мэдээллийн эх сурвалжаа шалгахын чухлыг ойлгуулах, ямар эх сурвалжид итгэж болохыг олж мэдэх, нийгмийн мэдээллийн сүлжээг мэдээлэл олж авахад ашиглахын давуу болон сул талыг ухааруулахыг зорьдог аж.
- *Hashtag Our Stories — HoS* — Мэргэжлийн сэтгүүлчид олон нийттэй хамтран ажиллах энэхүү төслийн хүрээнд иргэд бичлэг хийж олон нийтийн мэдээллийн сүлжээгээр, тухайлбал Snapchat Discover болон бусад платформоор илгээж, мэргэжлийн редакц тухайн агуулгыг шалгаж, засварлаж, нийтэлдэг. Тэдний зорилго бол ухаалаг утсаар гайхалтай бичлэг хийх, мэдээллийн үндсэн хөтөлбөрт байнга гараад байдаггүй амьд түүхийг өгүүлэх чадвартай иргэний сэтгүүлзүйг дэмжих явдал юм.
- АНУ-ын Олон нийтийн телевиз PBS нь онлайн сувгаараа багш, сурагчдын хэвлэл мэдээллийн мэдлэгийг хөгжүүлэх булан байршуулсан байдаг.
- *Нэг өдөр, нэг асуулт*— Франс ТВ-ийн энэхүү нэвтрүүлгээр өдөр бүр цаг үеийн мэдээтэй холбоотой хүүхдийн асуултад нэг минут гучин секундэд багтааж хариулдаг. Тийнхүү тайлбарлан хариулахдаа үргэлж хөнгөн, хөгжилтэй хариулт өгөх бөгөөд хүүхдэд учир шалтгааныг олох, өөрийн үзэл бодолтой болоход нь туслах зорилготой аж.
- *Сэтгүүлч үү? Амаргүй шүү!* Франс ТВ-ийн энэхүү санаачилга нь сэтгүүлчийн ажил мэргэжлийн янз бүрийн талыг танилцуулж, тайлбарлан, мэдээллийн хурд, салбарын эдийн засгийн бодит байдал, олон нийтийн хүлээлт зэрэг нь энэхүү мэргэжлийг шууд утгаараа хэрхэн өөрчилснийг үзэгчдэд ойлгуулахыг зорьдог.
- *“La Collab de L’Info”* буюу *“Мэдээллийн хамтын ажиллагаа”* хэмээх Франс ТВ-ийн энэхүү онцгой нэвтрүүлэгт уг телевизийн олны танил арван таван сэтгүүлч YouTube-ийн арван таван инфлуэнсэртэй хамтран ажиллаж хэвлэл мэдээллийн суурь мэдлэг олгох агуулга бэлтгэдэг.

Эдүгээ хэвлэл мэдээлэлд итгэх итгэл үнэмшлийн асуудал хамгийн эмзэг хэцүү зүйл болоод байна. Уншигч/үзэгч/сонсогч мэдээллийн урсгалд хөтлөгдөн, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үнэнч хэрэглэгч байхаа больж байна. Энэхүү хувирамтгай байдал нь хэрэглэгчдийн анхаарал сонирхол, улмаар тэдний итгэлийг алдахтай адил юм. Үзэгчдийн үнэнч байдал, итгэл үнэмшлийн өөрчлөлт нь мэдээллийн хэт их нийлүүлэлтээс үүдэлтэй гэж хэлж болно. Гэсэн хэдий ч мэдээллийн хэрэглээний шинэ жишгийг бий болгож, хүн амын мэдээллийн соёлыг төлөвшүүлснээр үзэгч, сонсогч, уншигчдын итгэлийг эргэн олж авах боломжтой байж болох юм. Энэ талаар доор дэлгэрэнгүй тайлбарлав.

Өмнө дурдсанчлан мэдээллийн соёл нь хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын чухал бүрэлдэхүүн бөгөөд хүн төрөлхтний соёлын нэг хэсэг юм. Үүнийг “мэдээллийн ертөнцийг үзэх үзэл, мэдлэг, ур чадварын тогтолцоо нь уламжлалт болон шинэ мэдээллийн технологийг ашиглан хувь хүний мэдээллийн хэрэгцээг оновчтой хангах зорилготой бие даасан үйл ажиллагаа”⁵⁶ гэж тодорхойлж болно. Хэвлэл мэдээллийн соёл нь үүнтэй нягт холбоотой бөгөөд хэвлэл мэдээллийн салбарын материаллаг болон оюуны үнэт зүйлсийн цогц юм.

Зураг 14. ХММСБ-ын бүрэлдэхүүн



“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛ = ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭС ХАМГААЛАХ + ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙГ ЗАДЛАН ШИНЖИХ = ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДЛЫГ ОЙЛГОХ + ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СОЁЛЫН ИДЭВХТЭЙ ОРОЛЦОО”⁵⁷

Уншигч, үзэгчдийн анхаарлын төлөөх тэмцэл дунд хэвлэл мэдээллийнхэн янз бүрийн хууль ёсны болон хууль бус бүх арга зам, тухайлбал худал мэдээллээр анхаарал татах аргыг хэрэглэдэг. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн тухай мэдлэгтэй хэрэглэгчид шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх чадвартай байх үед энэ нь эргээд нэр хүндтэй, мэргэжлийн хэвлэл мэдээллийнхний итгэлийг олж авах боломжийг олгодог. Иргэдийн шүүмжлэлтэй сэтгэх чадвар, хэвлэл мэдээллийнхэнд итгэх итгэлийг олж авахад үзүүлэх нөлөөллийн жишээн дээр үүнийг авч үзье.

56 N.I. Gendina. Formation of information and media literacy in the conditions of knowledge society: a new UNESCO initiative and the problems of the Russian information of education. // Pedagogy. Psychology. Issue № 1 / 2012. P. 140–161.

57 Vartanova E.L., Zasursky Ya.N. Russian module of media education: concepts, principles, models. // Information society, 2003, № 3. P. 5-10.

Уншигч үзэгчийн чадвар	Хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийн өсөлт
Бодит ба зохиомол агуулга, зар сурталчилгаа болон бусад төрлийн мэдээллийн ялгааг ойлгодог.	Мэргэжлийн хэвлэлд зар сурталчилгаа, төлбөртэй мэдээллийг үргэлж ялгаж өгдөг, редакцын агуулгыг худалдаж авах боломжгүй байдаг тул л мэргэжлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл итгэлцлийн өөр түвшинд тууштайгаар шилжинэ.
Төрөл бүрийн жанр, өгүүлэх арга техникийг мэддэг. Хэвлэл мэдээллийн агуулга нь зохиогч, үйлчлүүлэгчдийн сонголтоос хамаардаг бөгөөд өөр өөр тайлбартай байж болно гэдгийг мэддэг.	Янз бүрийн хэвлэлийн сэтгүүлчдийг таньдаг бөгөөд бичвэрийн чанар нь тухайн хэвлэлд итгэх итгэлийг бий болгодог. Сэтгүүлчид нь нэр хүндтэй, итгэл үнэмшилтэй байдаг тул хэрэглэгчид тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү их итгэдэг.
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн ажилладгийг мэддэг, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үнэлэх, хянах чадвартай. Хэвлэл мэдээллийн бүтцийг мэддэг, медиа контентын мөн чанарыг таних чадвартай	Энэ нь тухайн редакцад бусдын анхаарлыг татахын тулд хямд арга техник ашигладаг нэг өдрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс ялгарах боломжийг олгодог. Үүний үр дүнд энэ хэрэгсэлд итгэх итгэл нэмэгддэг.
Хэвлэл мэдээллийн хэрэгслийн түгээж буй агуулгад шүүмжлэлтэй хандаж, хэвшмэл үг хэллэгийн үр дагаврыг ойлгодог	Уншигч, үзэгч, сонсогч эргэлзээгээ илэрхийлж, асуулт асуух нь маш чухал. Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэдгээр асуултад мэргэжлийн түвшний хариулт өгч чадвал иргэдийн итгэлийг олж авах болно.
Мэдээллийн хэрэгслийн арилжааны, улс төр, үзэл суртлын зорилгыг мэддэг	Хэрэглэгчид мэдээллийг улс төр, үзэл суртлын зорилгоор хэрхэн тайлбарлаж байгааг ойлгох бас чухал юм. Тиймээс, тэд харьцуулахын тулд мэргэжлийн мэдээллийн эх сурвалжийг хайх болно. Хэрэв энэ нь хэд хэдэн удаа тохиолдвол тэд илүү мэргэжлийн хэмжээнд ажиллаж буй мэдээллийн хэрэгсэлд тогтвортойгоор итгэх болно.
Эх сурвалжийн зорилго, зорилтот үзэгчдийг тодорхойлж, өгсөн мэдээллийн найдвартай, үнэн зөв байдал, үнэ цэнэ, төвийг сахисан, нээлттэй байдлын зэрэглэлийг үнэлэх чадвартай.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүр тодорхой эх сурвалжтай холбоотой бөгөөд хэрэв уншигч эсвэл үзэгч “эх сурвалж”, “нэргүй эх сурвалж” гэх мэт ойлголтуудыг мэддэг бол, найдвартай эх сурвалжтай ажиллах боломжтой, боломжгүй нийтлэлийн түвшинг, аль нийтлэл нь зөвхөн цуу яриа, хуурамч мэдээлэлтэй холбоотой болохыг үнэлж чадна.

* Хэвлэл мэдээлэл, мэдээллийн мэдлэг нь өөрчлөгдөж буй ертөнцөд цогц ойлголт юм.

3.2. ХММСБ-ЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЖ БУЙ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО, ТББ, ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГУУД

ХММСБ-ын чиглэлээр маш олон байгууллага, нийгэмлэг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл идэвхтэй ажилладаг. Тэд өөр хоорондоо ялгаатай ажил эрхэлдэг ч, өргөн хэрэглээ бүхий, зайлшгүй шаардлагатай амьдралын ур чадвар болж буй ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлэх зорилгоороо ижил юм.

ЮНЕСКО, Европын зөвлөл, Европын ХММСБ-ын Хороо зэрэг олон улсын байгууллагууд ХММСБ-ыг тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Тэдний хүчин чармайлт нь өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх, шилдэг туршлагыг хуваалцах, үндэсний боловсролын тогтолцоонд ХММСБ-ыг нэвтрүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах явдал юм. Европын Зөвлөлийн Белград дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Тобиас Флезенкемпер хэлэхдээ, «Ялангуяа хүүхдүүд аюулгүй, урам зоригийг дэмждэг мэдээллийн орчинд төлөвшиж хүмүүжих нь чухал» хэмээн онцолсон. Эдгээр олон улсын байгууллагуудын идэвхтэй хүчин чармайлт нь холбогдох зохицуулах байгууллагуудад үр дүнтэй шийдвэр гаргах, хариуцлагыг дэмжих, харилцан туршлага солилцох сэдэл өгч, энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмждэг.

Европын орнуудын туршлага

Ардчиллын үйл явцын зайлшгүй нөхцөл бол мэдлэгтэй иргэн. Үүнийг цахим мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээллийн мэдлэгийн талаарх Европын орнуудын туршлагыг харьцуулан дүгнэсэн саяхны судалгаагаар онцлон тэмдэглэсэн байна.

77

Судалгаанд Европын шилдэг туршлага, хэвлэл мэдээллийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхийн тулд зохицуулах байгууллага болон бусад холбогдох оролцогчдыг татах арга замуудын хэд хэдэн жишээг танилцуулж, Финландын загварыг онцлон тэмдэглэв.

Жишээлбэл, Финландад хүүхэд, залуучууд хаана ч байсан хэвлэл мэдээллийн тухай мэдлэгийг зөвхөн цэцэрлэг, сургуульд төдийгүй номын сан, тоглоомын өрөө, залуучуудын төв, тэр ч байтугай виртуал нийгэмлэг, дижитал тоглоомоор ч дамжуулан авдаг.⁵⁸

Тус улсад хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг янз бүрийн практик болон судалгааны аргуудыг хослуулан хөгжүүлдэг бөгөөд үүнд төрийн байгууллагууд, сургууль, сургуулийн захиргаа, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажилладаг аж. Финландын Хэвлэл мэдээллийн боловсролын нийгэмлэг нь үндэсний хэмжээнд судалгаа, практикийг дэмжих замаар энэхүү хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

58 Media education as a factor of optimization of the Russian media space: Collective monograph / Ed. ed. I.V. Zhilavskaya and T.N. Vladimirova. — M.: RIC MGGU named after M.A. Sholokhov, 2014. — P. 420

Тус улсын хэвлэл мэдээллийн боловсрол олгох хүчин чармайлт 1990-ээд онд үүссэн бөгөөд түүнээс хойш дөрвөн өөр чиглэлээр хөгжиж ирсэн аж. Технологийн чиглэл нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, хэвлэл мэдээллийн хэрэгслийг сургалтын үйл явцад ашиглахыг зорьдог. Хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа нь хувь хүн, ялангуяа хүүхдүүдэд хэвлэл мэдээлэл хэрхэн нөлөөлж буйг судалж, тэднийг хэвлэл мэдээллийн сөрөг агуулгаас хамгаалахтай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг. Соёлын судалгааны чиглэл нь Британийн соёлын судалгааны хөдөлгөөний нөлөөгөөр хөгжиж, шүүмжлэлт сэтгэлгээний чиглэл нь хэвлэл мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох, эргэцүүлэн бодох сурган хүмүүжүүлэх арга зүй, стратегийг чухалчилдаг. Финландад олон тооны байгууллага хэвлэл мэдээллийн мэдээллийн боловсрол олгож буй нь гайхалтай. Хэдийгээр жижиг улс боловч албан боловсрол, залуучуудын хөгжлийн хөтөлбөр, номын сан болон бусад олон нийтийн соёлын үйлчилгээний чиглэлээр хэвлэл мэдээллийн боловсрол олгохоос гадна ХММСБ-ыг түгээх чиглэлээр 100 гаруй байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр нь ихэвчлэн ХММСБ-ыг үндсэн үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгон сурталчилж, өөрийн мэргэшлийн чиглэлд нэгтгэдэг. БСШУЯ-ны харьяа Үндэсний аудиовизуал хүрээлэн нь Финландын хэвлэл мэдээллийн боловсролын агентлаг бөгөөд хэвлэл мэдээллийн боловсролыг сурталчилдаг. Үндэсний боловсролын зөвлөл нь Финландын боловсролын хөгжилд голлох үүргийг гүйцэтгэдэг аж.

Хууль зүйн яам болон Финландын Өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах агентлаг нь үүргийнхээ хүрээнд ХММСБ-ыг сурталчлахад мөн өөрийн хувь нэмрийг оруулж байна.

Финландын Хэвлэл мэдээллийн боловсролын нийгэмлэг нь хэвлэл мэдээллийн боловсролын төрийн бус байгууллагуудын (ТББ-ууд), ялангуяа судалгаа, практикийн зөрүүг багасгах чиглэл бүхий гол байгууллага юм.

Финландын номын сангийн холбоо ч хэвлэл мэдээллийн боловсролын салбарт маш идэвхтэй ажилладаг. Номын сангууд нь ерөнхийдөө тоглоомд суурилсан боловсрол, хэвлэл мэдээллийн чадвартай ахмад настнуудад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэдэг.

Хүүхэд, залуучуудын байгууллага нь хүүхэд, өсвөр үеийнхний сайн сайхан, оролцоог хангах үүднээс хэвлэл мэдээллийн боловсролыг сурталчлах ажлыг зохион байгуулдаг. ХММСБ-ын үүднээс авч үзвэл залуучуудын хөгжлийн үндэсний хамгийн идэвхтэй байгууллагууд нь Залуучуудын мэдээлэл, зөвлөгөөг хөгжүүлэх төв (Координатти), Онлайн залуучуудын ажлыг хөгжүүлэх үндэсний төв (Верке), Финландын залуучуудын судалгааны сүлжээ юм. Мөн Маннерхаймын Хүүхдийг Хамгаалах Лиг, Опинкиржо хөгжлийн төв, Финландын «Хүүхдийг ивээх» байгууллага, Финландын эцэг эхийн холбоо зэрэг төрийн бус байгууллагууд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг аж.

Финланд улсын хүн ам сийрэг, хот суурин газар хоорондын зай хол байдаг тул ТББ-ууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн соёл урлагийн байгууллагууд олон жилийн турш хэвлэл мэдээллийн боловсролд идэвхтэй оролцож ирсэн. Хүүхдийн соёлын төвүүдийн үндэсний сүлжээ нь хэвлэл мэдээллийн боловсрол, ялангуяа кино урлагийн чиглэлээр боловсрол олгодог хэд хэдэн байгууллагуудыг нэгтгэдэг.

Сургуулийн кино холбоо (Колукино) болон Метка медиа боловсролын төв нь кино боловсролыг ХММСБ-ын салшгүй хэсэг хэмээн үзэж энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Үндэсний аудиовизуал хүрээлэн нь кино урлагийн боловсролын чанарыг дээшлүүлэх, Финландын аудиовизуал соёлыг сурталчлах үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоодод ч ХММСБ-ын үйл ажиллагаа улам бүр түгээмэл болж байна. Финландын Үндэсний Телевиз, Радио Компани (YLE) хэдэн жилийн турш боловсролын төсөл, материалаар бусад байгууллагуудыг хангасаар ирсэн. Финнмедиа, Финландын Хэвлэл мэдээллийн аж үйлдвэрийн холбоо нь хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан ХММСБ-ын хөгжлийг стратегийн болон нийгмийн зорилт болгосон.

Багаар ажиллах нь ХММСБ-ын Финландын загварын чухал шинж чанар юм. Төрөл бүрийн байгууллага, оролцогч талуудын хамтын хүчин чармайлт нь энэ загварын гол бүрэлдэхүүн хэсэг. Финланд улс хэвлэл мэдээллийн боловсролыг хамтын хүчин чармайлтаар амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд Финландын ХММСБ-ын мэргэжилтнүүд судалгаа, практик, бодлого боловсруулахад олон улсын түншээр идэвхтэй оролцож байна. Мөн Европын Холбоо, Европын Зөвлөл, ЮНЕСКО-гийн төсөл, хөтөлбөрүүд Хойд Европ, дэлхийн түвшинд ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлэхэд тусалсан. ХММСБ-ын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой аливаа байгууллага, судлаач Финландын мэргэжилтнүүдтэй холбоо барьж болно.

79

ХММСБ-ын долоо хоног буюу MLW нь жил бүрийн хоёрдугаар сард тэмдэглэдэг, хэвлэл мэдээллийн мэдлэг, боловсролын ач холбогдлыг таниулах, сурталчлах зорилготой арга хэмжээ юм. MLW-д төрийн болон төрийн бус байгууллага, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч оператор, мэдээлэл аюулгүй байдлыг хангах компаниуд, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг 40 орчим байгууллага оролцдог. Тэд тухайн жилийн сэдэв, нөлөөллийн ажил, мэдээллийн материал, зохион байгуулах арга хэмжээ зэргийг төлөвлөж, хамтран хэрэгжүүлдэг. Үндэсний аудиовизуал хүрээлэн нь ХММСБ-ын долоо хоногийг зохион байгуулах үндсэн үүрэгтэй. Илүү ихийг мэдэхийг хүсвэл www.mediataitoviikko.fi хаягаар зочилно уу.

Үндэсний Тоглоомын өдөр (NgD) нь тоглоомын ашиг тус, утга учир, түүнчлэн тоглогчдод үзүүлэх нөлөөг хэлэлцэх өдөр юм. Энэ арга хэмжээ нь дижитал тоглоомын талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлэх зорилготой бөгөөд бүх насны хүмүүсийг хамтдаа тоглохыг уриалдаг. Та NgD-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.pelipaiva.fi дээрээс авах боломжтой.

Мэргэжилтнүүдийн хэвлэл мэдээллийн боловсролын форум нь⁵⁹ судлаач, шийдвэр гаргагч, төрийн албан хаагч, ХММСБ-ын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийн уулзалтын талбар юм. Тус форум нь янз бүрийн салбар, орон нутгийн иргэдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилготой. Форумыг зохион байгуулагчаар Үндэсний аудиовизуал хүрээлэн ажиллаж байна.

Дэлхий даяар ХММСБ-ын ур чадварыг сурталчлах олон арга хэмжээ, байгууллага байдаг. Эдгээрээс Финландын туршлага хөгжиж буй орнуудад ХММСБ-ын стратеги боловсруулах маш сайн жишээ болж буйг онцлох нь зүйтэй.

Бүс нутгийн болон орон нутгийн төсөл, хөтөлбөрүүд хэвлэл мэдээллийн, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ХММСБ-той холбоотой судалгаа, арга хэрэгсэл боловсруулах, санал, туршлага солилцох чиглэлээр хамтран ажиллах нь түгээмэл байна. 2017 онд ХММСБ-ын шалгуур үзүүлэлтүүдийг (MIL индекс) Европын хэд хэдэн оронд «үнэний дараах» худал ташаа мэдээллийн урсгалыг эсэргүүцэх цогц арга хэмжээний хүрээнд бий болгосон. MIL индекс нь худал, өрөөсгөл, гуйвуулсан мэдээллийг таньж, эсэргүүцэх мэдлэг, чадварын түвшин хэр байгааг үнэлэх хэрэгсэл юм.⁶⁰


ХММСБ-ын шалгуур үзүүлэлтийн дагуу 2018 онд Европын 35 орныг гуйвуулсан мэдээлэл, түүний сөрөг үр дагаврыг эсэргүүцэх чадвараар нь үнэлжээ. Энэхүү үнэлгээг хэвлэл мэдээллийн эрх чөлөө, боловсролын чанар, хүмүүсийн хоорондын итгэлцэл, цахим оролцоо зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн бэлтгэсэн аж. Үнэлгээнд дурдсан үзүүлэлтүүдэд үндэслэн худал мэдээлэл, түүнтэй холбоотой хор хохирлын эсрэг олон нийтийн эсэргүүцлийн түвшинг урьдчилан тооцох боломжтой хэмээн үзэж буй аж.⁶¹

59 Based on the materials of www.kavi.fi: Finnish Media Education.

60 The report on the first Media Literacy Index 2017 entitled “Can this be true? Predictors of media literacy and resilience to the posttruth phenomenon in Europe”, October 2017.

61 Common sense wanted resilience to ‘post-truth’ and its predictors in the new media literacy index 2018, Marin Lessenski.

График 4



Эх сурвалж: Common sense wanted resilience to 'post-truth' and its predictors in the new media literacy index 2018, Marin Lessenski

2018 оны үр дүнд үндэслэн (График 4) ташаа мэдээлэл, худал мэдээлэл, түүний сөрөг үр дагавартай тэмцэхэд хамгийн сайн бэлтгэгдсэн орнууд бол Баруун хойд Европын орнууд, тухайлбал Нидерланд, Эстони, Ирланд юм. ХММСБ-ын үнэлгээг боловсролын түвшин, хэвлэл мэдээллийн байдал, олон нийтийн итгэл, оролцооны шинэ арга хэрэгслийн ашиглалт зэрэг янз бүрийн үзүүлэлтүүд дээр үндэслэн боловсруулсан байна. Эдгээр үзүүлэлтүүдийг ач холбогдлоор нь ялгаж тооцдог бөгөөд хамгийн чухал нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө, боловсрол юм. Үнэлгээний үлдсэн хэсэг нь иргэдийн итгэлцэл, цахим оролцооны үзүүлэлтэд тулгуурладаг аж. Үнэлгээний аргачлалын талаар эндээс үзнэ үү.

Шалгуур	%
Хэвлэлийн эрх чөлөөний шалгуур	
Freedom House-ын үнэлгээгээр Хэвлэлийн эрх чөлөөний индекс	20%
Хил хязгааргүй сэтгүүлчдийн үнэлгээгээр хэвлэлийн эрх чөлөөний индекс	20%
Боловсролын шалгуур	
Унших чадварын PISA индекс	30%
Байгалийн ухааны мэдлэгийн түвшин, PISA индекс	5%
Математикийн мэдлэгийн түвшин PISA индекс	5%
Дээд боловсролтой иргэдийн хүн амд эзлэх хувь (Eurostat)	5%
Итгэлцэл	
Бусдад итгэх итгэл (Eurostat)	10%
Оролцооны шинэ хэлбэр	
Цахим оролцооны индекс (UN)	5%

Европын 35 орны ХММСБ-ын ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний системд 0-ээс 100 хүртэлх оноо ашигладаг бөгөөд хамгийн өндөр оноо нь хамгийн сайн өндөр үзүүлэлтийг харуулна. www.thecatchupindex.eu. сайтын тогтмол шинэчлэгдэж байдаг мэдээллээс үзэхэд Финланд (76), Дани (71), Нидерланд (70), Швед (69), Эстони (69), Ирланд (68) сүүлийн жилүүдэд тэргүүлж байна.

ХММСБ-ын хөгжлийг үнэлэхэд хэд хэдэн чухал хүчин зүйл байгааг зарим олон улсын байгууллагууд тодорхойлсон байдаг. Эдгээр хүчин зүйлсэд сургалтын хөтөлбөр, хэвлэл мэдээлэл, сэтгүүлзүйн сургалт, багш нарт зориулсан сургалт, ХММСБ болон сэтгүүл зүйн боловсролтой холбоотой бусад үйл ажиллагаа зэрэг мэргэжлийн хүмүүсийн дунд ХММСБ хэр байгааг илтгэх үзүүлэлт багтаж байна. Цаашилбал, сэтгүүлчдийн тоон бичиг үсгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа мөн чухал хэмээн үзэж байна. ХММСБ-той холбоотой асуудлыг зохицуулах үүрэг бүхий тусгайлсан байгууллагууд байдаг эсэх, мөн төрийн бодлого зохицуулах байгууллага энэ чиглэлээр хэрхэн ажилладаг зэргийг өндөр ач холбогдолтой хэмээн онцолдог аж. Мөн хэрэглэгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалахад төрийн байгууллага, зохицуулагчдыг татан оролцуулах нь мөн чухал гэж үзэж байна.

62 Common sense wanted resilience to 'post-truth' and its predictors in the new media literacy index 2018, Marin Lessenski.

Дараах хэсэгт ХММСБ, сэтгүүл зүйн боловсрол, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ёс зүйтэй үйл ажиллагааг сурталчлахад өндөр ач холбогдолтой байгууллага, үйл ажиллагааг товч танилцуулж байна. Үүнд хөтөлбөр, төсөл боловсруулах, санхүүжилт, мэдээлэл, боловсрол, сурталчилгааны материал бий болгох зэрэг орно.

Юун түрүүнд хэвлэл мэдээллийн мэдлэг, сэтгүүлзүйн боловсролыг дээшлүүлэхэд төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд салбарын зохицуулалт, хамтын ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт, төслийн менежментийг сайжруулахад идэвхтэй оролдог. Түүнчлэн, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэл иргэдэд хүртээмжтэй байх нь чухал юм. Тэдгээр хэрэгсэлд гар утас, Интернэт, телевиз, радио, сонин, цахим мэдээллийн эх сурвалж, нийгмийн сүлжээ зэрэг орно.⁶³

Мөн хэвлэл мэдээллийн боловсролын бодлогыг тодорхойлсон хууль тогтоомжид анхаарлаа хандуулах нь чухал. Түүнчлэн хэвлэл мэдээллийн боловсролд зориулсан нөөц бололцоо, ХММСБ-той холбоотой хөтөлбөр, төслүүд хэрэгждэг эсэх, мөн хэвлэл мэдээллийн долоо хоног, наадам, тэмцээн, тоглоом, нийгмийн сүлжээний бүлгүүд гэх мэт байдаг эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.

Нэмж дурдахад ХММСБ-ын хангалтгүй байдлын улмаас хууль зөрчих тохиолдолд гарч байгаа эсэх, энэ талаар тоон статистик мэдээлэл байдаг эсэхийг шалгах хэрэгтэй. Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр бид ХММСБ-ын чадавхыг сайжруулж, хэвлэл мэдээллийн талаарх мэдлэг бол амьдралын чухал ур чадвар гэдгийг хүлээн зөвшөөрч, хүн бүрийн амьдралын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулах боломжтой болно.

3.3 ХММСБ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ

Сэтгүүлчдийн «нэр төрийн баталгаа»-г хангах учиртай мэргэжлийн сэтгүүл зүйн ёс зүйн зарчмуудыг янз бүрийн баримт бичигт тусгасан байдаг. Тухайлбал, Узбекистан улсад 2019 онд батлагдсан Узбекистаны радио телевизийн үндэсний холбооны дүрэм, Узбекистаны сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрэм зэрэгт сэтгүүл зүйн ёс зүйн асуудлуудыг томъёолсон байна.

1978 онд ЮНЕСКО-гийн ивээл дор зохион байгуулсан Зөвлөлдөх уулзалтын дараа олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын 400 гаруй мянган сэтгүүлч эвлэлдэн нэгдэж, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах болсон. Эдгээр сэтгүүлчдийн дөрөв дэх Зөвлөлдөх уулзалтыг Парис, Прага хотод зохион байгуулж, тэрхүү уулзалтын үеэр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь үндэсний болон олон улсын мэдээллийн харилцаанд чухал үүрэгтэй болох талаар хэлэлцээд, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн үндсэн хэм хэмжээг баталсан. Энэхүү баримт

63 Media Literacy and Education Needs of Journalists and the Public in Albania, Bosnia Herzegovina, Macedonia, Montenegro, Serbia - Regional Report March 2017 Project "South-East European Partnership for Media Development"

бичгийн эхний хоёр хэсэгт “Найдвартай мэдээлэл авах иргэдийн эрх”, “Үйл явдлыг бодитой мэдээлэх - сэтгүүлчийн үүрэг” хэмээх зарчмуудыг тусгасан бол гуравдугаар зүйлд сэтгүүлчийн нийгмийн хариуцлагын тухай оржээ. Мэдээллийг баталгаажуулах орчин үеийн технологийн боломж бий болсон цаг үед хараат бус байх, бодитой, шударга, үнэн зөв мэдээлэх зэрэг ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх нь онц чухал шаардлагатай болоод байна. Эдгээр зарчмуудыг дагаж мөрдөх нь хэвлэл мэдээллийн нэр хүндийг баталгаажуулж, олон нийтийн итгэлийг олж авахад чухал ач холбогдолтой.

Хэвлэл мэдээллийн агуулгыг гуйвуулах нь иргэний нийгмийн төлөвшил, шүүмжлэлтэй сэтгэлгээнд бодитой заналхийллийг бий болгодог. Тийнхүү гуйвуулсан агуулгыг нийгмийн мэдээллийн сүлжээгээр олны хүртээл болгох нь түгээмэл. Нийгмийн мэдээллийн сүлжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэмээн үзэх нь өрөөсгөл юм. Гэхдээ эдгээр хэрэгсэл нь алгоритмын тусламжтайгаар мэдээллийн урсгалыг хянаж байдаг учир, тэдний нийгмийн хариуцлагыг мөн онцлон ярих хэрэгтэй. Хэдийгээр нийгмийн мэдээллийн сүлжээ өөрийн гэсэн дүрэм, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж байгаа ч, эдгээр сувгаар олон нийтэд хүрэх худал ташаа мэдээлэл улам бүр нэмэгдэж байна. Тийм ч учраас нийгмийн мэдээллийн сүлжээний өөрийн зохицуулалтын арга хэрэгсэл, тэдний дотоод дүрэм журам төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байна хэмээн үздэг.

Дасгал 5

Дараах асуултад хариулна уу:

1. Нийгмийн мэдээллийн сүлжээний хаягаар хувийн мэдээллийг олж авах боломжтой байдаг. Мэдээллийн бодит байдлыг шалгахын тулд сэтгүүлч хүн ийм мэдээллийг ашиглах ёс суртахууны эрхтэй юу? (хариултаа үндэслэнэ үү)

2. Сэтгүүлч хэрэглэгчийн контентоос бичвэрийн материал цуглуулжээ. Тэрээр сэдвийнхээ чухал өнцгийг тодотгосон хоёр түүхтэй; түүнд үйл явдал тодорхой хэлбэрээр явагдана гэдгийг нотлох үндэслэл, баримт, тоо байгаа. Гэвч хэрэглэгчийн контентыг ашиглаж материалын гурав дахь хэсгийг тайлбарлах шаардлагатай болно. Сэтгүүлч дүр зохиож, хэрэглэгчийн контентоос авсан материалыг дүрийн хэлсэн зүйл болгож нийтлэх эрхтэй юу? (дэлгэрэнгүй, үндэслэлтэй хариулт өгнө үү)

3.4 ХММСБ-ЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР СУРВАЛЖЛАХ АРГА ТЕХНИК

Уур амьсгалын өөрчлөлт, жендэрийн тэгш байдал, хүний наймаа, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг хөгжлийн янз бүрийн асуудлаар олон нийтийн яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд хэвлэл мэдээлэл чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүн ХММСБ-той байх нь үндэсний болон дэлхийн тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой юм. Гэсэн хэдий ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр ХММСБ-ын хөгжлийн талаар мэдээлэх нь хомс байна. Хааяа мэдээлэх тохиолдол гарч буй ч, ялангуяа ташаа мэдээллийн урсгалтай харьцуулбал эдгээр нь цөөхөн бөгөөд давтамжийн хувьд хол байна.

The UNESCO publication *MIL Policy and Strategy Guidelines*⁶⁴ [Grizzle, A and Torras-Carme, M. (2013)], notes

“ХММСБ-ын бодлого, стратеги нь мэдлэгт тулгуурласан, хүртээмжтэй, олон ургалч, ардчилсан, нээлттэй нийгмийг бий болгоход тулгуур үүрэг гүйцэтгэнэ.⁶⁵ Орчин орчин үеийн засаглал, дэлхийн иргэншлийн оршин тогтнохуйг баталгаажуулах нь ХММСБ-ын бодлого, стратегийг хэрхэн томъёолж хэрэгжүүлэхээс үлэмж хамаарч байна. Тиймээс улс орон бүрд ХММСБ-ын үндэсний бодлого боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг олон нийтийн анхааралд хүргэж, хэлэлцүүлгийн чухал сэдэв болгууштай.

Хүснэгт 5-д үндэсний болон дэлхийн түвшинд ХММСБ-ын хөгжлийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхдээ анхаарах ёстой зарим асуудал, арга техникийг санал болгож байна.

Хүснэгт 5. ХММСБ-ын хөгжлийн талаар мэдээлэхэд анхаарах асуудал, арга техник

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн хийх зүйл	Ашиглаж болох материал, жишээ
ХММСБ нь мэдлэгт суурилсан нийгэм, боловсрол, ардчилал, энх тайван, сайн засаглал, тогтвортой хөгжил зэрэгтэй хэрхэн холбогдож байгааг олон нийтэд ойлгуулж, ХММСБ-ын хөгжлийн нөхцөл байдлыг судалж, мэдээлнэ.	- MILID Yearbook 2015: Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх ХММСБ - Дижитал эрин үеийн ХММСБ-ыг ойлгох нь: Ардчиллын тухай асуудал - MILID Yearbook 2016: ХММСБ: Хүний эрхийг бэхжүүлэх, радикализм, хэт даврагч үзэлтэй тэмцэх нь

64 Grizzle, A. & Torras, M.C. (Eds.) (2013). Media and Information Literacy Policy and Strategy Guidelines. United Nations Educational, Scientific and Cultural Organization. Paris, France. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000225606>. Accessed on 31 August 2019.

Steinerová, J. and Šušol, J. (2007), “Users’ information behaviour - a gender perspective”, Information Research, 12(3): paper 320, Available at <http://InformationR.net/ir/12-3/paper320.html>

65 See also Carlsson, U. (ed) (2019). Understanding Media and Information Literacy (MIL) in the Digital Age: A question of democracy. Department of Journalism, Media and Communication (JMG). University of Gothenburg, Sweden.

ХММСБ-ыг сурталчилж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаар судалж, мэдээлэх. Энэ ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлснээр үзэгч, сонсогч, уншигчдын харилцаа хэрхэн өөрчлөгдөж буйг сурвалжлах	- WAN/IFRA мэдээллийн сан 130 гаруй ХММСБ-ын талаарх мэдээний загвар, төслийн жишээ - Сэтгүүл зүйн чиглэлээр суралцагчид болон мэргэжилтнүүдийн ХММСБ-ын чадамжийн стандарт - Дилевко, Ж. (1998). Номзүйн зааварчилгаа, ХММСБ: Онолын суурь. Номын сан улирал тутам, 68(4), 431-474. - Сэтгүүл зүйг сайжруулах судалгаа, нөөц, санаа. (n.d.). Journalism.org. “http://journalism.org” http://journalism.org
Үндэстний ХММСБ-ын бодлогын хэрэгцээ шаардлагын талаар асуудал хөндөж, хэлэлцүүлэг өрнүүлэх.	ХММСБ: Бодлого, стратегийн удирдамж
Үндэсний ХММСБ-ын бодлоготой улс орнуудад тэдгээр нь хэр зэрэг хэрэгжиж байгааг судалж, мэдээлэх	
ХММСБ иргэд, нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой эмпирик судалгааны үр дүнг олж авах, мэдээлэх.	- Олон улсын ХММСБ-ын сэтгүүл - Мэдээллийн бичиг үсгийн сэтгүүл (JIL) - Хэвлэл мэдээллийн бичиг үсгийн боловсролын сэтгүүл (JMLE.org)

Сэтгүүлчийн ажил бол анхан шатны мэдээлэлтэй ажиллах, мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах явдал юм. Гэвч мэдээллийн тэсрэлт, технологийн хурдацтай дэвшлийн эрин үед сэтгүүл зүйн үйл ажиллагаа технологийн дэвшилд улам бүр хөтлөгдөж буй учир сэтгүүлч хүнд шинэ шинэ үр чадвар шаардлагатай болоод байна.

Сэтгүүлчдийн үндсэн зарчим бол эргэлзэх сэтгэлгээг эрүүл байлгах явдал. Тэд харсан, сонссон бүхэндээ эргэлзэж, мэдээллийг шалгах үүрэгтэй. Гэвч нөгөө талаар энгийн хүмүүс ч мэдээллийн урсгалд оролцож, шинэ мэдээллийг бий болгож байгаа учир сэтгүүлчид төдийгүй, мэдээлэлтэй харьцдаг хүн бүр ХММСБ-той байх зайлшгүй шаардлагатай болоод байна.

Тиймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд худал ташаа мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд хийж болох дараах хэд хэдэн алхмуудыг сэтгүүлчдэд эзэмшүүлэх нь чухал:

- Юуны өмнө мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж, тэдэнд итгэж байгаа эсэхээ эргэцүүлж үзэх хэрэгтэй. Тухайн мэдээлэл бодитой байхын тулд хамгийн багадаа гурван бие даасан эх сурвалжаар баталгаажсан байвал зохино. Түгээж буй агуулга эргэлзээтэй бол өөр нотлох баримт, эсвэл уг мэдээллийг хэн нэгэн үгүйсгэж буй эсэхийг олох нь чухал.

- Мэдээллийн эх сурвалж гэж тухайн мэдээллийг хамгийн түрүүнд түгээсэн, бий болгосон хүнийг хэлнэ. Энэ нь болж өнгөрсөн зүйлийг нүдээр харсан гэрч эсвэл нөхцөл байдалтай ойрын хамаарал холбоотой хүн байж болно. Илүү нарийн зүйлсийг олж мэдэхийн тулд олон эх сурвалжаас авсан мэдээллийг шалгаж, мэргэжилтнүүд болон мэдлэгтэй хүмүүсээс санаа бодлыг нь сонсох зүйтэй. Мэдээллийг хуваалцахдаа баримт, тайлбарыг хооронд нь ялгаж салгаж, байр суурийг агуулгын хувьд зөв хүргэх нь чухал.
- Эсрэг талын байр суурийг сонсох Тодорхой асуудлаар үзэл бодол илэрхийлэх үед эх сурвалжийн тоо төдийлөн чухал биш. Хамгийн гол нь ашиглаж буй бүх эх сурвалж бүгд ижил байр суурьтай байх нь зохимжтой биш. Өөрөөр хэлбэл асуудлыг зөвхөн нэг талаас нь харуулбал тухайн мэдээлэл өрөөсгөл байх эрсдэлтэй. Тэнцвэртэй мэдээлэхийн тулд эсрэг талын үзэл бодлыг сонсож, бусдад хүргэх шаардлагатай. Энэ нь ялангуяа зөрчилдөөнтэй нөхцөлд онцгой чухал юм. Тиймээс хэлэлцэж буй асуудлын талаар бүх оролцогч талыг тодорхойлж, тэдний санал бодлыг мэдэх нь нэн чухал.
- Хурдыг чухалчлахаас илүүтэйгээр баримтын үнэн зөв байдал илүү чухал юм. Сэтгүүлч хүний хувьд сэтгэл хөдлөл нь аюултай дайсан байж болно. Мэдээлэлтэй ажиллахдаа сэтгэл хөдлөлөөс илүү логик сэтгэлгээ, эргэлзээнд найдах нь чухал. Сэтгэл санааны ерөнхий байдал, хувийн хэвшмэл хандлага, хүсэл тэмүүлэл сэтгүүлчийн ажилд нөлөөлөх эрсдэл байнга гардаг. Орчин үеийн сэтгүүлчдэд тулгардаг цаг хугацааны байнгын дарамтаас болж энэхүү эрсдэл улам бүр нэмэгдэнэ. Анхны «халуун» мэдээг нийтлэх хүслээ давж, мэдээлэл үнэн зөв эсэхийг баталгаажуулж хэвших нь чухал юм. Сэтгүүлчид нийгмийн мэдээллийн сүлжээний мэдээллийг ашиглахдаа болгоомжтой байх хэрэгтэй.

Нийгмийн мэдээллийн сүлжээ нь хүмүүст өөрийн нүдээр харсан зүйлсийн талаар мэдээ, мэдээллийг хүлээн авах, мөн олон хүний сэтгэгдлээс янз бүрийн үзэл бодлыг харах боломжийг олгодог тул сэтгүүлчдийн ажилд тустай. Гэхдээ нийгмийн мэдээллийн сүлжээгээр түгээсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг дор хаяж гурван бие даасан эх сурвалжтай харьцуулан шалгах нь чухал юм. Үүний тулд сэтгүүлчид янз бүрийн нягтлан шалгах арга хэрэгслийг ашиглах ёстой.

Сэтгүүл зүй мэдээллийн орчинд тулгарч буй сорилт, бэрхшээлд дасан зохицож байна. Эдүгээ баримт шалгах олон янзын арга, хэрэгсэл бий болж, худал мэдээллийг илрүүлэх зорилготой тусгайлсан сайтууд хөгжиж, худал мэдээлэл, гуйвуулга, заль мэхтэй тэмцэх онлайн нийгэмлэгүүд олноор бий болж байна.


<http://factcheck.kg>

<http://www.accessify.com/visit?domain=faktograf.hr>

<https://anhor.uz/MILplus>

Мэдээллийг шалгахдаа баримт, эх сурвалжийг ялгах нь маш чухал. Үүнийг шалгах хоёр арга бий. Нэгдүгээрт, Интернет ашиглан мэдээлэл өгсөн хүнийг хайж олох, гэр бүл, хамаатан садан, найз нөхөдтэй нь холбоо барьж, хамт олон, танил хүмүүсээс нь мэдээлэл авах боломжтой. Үүнийг хийснээр мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангахад тусална.

Дасгал 6. Санал болгож буй асуудлын талаар оролцогч талуудын харилцааг зураглаж, жагсаалтад нэмж, харилцааг харуулсан шугам зур.



88

Нийгмийн мэдээллийн сүлжээ нь олон нийтийн санаа бодлыг тандах чухал эх сурвалж болоод байна. Сэтгүүлчид ч үүнийг түгээмэл ашигладаг. Цаг үеийн онцгой үйл явдлын үеэр «иргэний сэтгүүлч» гэгддэг жирийн иргэд хамгийн түрүүнд тухайн үйл явдал, нөхцөл байдлын талаар мэдээлдэг. Гэсэн хэдий ч ийм мэдээллийн үнэн зөвийг шалгах нь маш чухал.

Нөгөө талаар хэрэглэгчийн түгээж буй агуулгыг ашиглаж худал ташаа мэдээллийг илрүүлэх боломж ч улам бүр нэмэгдэж байна.

Нийгмийн мэдээллийн сүлжээн дэх хаягаар хүлээн авсан аливаа мэдээллийг үнэн гэж хүлээн зөвшөөрөхөөс өмнө тэдгээрийн бодитой эсэхийг шалгаж хэвших нь чухал. Ингэснээр мэдээллийг тодруулах, дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах, баримтын үнэн зөвийг тогтооход тустай.

Аливаа мэдээллийг баримт, фактоид, хуурамч хэмээн гурван төрөлд хувааж үзэх нь элбэг байна. (Фактоид гэж найдваргүй боловч баримт мэтээр олны дунд түгээж, хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийг хэлнэ.) Аливаа хэвлэл мэдээллийн байгууллагын редакцын зөвлөл нь мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулахын тулд шүүлтүүртэй ажиллах үүрэгтэй. Баримт шалгах гэж нэрлэгддэг энэхүү үйл явц нь мэдээллийн үнэн зөвийг нягталж, тодорхой, зохион байгуулалттай байдлаар танилцуулах явдал юм.

Баримт шалгах гэдэг нь нийтлэгдсэн материалыг нягтлан шалгах үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд шинэ агуулгыг болгох явдал юм. Баримтыг тогтоож, баталгаажуулж, дахин шалгаж, засаж залруулах бөгөөд маргаангүй гэгдэх мэдээллийг бий болгоно гэсэн үг.

Мэдээллийг нотлох, үгүйсгэхээс гадна баримт шалгах ажиллагаа нь ашигласан эх сурвалж, баталгаажуулах үйл явцыг харуулдаг. Энэ нь мэдээлэл найдваргүй байж болно гэдгийг уншигч, үзэгчдэд ойлгуулахад чухал ач холбогдолтой юм. Баримтыг нягтлан шалгах нь тогтсон дүрэм журмаар хязгаарлагдахгүй бөгөөд хариуцлага, сонирхол, хичээл зүтгэл зэрэг хувийн шинж чанаруудыг шаарддаг. Үүний зэрэгцээ сэтгүүлчид хэвлэл мэдээллийн орчны талаар болон мэдээллийг нягтлах арга боломж, байгаа үйлчилгээг хэрхэн ашиглах талаар сайн ойлголттой байх нь чухал.

Орчин үеийн дижитал ертөнцөд мэдээллийн үр нөлөө нь үнэн бодит байдлаас ч илүү чухал болж хувираад байна. Тийм ч учраас хаана ч байхгүй “баримт”-ыг нийтэлж, түгээж, үнэлж, хариу үйлдэл үзүүлдэг болж.

Харамсалтай нь олон хүн аливаа мэдээллийг агуулгыг цэгнэхээс илүүтэйгээр танилцуулсан хэлбэр, арга барилд нь итгэх хандлагатай байдаг. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа, тэдгээр хэрэгслээр түгээсэн мэдээний тухай хэвшмэл ойлголт бий болсонтой холбоотой. Сонинд нийтлэгдсэн, зурагтаар гарсан, цахим хуудсуудаар цацагдсан олон лайк авсан мэдээ үнэн байх ёстой гэж хүмүүс үздэг. Үүнийг худал мэдээлэл тараах арга хэлбэр болгон ашиглаж байна. Ийм төрлийн хуурамч мэдээлэл нь бусад мэдээллийн нотлох баримтын нэг хэсэг нь болж, дэлхийн бодит дүр зургийг гажуудуулж болзошгүй юм. Тиймээс сэтгүүлчид ч, уншигчид ч тухайн мэдээллийг бодитой гэж хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө үнэн зөв эсэхийг шалгах нь чухал.

Дасгал 7 Өөрийн орны болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээс жишээ ол. Уг материалыг нийтэлсэн гарчиг, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэрийг хүснэгтэд оруулна уу.

Хүснэгт 6

Буруу ойлголт өгөх агуулга: Гарчиг, зураг, агуулга зөрчилтэй, эсвэл хоорондоо хамааралгүй.	
Нэмэлт мэдээлэл зөрчилтэй буюу худал: Баримтыг тайлбарлах нэмэлт мэдээлэл нь буруу, дутуу, худал байхаас шалтгаалж агуулгын мөн чанар алдагдсан байх.	
Орчин нөхцөлийн талаарх мэдээллийг гуйвуулах: Анхдагч мэдээллийг тодорхой хариу үйлдэлд хүрэх зорилгоор хөрвүүлж танилцуулах.	
Элэглэл, хошигнол. Хор хөнөөл учруулах тодорхой зорилго байхгүй, хэдий ч, хуурах сэдэлтэй	
Төөрөгдүүлсэн агуулга. Ижил төстэй мэдээллийг зориудаар төөрөгдүүлэх, эргэлзээ үүсгэх сэдлээр түгээх	
Контент хуурамч. Эх сурвалжгүй баримт, эх сурвалж нь хувийн бус.	
Үйлдвэрлэсэн контент. Хор хөнөөл учруулах зорилготой бүрэн боловсруулсан контент.	

3.5 ХММСБ-ЫН ТАЛААР РЕДАКЦЫН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХҮЙ

Редакцын баг бүр ХММСБ-ыг дээшлүүлэх мэдээллийн бодлогыг бий болгох нь чухал юм. Сэтгүүлчид редакцын ажилтны хувьд заримдаа баталгаагүй мэдээлэл тараах нь бий. Тухайн байгууллагад дагаж мөрдөх редакцын бодлоготой байх үед ийм алдаанаас урьдчилан сэргийлэх, мөн алдаа гарвал хэрхэх талаар мэддэг байх боломжтой.

2017 оны 2-р сард дэлхийн хамгийн нөлөө бүхий шинжлэх ухааны сэтгүүлүүдийн нэг болох “Science” нь худал ташаа мэдээллийн асуудалд анхаарлаа хандуулсан. Эрдэмтдийн баг Twitter дээр арван жилийн хугацаанд үнэн, худал мэдээний 126,000 репост буюу дахин түгээлтийг цуглуулжээ. Ингэснээр тэд худал агуулга үнэнээс хамаагүй хурдан тархдаг болохыг олж мэдсэн аж.⁶⁶

Тийм учраас баталгаажаагүй мэдээлэлтэй хэрхэн ажиллах тухай арга зүйн ойлголт мэдлэг, арга барилаа нэгтгэх нь редакцын бодлогын гол асуудал байх ёстой. Сэтгүүлчид олон улсын янз бүрийн төслийн хүрээнд мэдээллийг нягтлан шалгах сэтгүүлчдийн нийгэмлэг байгуулан ажиллаж буй цөөнгүй жишээ бий.

90

Тухайлбал, АНУ-ын сонгуулийн кампанит ажлын үеэр ProPublica болон First Draft хамтран АНУ-ын ирээдүйн Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалттай холбоотой асуудлуудыг хөндсөн сошиал медиа агуулгад ажиглалт хийх зорилгоор Electionland төслийг хэрэгжүүлсэн байна. Энэхүү төсөл нь нэлээд амбицтай байсан бөгөөд Америкийн өнцөг булан бүрээс сэтгүүл зүйн чиглэлээр суралцдаг 600 гаруй оюутан, 400 гаруй сурвалжлагч, мөн Нью-Йорк хотын төвд 150 сэтгүүлчтэй томоохон мэдээллийн төвийг хамарсан. Төслийн захирал Клэр Уордл санал хураалтын талаар хүмүүсийн нийтэлсэн агуулгыг цуглуулахын тулд сэтгүүлч, судлаач, оюутнуудыг баг уйгагүй хөдөлмөрлөсөн хэмээн ярьсан байдаг.⁶⁷

2017 оны 2-р сард Францын сэтгүүлчид Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын үеэр First Draft болон Google New Lab-ийн дэмжлэгтэйгээр Cross-Check төслийг санаачилжээ. Энэхүү төсөл нь Pro Publica-гийн амжилтаас санаа авсан бөгөөд онлайн худал мэдээлэлтэй тэмцэх, сонгогчдын дунд бодит ардчилсан мэтгэлцээн өрнүүлэх зорилготой байв.

Уг платформ нь нийтэлсэн материал бүрийг редакцын лого эсвэл нөөцийн тэмдэглэгээр ялгаж, үнэн зөвийг баталгаажуулахын тулд агуулгын бүрийн задлан шинжилсэн аж. Үүний үр дүнд материал бүрийг үнэн, худал, болгоомжлох, баримт хангалтгүй, анхаарах гэх зэргээр ангилж тэмдэглэсэн байна.

66 Kozlovsky, B. Maximum repost: How social networks make us believe the misinformation and disinformation / Borislav Kozlovsky. — М.: Alpina Publisher. — P. 198

67 firstdraftnews.com/crosscheck-findings

Худал хэмээн ангилсан мэдээллийг тохуурхал (наргия), бүрэн бус мэдээлэл, гуйвуулсан, зохиомол, төөрөгдүүлсэн агуулга, буруу тайлбарласан гэх мэт мэдээллийн гажуудлын хэлбэрийг нарийвчлан үнэлжээ. Уг төсөл дээр Франц, Их Британийн 100 гаруй сэтгүүлч, 33 редактор хамтран ажилласан байна.⁶⁸



Source: <https://www.poynter.org/channels/fact-checking>

91

Баримтыг нягтлах шилдэг туршлагыг сурталчлах, мэдээлэл солилцох замаар сэтгүүл зүйд баримт шалгах практикийг дэмжих зорилгоор Олон улсын баримт шалгах сүлжээг (IFCN) 2015 оны 9-р сард үүсгэн байгуулсан юм. Энэ нь Пойнтер институтын салбар бөгөөд дэлхийн өнцөг булан бүрийн баримт шалгагчдыг нэгтгэх зорилготой юм.

IFCN1 нь хэд хэдэн гол зорилготой:⁶⁹

- Баримт илрүүлэх бодлогын хөгжлийн чиг хандлага үйл ажиллагааг судалж, энэ сэдвээр тогтмол нийтлэл бэлтгэх, түгээх
- Үндсэн хэм хэмжээ, баримт шалгах дүрэм, зарчмуудыг сурталчлах, баримт шалгах үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн төслүүд.
- Энэ чиглэлээр жил бүр инновацийг дэмжих тэтгэлэг олгох, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх
- Олон улсын хэмжээнд баримт шалгах хүчин чармайлтыг дэмжих, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Бодит баримтад суурилсан онлайн сургалт хэрэгжүүлэх

Мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн орчинд янз бүрийн хэлбэрийн мэдээллийн гажуудлаас урьдчилан сэргийлэх талаар

⁶⁸ The Impact of CrossCheck on Journalists & the Audience, by Smyrniaios, N., Chauvet, S., & Marty, E., November 2017.

⁶⁹ <https://www.poynter.org/channels/fact-checking>

санаа тавьдаг сэтгүүлч, судлаачид дэлхийн дахинаа хамтран ажиллах янз бүрийн арга хэлбэрийг эрэлхийлж байна. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн тухай мэдлэг бол “хүн бүрийн хувийн болон нийгмийн зорилгод хүрэх зайлшгүй шаардлагатай чадвар.”⁷⁰ Тиймээс аль ч хэвлэл мэдээллийн байгууллагад ажил горилогчдыг сонгон шалгаруулахдаа тэдний хэвлэл мэдээллийн мэдлэгийн түвшинг тодорхойлох асуултуудыг асуух шаардлагатай.

ХММСБ нь хэрэглэгчидтэй харилцан яриа өрнүүлэх, чанартай медиа контент үйлдвэрлэхэд чухал хүчин зүйл болдог. Сэтгүүлчдийг ажилд авахдаа үүнийг анхаарахаас гадна ажиллаж буй бүрэлдэхүүний мэргэжлийн түвшнийг ахиулах, улмаар тэдний бүтээлч идэвх зүтгэлийг дэмжих үйл ажиллагааг редакцын бодлогод багтаах ёстой.

Цаашилбал, сэтгүүлчдийн эрхийг хамгаалахад эв нэгдлийн зарчмыг баримтлах зохицуулалтыг редакцын бодлогод тусгах нь чухал ач холбогдолтой. Сэтгүүлчид хэвлэл мэдээллийн боловсролыг хөгжүүлэх явцад хамт олон дотроо эсэргүүцэл, зөрчилдөөнтэй байнга тулгардаг. Ийм тохиолдолд зөрчилдөөнийг шийдвэрлэхэд редакцын нэгдмэл хандлага, эв нэгдлийн зарчмыг баримтлах нь чухал юм. Өнөөгийн сэтгүүлчид болон уншигчдын хоорондын идэвхтэй харилцаа өндөр байгааг харгалзан редакц бүр ийм бодлоготой байх ёстой.

3.6 ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮНИЙ ЭРХ. СЭТГҮҮЛ ЗҮЙ БА ХММСБ ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын зарчмууд нь хүний эрхийн үндсэн зарчимтай төстэй. ХММСБ нь бидний амьдарч буй онлайн ертөнцөд хүний хангах чухал хэрэгсэл юм. Доорх харьцуулсан хүснэгтээс ХММСБ-ын гол зорилго нь хэвлэл мэдээллийн мэдээллийн орон зайд хүний эрхийг хамгаалах явдал гэдгийг харж болно.

ХММСБ-ын хөтөлбөрүүд нь үзэн ядах үзэл санааг өдөөсөн кампанит ажил, хөдөлгөөнд тодорхой бүлгүүд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Үүнд цагаачид, дүрвэгсэд, шашин шүтлэг, арьсны өнгө, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг цөөнхийн бүлгүүд, түүнчлэн хүйс, нийгмийн байдлаас хамаарсан үзэн ядалтыг дурдаж болно.

70 Zhilavskaya, Irina Vladimirovna. Media information literacy as a new direction in media education // Magister Dixit. 2011. №3. URL: <https://cyberleninka.ru/article/n/mediainformatsionnaya-gramotnost-kak-novoe-napravlenie-v-mediaobrazovanii>

Gendina, N.I., Kolkova, N.I., Starodubova, G. A., Ulenko Yu. V. Formation of an information culture of a person: theoretical substantiation and modeling of the content of an academic discipline. M.: Interregional Center for Library Cooperation. M.: Межрегиональный центр библиотечного сотрудничества, 2006.

ХММСБ	Хүний эрх
Шаардлагатай мэдээллийг үр дүнтэй хайж олох чадвар	Хүний мэдээлэл олж авах эрх
Хортой, хэт их контентоос өөрсдийгөө хамгаалах чадвар	Хүний хувийн нууцыг хамгаалах эрх
Мэдээллийн өөр эх сурвалжийг ашиглан мэдээллийг шалгах, шүүмжлэлтэйгээр үнэлэх чадвар	Хүний сонголт хийх эрх
Мэдээллийг зохих ёсоор хүлээн авах чадвар ба үр дүнтэйгээр (зөв) ашиглах	Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх
Хуулийн шаардлагын дагуу мэдээллийг үр дүнтэй, хангалттай түгээх чадвар	Мэдээлэл түгээх хүний эрх

Үзэн ядсан үг хэллэг бол хүний эрхэнд хамгийн их хор хөнөөл учруулдаг зүйлсийн нэг юм. Цахим орчинд дайрч доромжлох, нэр төрийг гутаах хандлага улам бүр түгээмэл болж байгаа бөгөөд үүнтэй тэр бүр хариуцлага тооцохгүй байна. Худал мэдээ, гэрэл зурагт шүүмжлэлтэй ханддаггүй хүмүүс ийм төрлийн мэдээлэлд амархан автаж, хувь хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн нэр төрийг гутаан доромжлох зорилготой хөдөлгөөнийг ухамсаргүйгээр дэмждэг. Тиймээс сэтгүүлчид үзэн ядалтыг өөгшүүлсэн, ялгаварлан гадуурхсан, гутаан доромжилсон агуулга, тэдгээрийн сөрөг үр дагаврыг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлбарлаж, мэдээлэх үүрэгтэй.

Хувийн мэдээлэл, хувийн нууцыг хамгаалах нь өнөөгийн ертөнцөд тулгамдаж буй өөр нэг асуудал болоод байна. Интернэтийн орчинд хувийн мэдээлэлд хандах, бусдад дамжуулах нь урьд өмнөх үеэс хамаагүй илүү хялбар, хурдан болсон. Бид бараа, үйлчилгээ худалдан авах, тоглох, суралцах, татвар төлөх зорилгоор мэдээллээ цахим орчинд үлдээж байгаа эсэхээс үл хамааран бидний хувийн мэдээлэл сүлжээнд хадгалагдаж үлддэг.

Цахим орчинд, нэн ялангуяа нийгмийн мэдээллийн сүлжээнд нийгмийн харилцаа улам бүр эрчимжиж байгаа нь шинэ боломжуудыг бий болгож байгаа ч бидний хувийн нууцад эрсдэл учруулж байна. Интернэтийн хязгааргүй шинж чанарын улмаас өөр өөр зорилго, амьдралын үнэт зүйлс бүхий улс орнууд болон өөр өөр хүмүүсийн хооронд мэдээлэл чөлөөтэй урсаж байна. Тиймээс бид хувийн нууцаа хамгаалахын тулд зорилготойгоор ажиллах нь чухал юм.

3.7 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА: ХММСБ-ЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Сэтгүүлчид цахим орчны мэдээллийн гажуудал, уялдаа холбоо, ардчилсан нийгэм дэх улс төр, олон нийтийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөөг ойлгодог болсон. Улмаар худал ташаа мэдээлэл түгээж буй хүмүүсийн зорилго сэдэл, хүлээж буй ашиг тусыг илрүүлэх мэдлэг, чадвартай болох нь чухал.

Юун түрүүнд “Худал мэдээлэл” болон «Ташаа мэдээлэл» хэмээх ойлголтуудыг ялгах хэрэгтэй.

Ташаа мэдээлэл гэж төөрөгдүүлсэн, худал мэдээлэл агуулсан, гэхдээ хор хөнөөл учруулах зорилгоор бүтээгдээгүй контент юм.

Худал мэдээлэл гэдэгт хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс оронд хор хөнөөл учруулах зорилгоор, санаатайгаар бүтээгдсэн худал мэдээлэл хамаарна.

Хортой агуулга нь үнэн зөв боловч хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс оронд санаатайгаар хохирол учруулахад ашигласан мэдээлэл

Зураг 15. Худал мэдээллийн төрлүүд⁷¹



Дээрх зургаас мэдээллийн гажуудлын төрөл нь хохирол учруулах зорилго, сэдлээс хамаарч байгааг харж болно. Улс төрийн сонгууль, тодорхой бүс нутагт явуулж буй цэргийн ажиллагаа, олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой үйл явдал болох үеэр гэх мэт онцгой цаг үеэр худал, гуйвуулсан, төөрөгдүүлсэн мэдээллийн урсгал ихээхэн нэмэгддэгийг анхаарах нь чухал юм.

Нийгмийн сүлжээний хамгийн түгээмэл платформ болох Facebook нь ташаа, худал мэдээлэл, гуйвуулсан контентын эсрэг идэвхтэй тэмцэж,

71 Claire Wardle, Hossein Derakhshan, “Information Disorder. Toward an interdisciplinary framework for research and policymaking”, Council of Europe, 2017.

ташаа мэдээллийн эх сурвалжийг хянах, устгах системийг нэвтрүүлээд буй. Мэдээллийн урсгалын дүн шинжилгээнээс харахад, АНУ-ын иргэдийн дөнгөж 14% нь нийгмийн мэдээллийн сүлжээнээс мэдээлэл авдаг. Гэсэн хэдий ч эдгээр сувгуудаар төөрөгдүүлсэн мэдээлэл олны анхаарлыг татаж, дахин нийтлэгдэж, маш олон тооны хүнд хүрч байгаа аж. ⁷²



Алхам 1. Фэйсбүүк худал мэдээлэлтэй хэрхэн тэмцдэг вэ. Тодорхой агуулгад хэрэглэгчдийн үзүүлж буй хариул үйлдэл дээр үндэслэн тухайн контентыг шинжилдэг.

95



Эх суралж: Инфографикийг Даниэл Функе

<https://www.poynter.org/news/how-facebook-deals-misinformation-one-graphic/>

⁷² Alcott, H. & Gentzcow, M. (2017). Social Media and Misinformation and disinformation in the 2016. Elections. Journal of Economic Perspectives 31(2), 211—236.


Алхам 2. Шалгуурын дагуу агуулгыг үнэлнэ:

- сонгогчдын идэвхийг бууруулах агуулга
- хүчирхийллийн бодит заналхийлэл бүхий агуулга.
- ФБ хэрэглэгчийн дүрмийг зөрчсөн

Хэрэв тийм бол мэдээллийг устгана.



Эдгээр үзүүлэлтүүд дээр сөрөг үр дүн гарсан тохиолдолд агуулгыг баримт шалгагчдад илгээдэг.



Politifact эсвэл Snopes гэх мэт эх сурвалжууд нь “худал мэдээлэл”, “холимог агуулга”, “зөвхөн гарчиг”, “үгүй” гэсэн шалгуураар мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулдаг. Худал мэдээллийн шинж чанар агуулсан төөрөгдүүлсэн контент илэрвэл Facebook нь тухайн материалын хандалтыг тоог бууруулдаг. Нийгмийн мэдээллийн сүлжээ нь нөлөө бүхий хүчирхэг суваг учир аливаа агуулга бэлтгэж түгээхдээ худал ташаа мэдээлэл түгээхэд хувь нэмэр оруулахгүй байхыг хичээх нь чухал.

3.8 ХММСБ ПРАКТИКТ: ӨӨРИЙГӨӨ ҮНЭЛЭХ ДАСГАЛ

Ялангуяа нийгмийн мэдээллийн сүлжээ, Интернэт гэх мэт найдваргүй эх сурвалжаас авсан мэдээлэлд эргэлзэх хандлага чухал. Олон улсын баримт шалгагчдын сүлжээнээс мэдээллийн эх сурвалж, агуулгыг шалгахын тулд хийж болох алхмуудыг тодорхойлсон хяналтын хуудсыг боловсруулсан байдаг.⁷³

Сүүлийн үед мэдээллийн урсгалын хэмжээ жил бүр 30 хувиар нэмэгдэж байгаа гэх судалгаа бий. Энэ цаг үед сэтгүүлчид тодорхой мэдээллийн үнэн зөв, бодитой, найдвартай байдлыг шалгахын тулд дээр дурдсан болон бусад нөөц хэрэгслийг ашиглах боломжтой.⁷⁴



1.Хуурамч мэдээллийн хэрэгслээс болгоомжлоорой. Зарим сайт албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслийг шинж тэмдгийг дуурайх, мөн хэвлэл мэдээллийн хаягийг дуурайж итгэл үнэмшил олж авахыг хичээдэг.



Та хэвлэл мэдээлэлд итгэдэггүй байж болно, гэхдээ энэ нь найдвартай эх сурвалж хэмээн тооцогддог. Учир нь уг мэдээллийг сэтгүүлчид бэлтгэдэг бөгөөд, худал мэдээлэл түгээвэл тэдэнтэй хариуцлага тооцдог юм.

Та хэвлэл мэдээлэлд итгэдэггүй байж болно, гэхдээ энэ нь найдвартай эх сурвалж хэмээн тооцогддог. Учир нь уг мэдээллийг сэтгүүлчид бэлтгэдэг бөгөөд, худал мэдээлэл түгээвэл тэдэнтэй хариуцлага тооцдог юм.



2. Мэдээллийг бусад эх сурвалжаас дахин шалгана уу. Хэрэв энэ нь найдвартай мэдээлэл бол бусад эх сурвалжууд дээр мөн нийтлэгдэх болно. Таны мэддэг эх сурвалжуудтай ижил төстэй эсвэл ижил нэртэй хуурамч хаягаас болгоомжил.



Эх сурвалжийг шалгана уу
Таны хүлээн авсан мэдээллийг аль эх сурвалжаас дамжуулсныг олж мэдэх шаардлагатай. Гарчиг, зураг, эсвэл холбоосыг шалгах нь тийм ч чухал биш.

73 <https://www.poynter.org/news/> Fred fact doesn't fall for misinformation and disinformation. Brazilian fact-checking platform Aos Fatos, April 2018.

74 <https://ru.wikipedia.org/wiki>

3) Зохиогчийн нэрийг шалга
Үүнийг хэн бичсэн бэ гэж өөрөөсөө асуу



Овог нэр 1998 оноос хойш
сэтгүүлчээр, 2012 оноос хойш Truthful
News-д ажиллаж байна. ... сэдвээр
дагнан бичдэг

ЗОХИОГЧООС:

- Ижил төстэй бүтээлийн тухай
- Өөр сэдвээр бичсэн бүтээлийн талаар

Бүтээл дээр зохиогчийн нэр байх тохиолдолд уг бүтээлийн хариуцлагыг
сэтгүүлч өөрөө хүлээнэ гэсэн үг. Уг сэтгүүлчийн бусад бүтээлийг олж унших,
эсвэл өөртэй нь холбоо барьж асуулт асуух нь зүйтэй.

3. Зохиогчийн нэрийг
шалгах хэрэгтэй.
Туршлагатай бичигч бол
өмнөх бичвэр, бүтээлийн
түүх зэргийн талаар
мэдээлэл олдоно.

Зураг, бичлэгийн талаар
эргэлзээ төрж байвал
4) Google-ээс асуугаарай

Google



Тухайн зургийг Google хайлтын
цонх руу чирж оруулна

AMNESTY
INTERNATIONAL


Youtube DataViewer

Video URL


Youtube Dataviewer ашиглан видео
бүтээлийг нягтлах боломжтой

4. Хэрэв та зураг эсвэл
видео бичлэг бодитой
эсэхэд эргэлзэж байгаа
бол хайлтын системд
байршуулж болно. Мөн
Youtube DataViewer-ээр
видео шалгах боломжтой.

Мөн 5) статистик тоог нягтлан
шалгах боломжтой



Дата мэдээлэл болон цаг
хугацааны шугамыг шалгаарай.
Тоон мэдээлэл дутуу байх нь чухал
мэдээлэл юм шүү.



5. Мөн та тоон мэдээллийг
статистикийн эх
сурвалжаас шалгаж үзэх
хэрэгтэй. Статистик бол
нарийн зүйл бөгөөд зугаа
цэнгэл, сэтгэл хөдлөлөөс
ангид, логик дараалалтай,
цаг хугацааны, тоон болон
чанарын өгөгдлийг
агуулдаг. Бүрэн бус дүр
төрх илэрвэл чухал
мэдээллийг нууж байж
болзошгүй.



Та ганцаараа биш гэдгийг санаарай!
Тусалцаа хэрэгтэй бол
7) Мэргэжлийн хүнд ханд




POLITIFACT

Баримтыг нягтлан шалгадаг сайтууд цөөнгүй бий.

Мэдээж хэрэг тэд бүх мэдээллийг хянаж амжихгүй. Гэхдээ ихэнхдээ олны анхаарлын төвд байгаа мэдээллийг нягталсан байдаг.

6. Танд туслах боломжтой мэргэжилтнүүд байгаа эсэхийг шалгаарай. Баримт шалгах олон вэбсайт байдаг боловч зарим мэдээллийг тэд хараагүй байж болно. Мөн ташаа мэдээлэлтэй тэмцэхэд та өөрийн хувь нэмрийг оруулж чадна.



Баримтыг нягтлах санал:

Сайнуу, би нэг мэдээллийг шалгаад өгөөч гэж хүсэх гэсэн юм. 2018 оны 4 сарын 4-нд сайтад нийтлэгдсэн зүйл худал байх гэж бодож байна. Үүнийг шалгаж үзэх боломжтой юу?

Шалгуулах агуулгын холбоос:

<https://truthfulnews.com/45663451>

Мэдээллийн зохиогч эсвэл эх сурвалж:

So-and-So Surname / Truthful News

Send

Зүгээр л асуугаад үз. Зарим сайт олон хүн д хүрсэн, худал байж болзошгүй мэдээллийг хүсэлтийн дагуу шалгаж өгдөг. Хэрэв Таныг асуулт тэдний бодлоготой нийцэж байвал тэд шалгаад өгөх болно.

7. Та уг мэдээллийн зохиогч, эх сурвалж гарчиг зэргийг дурдаад, үнэн эсэх талаар тодруулга авч болно.

99


"Мэдээлэл үнэн эсэхийг мэдэхийн тулд ийм их ажил болдог юм уу?"




Тиймээ. Хэрэв та мэдээллийг нягтлахгүйгээр бусдад дамжуулбал энэ нь явсаар таны гэр бүл, найз нөхдөд хүрнэ. Тэд нягтлахгүй бол мөн л худал мэдээлэл тэдний найз нөхдөд очно гэх мэтчилэн.



8. Ганцхан ташаа мэдээллийн төлөө ийм их хүчин чармайлт гаргах хэрэгтэй гэж үү? Хариулт нь тийм. Таны дамжуулсан ташаа мэдээлэл хамаатан садан, найз нөхдөд, улмаар олон сая хүнд хүрнэ. Худал мэдээлэл нь хувь хүн, нийгэмд хохирол учруулах зорилготой байдаг. Та ганцхан товшоод энэ гинжин урвалыг өөрчилж чадна.





IV ХЭСЭГ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН
ГАРЫН АВЛАГА

ХЯНАХ ХУУДАС ГЭЖ ЮУ ВЭ?

Хянах хуудас бол үйлдлийн алгоритм, өөрөөр хэлбэл өөрийгөө нягтлан шалгах энгийн бөгөөд ойлгомжтой хэрэгсэл юм. Хянах хуудас нь хяналтын шалгуур, асуулт эсвэл хийх ажлын жагсаалтыг агуулдаг. Энэ нь ажлын чухал хэсгийг анхааралдаа байлгах, цаг хугацаа хэмнэх, алдаа гаргахаас сэргийлэх, мэдээллийг бүтцэд оруулахад тустай юм. Ийм жагсаалт нь мэдээллийн эх сурвалжтай ажиллах үед сэтгүүлчийн ажлын чухал элемент болдог. Энэ гарын авлагад орсон хянах хуудсууд нь медиа үйлдвэрлэлийн явцад үйлдвэрлэлийн өмнөх, үйлдвэрлэлийн үеийн, мөн үйлдвэрлэлийн дараах үе шатанд хэрэг болно.

4.1. ХЯНАХ ХУУДАС №1: ХММСБ-ЫГ ХЭРХЭН СУРТАЛЧЛАХ ВЭ?

Судлаачид ХММСБ-ын гол цөм болсон чадавхыг сэтгүүлчдэд зориулж доорх байдлаар тодорхойлсон байдаг. Харин хэвлэл мэдээллийн сургагч багш нар сургалтын явцад эдгээр шаардлагыг харгалзан үзэж, тэдгээрийг хангах арга барилыг боловсруулж, ашиглах чадвартай байх ёстой. Эрхэм уншигч та сэтгүүлчдэд эдгээр чадварыг хэрхэн үр дүнтэй эзэмшүүлэх талаар бодож, тодорхойлоорой. Хүснэгтийг бөглөхдөө та өөрийн туршлага, мэдлэг дээр төвлөрөх хэрэгтэй. Өөрөө өөртэйгөө ажиллах нь «ХММСБ-ыг хэрхэн сурталчлах вэ»хэмээх үйл явцын гол зарчим юм.

Сэтгүүл зүйн чадавх	Сэтгүүл зүйн багш нар тэдгээрийг хэрхэн хөгжүүлэх ёстой вэ (ЖИШЭЭ-нд үндэслэн өөрөө гүйцээж бичнэ үү)
Бичих, өгүүлэх чадвар, зохиомжийн тухай ойлголттой байх.	
Мэдрэмжээ үг, дүрс, хөгжмөөр илэрхийлэх чадавх.	
Өөр өөр дүрийг тодорхойлж, өөрийгөө оронд нь тавьж үзэх, дүрийн хувийн туршлага, мэдрэмжийг өөрийнхтэйгөө харьцуулах чадавх.	
Хэвлэл мэдээллийн агуулга бүтээх явцад өөрийгөө болон хувийн онцлог шинжээ илэрхийлэх чадавх.	
Өөрсдийн үнэт зүйлс, хандлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гардагтай харьцуулах чадавх.	
Хэвлэл мэдээллийн агуулга, утга санаанд дүн шинжилгээ хийх чадвартай байх.	
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй янз бүрийн үзэл бодлыг хүлээн авах, хэлэлцүүлэгт оролцох чадавх, бусдын үзэл бодлыг ойлгох, сонсох чадвар	ЖИШЭЭ: Нийгмийн болон мэргэжлийн янз бүрийн сэдвээр мэтгэлцээн зохион байгуулах
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх хувийн болон нийтийн орон зайг ялгах чадвар, үг хэлэх эрх чөлөөний зарчмыг мэддэг байх.	
Хэвлэл мэдээллийг идэвхтэй ашиглах, оролцох янз бүрийн арга замын талаар ойлголттой байх.	

Хэвлэл мэдээллийн агуулгад тавих насны хязгаарыг ялгах чадавх.	
Интернэтийг аюулгүй ашиглах чадвар, виртуал орон зайд мэдээлэл, хувийн нууцлалыг хэрхэн хамгаалах талаар мэддэг байх.	
Интернэт дэх харилцааны хэм хэмжээ, зөв зан үйлийн талаар ойлголттой байх, тэдгээрийг сахих.	
Хэвлэл мэдээллийн хэрэгслэгчдийн хууль ёсны эрх, үүргийг мэддэг байх	
Интернэтийн дүрэм, хуулийг дагаж хэвлэл мэдээллийн хэрэгслийг янз бүрийн аргаар ашиглах.	

4.2. ХЯНАХ ХУУДАС № 2: СЭТГҮҮЛЧИЙН СУРВАЛЖИЛГАД ХММСБ-ЫГ ХЭРХЭН НЭГТГЭХ ВЭ?

Доорх хүснэгтийн сэтгүүл зүйн үндсэн зарчим болон ХММСБ-ын зарчим дотроос хамгийн төстэй болон ялгаатай зарчмуудыг олно уу.⁷⁵

Сэтгүүл зүйн үндсэн зарчим ⁷⁶	ХММСБ -ын үндсэн зарчим
1. Үнэнийг мэдээлэх нь сэтгүүл зүйн тэргүүн үүрэг юм.	1. Үнэнийг эрэлхийлэх үйл явцад үр дүнтэй оролцох боломжийг олгоно.
2. Иргэдийн эрх ашигт үнэнч байна.	2. Иргэдийг чадавхжуулахад гол анхаарлыг хандуулна.
3. Сэтгүүл зүйн мөн чанар нь нягтлан шалгах сахилга бат юм.	3. ХММСБ нь хувь хүний нягтлан шалгах дадлыг хөгжүүлнэ.
4. Сэтгүүлчид сурвалжилж буй эх сурвалжаас хамааралгүй, хараат бус байх ёстой.	4.ХМССБ нь хүнд юу бодох, хэрхэн бодохыг заах бус, аливааг эргэцүүлэн бодох дадалд сургах тухай юм.
5. Эрх мэдлийг хараат бусаар хянах үүргийг гүйцэтгэнэ.	5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь 4 дэх засаглал бол ХММСБ 5 дах засаглалыг (иргэдийн) бий болгодог.
6. Олон нийтийн шүүмжлэл, зөвшилцлийн талбарыг хангана.	6. ХММСБ нь олон нийтийн яриа, хэлэлцүүлэгт оролцох боломжийг олгодог.
7. Чухал ач холбогдолтой зүйлийг сонирхолтой бөгөөд хамааралтай болгоно.	7. ХММСБ хүний сониуч зан, технологийн эрэл хайгуулыг идэвхжүүлж, мэдээлэл, хэвлэл мэдээлэл яагаад хамаатай бөгөөд чухал болохыг ойлгуулдаг.
8. Бүрэн дүүрэн, тэнцвэртэй мэдээлнэ.	8. ХММСБ нь мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон төрөл байдгийг ойлгуулна.
9. Сэтгүүлчид хувийн мөс чанараа илэрхийлж болно.	9. ХММСБ нь хүн бүрд заяагдсан ухамсар, хүн чанарыг дэмждэг.

⁷⁵ Source: Alton Grizzle, Unpublished Work.
⁷⁶ White, A. (2008). To Tell You The Truth. The Ethical Journalism Initiative. Brussels, Belgium: International Federation of Journalists.

4.3. ХЯНАХ ХУУДАС №3: ЭХ СУРВАЛЖ ДЭЭР АЖИЛЛАХ

- ☐ Таны сэдвийг тодорхойлох суурь нөхцөл байдлын талаар та юу мэдэх вэ?
- ☐ Энэ сэдвээр статистик мэдээлэл бий юу?
- ☐ Сэдвийн талаар санал асуулга явуулж байсан уу?
- ☐ Ямар мэргэжилтэн баримтыг баталж/хэлж чадах вэ?
- ☐ Тухайн газрын хэдэн мэргэжилтэнтэй ярилцлага хийх шаардлагатай байна вэ?
- ☐ Тухайн сэдвээр хэдэн олон улсын мэргэжилтэн олж болох вэ?
- ☐ Нэмэлт/ дүрсжүүлсэн нотолгоо байгаа эсэх.
- ☐ Сэдвийн талаарх мэдээллийг баталсан/ үгүйсгэсэн социологийн судалгаа байдаг уу?
- ☐ Энэ сэдвээр аль хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэмэлт мэдээлэл түгээсэн бэ?
- ☐ Сэдвийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн дэлгэрүүлж мэдээлсэн бэ?
- ☐ Ямар нэг баримтат эх сурвалж байна уу?
- ☐ Цуглуулсан материалын хэдэн хувийг Интернэт эх сурвалжийн материал бүрдүүлж байна вэ?
- ☐ Ярилцлагын аудио бичлэг бий юу?
- ☐ Хүлээн авсан баримтын хэд нь/ аль нь нүүр хуудсанд тавигдах ёстой/ боломжтой вэ?
- ☐ Олж авсан баримтын хэд нь/ аль нь нэмэлт материал болох вэ?
- ☐ Гарчигт оруулах баримт байна уу?
- ☐ Материалд нэмж оруулах дүрс бүхий нарийвчилсан мэдээлэл байна уу?
- ☐ Инфографик бэлтгэхэд ашиглаж болох мэдээлэл байна уу?
- ☐ Хүлээн авсан мэдээлэл таны материалын сэдэвт тохирч байна уу?

105

4.4. ХЯНАХ ХУУДАС №4: СЭТГҮҮЛ ЗҮЙН БИЧВЭР ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Өгүүллийн гол санаан дээр ажиллах (45 мин)

☐ Үндсэн санаагаа томъёолох

Миний нийтлэлийн гол санаа юу вэ? хэмээх асуултад хариул. Санаагаа товч бөгөөд богино хэлбэрээр илэрхийл. 1-2 өгүүлбэр байхад болно. Удаан бодож гацахгүйн тулд 10-15 минут сэрүүлэг тавих нь тустай байдаг.

☐ Урьдчилсан гарчиг өгөх

Гарчиг нь нийтлэлийн гол утга агуулгыг тусгах ёстой, гэхдээ үүнийг удаашруулж

ахин дахин засварлах хэрэггүй, учир нь та сүүлд буцаад өөрчилж болно. Явцыг удаашруулахгүйн тулд 20-30 минут сэрүүлэг тавьж ажиллавал тустай байх болно.

Өгүүллийн бүтцийг гаргах (30 мин)

☐ **5-7 дэд гарчиг өгөх**

Өгүүллийн дэд сэдвүүдийг бич. Та тэдгээрийг майнд мэл буюу оюуны зураглал хэлбэрээр товлож болно. Дэд гарчиг олон байх тусмаа сайн. Үүн дээр гацахгүйн тулд сэргүүлэг тавьж 15-20 минут ажиллана.

☐ **3-4 түлхүүр дэд гарчгийг сонгох.**

Үндсэн сэдвээ дахин уншиж, гол санааг тусгахад хамгийн чухал 3-4 дэд сэдвийг сонгоно.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний цагийн хуваарилалтыг нарийвчлан гаргана (~ 60 минут)

☐ **Дэд сэдэв бүрд цаг хуваарилах.**

Дэд сэдэв бүрийн өмнө түүнийг бичихэд хэдэн минут зарцуулахыг бичиж тэмдэглэнэ. Тайлбар зураг хайх, схем зохиох зэргээ бодолцож үзээрэй.

“Үр дүн”-д цаг хуваарилна

Дүгнэлт бичих хугацаа нь дэд сэдвийг бичих хугацаанаас их байж болохгүй. Үр дүнг бичихдээ нийтлэлд дурдсан үндсэн санаагаа л товчхон дурдах хэрэгтэй. Үр дүнг «Өмнө нь энэ цувралд...» гэсэн хэв маягаар бичих ёстой.

☐ **Хянан унших цагийг хуваарилах**

Алдаагаа засах, нэр томъёог илүү оновчтой болгох цаг болжээ.

☐ **Огноог заах**

Хүлээн авсан төлөвлөгөө нийтлэлийг гаргах хугацаатай авцалдаж байгаа эсэхийг шалгаж, хэрэв үгүй бол нийтлэлийн аль хэсгийг хасаж болохыг шийднэ.

☐ **Ажлын төлөвлөгөө гаргах (хэвлэх).**

Шаардлагатай хугацаа, эцсийн хугацааг үндэслэн ажлын үе шат бүрд тодорхой огноо заасан файл (текст эсвэл цахим хүснэгт) үүсгэнэ. Бодитоор зарцуулсан цагийг тэмдэглэх зайг хуваарилна. Төлөвлөгөөг хэвлэж сайн харагдах газар өлгөнө.⁷⁷

4.5. ХЯНАХ ХУУДАС № 5: НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРЬЦАХ

☐ **Өгөгдлийн эх сурвалжийг баталгаажуулах.**

Эх сурвалжийн талаар лавлагаа байхгүй бол ийм өгөгдлийг баталгаатай гэж үзэх боломжгүй тул дахин шалгах шаардлагатай. Ийм мэдээллийн сан маш бага үнэлгээтэй байдаг.

☐ **Өгөгдлийн формат ямар байна вэ?**

.xls, .csv - сайн мэдээллийн сан, .docx, .pdf - мэдээллийн сан биш.

⁷⁷ E version is available online at <http://checklists.expert>

- ☐ Бид **өгөгдлийг** OpenRefine эсвэл Excel дээр **боловсруулдаг**.
- ☐ **Хувьсагч бүр** тусдаа баганад байгаа эсэхийг нягтална.
- ☐ **Хувьсагчийн тодорхойлолт** тусдаа мөрөнд байгаа эсэхийг нягтална.
- ☐ **Бүлэг хувьсагчид** зориулсан тусдаа хүснэгт байгаа эсэхийг нягтална.
- ☐ **Бие даасан хүснэгтүүд** хоорондоо нийтлэг баганаар **холбогдсон** эсэхийг нягтална.

4.6. СЭТГҮҮЛЧИЙН ХММСБ-ЫН ДЭВТЭР

Дасгал 1

Эх сурвалжийн найдвартай байдлыг шалгах – эх сурвалж нь хүн.

Алхам 1	Энэ хүн ийм төрлийн мэдээлэлд хандах боломжтой юу?	
Алхам 2	Түүний өгсөн мэдээлэлд баталгаажуулах боломжтой дэлгэрэнгүй мэдээлэл байна уу?	
Алхам 3	Энэ эх сурвалж өмнө нь мэдээлэл өгч байсан уу, мэдээлэл нь батлагдсан уу?	
Алхам 4	Түүний зорилго юу вэ?	
Алхам 5	Энэ нь нээлттэй эх сурвалж уу, эсвэл түүний нэрийг дурдалгүйгээр нийтлэх шаардлагатай юу?	
Алхам 6	Илүү өргөн мэдээлэлтэй эх сурвалж бий юу?	

107

Дасгал 2

Ярилцлага хийхдээ та хамгийн дээд түвшний хэвлэл мэдээллийн мэдлэгтэй байх ёстой, учир нь тодорхой бус байдлыг зохиомлоор бий болгох хэд хэдэн арга байдаг, арай энгийнээр хэлбэл, мэдээллийг залж чиглүүлэх (manipulating information) арга техник байдаг. Ийм арга ашиглахыг «манипуляцийн риторик» гэж нэрлэдэг.

Та иймэрхүү арга техникийг ашиглаж байхтай таарч байсан уу? Өөрийн практикаас жишээ авч, аргыг тайлбарлана уу.

- “**тодорхой бус үгс**” - яриандаа хүн бүр өөр өөрийн утгаар ойлгож илэрхийлдэг олон утгатай үг хэллэгийг хэрэглэнэ. Ийм илэрхийлэл нь уриа лоозонгийн шинж чанартай бөгөөд тодорхой онцлог агуулдаггүй. Тухайлбал, “Бид эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн төлөө байна”.

- “**үйлдэгчийг орхиж ярих**” эсвэл хийсвэр бүлэг хүмүүсийн тухай дурдах, жишээлбэл, “Бүх ухамсартай иргэд биднийг дэмждэг” гэх мэт.

- “**Холбох**” арга нь өөр хоорондоо нийтлэг шалтгаан, үр дагаврын холбоогүй янз бүрийн үйл явдал, баримт, үзэгдлийг нэгтгэдэг, жишээлбэл: “Депутатууд Парламентын танхимд сууж байхад уурхайчдын хүүхдүүд өлсөж байна».

- “**Хууль бусаар ерөнхийлөх**” гэдэг нь “... шахуу”, “бараг” гэх мэт үгсийн тусламжтайгаар ерөнхийлөх, тодорхой зүйлээс зайлсхийх явдал юм.

- “**үг өөрчлөх**” — ярилцагч сэтгүүлчийн асуултыг өөрчилж, утга нь ойр боловч хариулт өгөхөд эвтэй үгээр орлуулж, хурц өнцгөөс зайлсхийх.

- “**Асуултыг хүлээн авах боломжгүй байх**” гэж ярилцагч хариултаас зайлсхийхийн тулд өөрийгөө энэ асуултад хариулах хүн нь биш эсвэл асуултыг ингэж тавих боломжгүй гэх зэргээр булзааруулах юм.

Дасгал 3

“Миний баатар” дүрд тоглох тоглоом. Хамгийн ойрын хүрээллээсээ дүр сонгоод сэтгэл зүй, хүн ам зүй, социометрийн шинж чанараар нь түүний хөргийг бүтээ. Дүрийнхээ дүр төрхийг «зур».

Дасгал 4


“Түүхэн хүн” тоглоом. Түүхэн дүрийг сонгож, тэдгээрийн талаар аль болох олон янзын мэдээлэл цуглуулж, баатрын хөргийг түүхэн нөхцөл байдалд нь бүтээнэ.

Түүхэн хүн	Хувь хүний мэдээлэл	Түүхэн үйл явдлын тухай баримт
Түүхэн хүн	1	1.
	2.	2.
	3.	3.
	4.	4.

Дасгал 5

ФОРМАТ СОНГОХ

Дараах дүрсний форматад тохирох тайлбар, онцлогийг тус тус харгалзуулж сумаар холбоно уу.

Видео		Тоо ба өгөгдөл.
Аудио		Нэг цаг хугацаанд нэг сэдэв, дүр, асуудлаар холбогдсон цуврал үйл явдал.
Текст		Статик дүрслэл.
Фото		Нөхцөл байдлын дүрслэл, чухал логик мэдээлэл бүхий өгүүлэмж.
Фото слайдер		Цаг хугацаа, газарзүйн байршилтай холбоотой цуврал үйл явдал.
Инфографик		цаг хугацаа, орон зайд өөрчлөгддөг үйлдэл.
Цаг хугацааны зурвас		ярианы шинж чанарыг нь хадгалж үлдээх нь чухал шинжээчийн дүгнэлт эсвэл дүрийн сэтгэл хөдлөлтэй гүйцэтгэл.
Интерактив газрын зураг		Дүрсний тод сэтгэгдэл төрүүлэх цуврал.

Дасгал 6

Даалгавар: эх сурвалж вэбсайтын найдвартай байдлыг шалгах

Нягтлах алгоритм:

Үе шат	Хийх зүйл
Алхам 1	Домэйн нэрд анхаарах хэрэгтэй. Мэдээллийн агентлаг, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ихэвчлэн өөрийн гэсэн домэйн нэртэй байдаг
Алхам 2	Нийтлэлд зохиогч болон хэвлэгдсэн огноог заасан байх ёстой.
Алхам 3	Сайтад «Бидний тухай» гэсэн булан, редакцын бүрэлдэхүүний жагсаалт байх ёстой. Ташаа мэдээлэл, худал мэдээллээр мэргэшсэн, иймэрхүү үйл ажиллагаа явуулдаг ихэнх сайт энэ талаараа «Бидний тухай» хэсэгт дурдсан байдаг. Хуурамч мэдээ үйлдвэрлэгч энтертайнмент вэбсайтууд: Onion. Fog News. HOBO-STI. Smixer.

Алхам 4	Ихэнх вэбсайт “Бидний тухай” хэсэгтээ нийтлэлийн зорилгоо тодорхойлдог. Хэрэв энэ хэсэг нь сүртэй, бичсэн зүйл нь тодорхой бус, хэт ерөнхий бол, энэ нь эргэлзээ төрүүлэх шалтгаан юм. Google ашиглан энэ мэдээллийн хэрэгслийн найдвартай байдлын талаар мэдээлэл хайж үзэх хэрэгтэй.
Алхам 5	Вэб сайтын агуулга нь өрөөсгөл, эсэхийг анхаарах хэрэгтэй.
Алхам 6	Агуулгын гарчигт дүн шинжилгээ хийх. Хэт дуулиантай гарчиг сайтын найдвартай байдалд эргэлзэх нэг шалтгаан байж болно.
Алхам 7	Материалын доорх сэтгэгдлийг харах хэрэгтэй. Хэрэв уг агуулгыг хэн нэг нь хуурамч гэсэн байвал анхааралдаа авах нь зүйтэй.
Алхам 8	Хэрэв материалд маргаантай сэдвийг хөндсөн бол уг материалд эшлэл орсон байх нь дамжиггүй. Үндэслэлгүй дүгнэлт эргэлзээ төрүүлэх ёстой.

Дасгал 7

Даалгавар: зургийн жинхэнэ эсэхийг шалгах.

Үе шат	Хийх зүйл
Алхам 1	Уг зураг өмнө нь нийтлэгдэж байсан эсэхийг шалгана. Үүний тулд Google Image Search эсвэл TinEye үйлчилгээг ашигладаг. Эдгээр үйлчилгээ нь ижил төстэй зургийн хайлт хийдэг. Зургийг огноо, хэмжээгээр нь эрэмбэлж, хооронд нь харьцуулна. TinEye мөн зургийн Интернэтэд тавигдсан огноог харуулдаг. Харьцуулах зургийг хамгийн сайн нарийвчлалтайгаар авууштай . Тэгвэл хайлтын систем эхийг хурдан олох боломжтой болно.
Алхам 2	Хуурамч зураг бүтээхдээ хоёр зураг эвлүүлж хийх нь олонтоо тохиолддог. Хэрэв ийм сэжиг байгаа бол зургийн хэсгүүдийг график засварлагчаар салгаж, тус бүрээр нь хайж олохыг хичээнэ.
Алхам 3	Гэрэл зургийг хуурамчаар бүтээх явцад зургийн хоёр хэсгийг нийлүүлж, нэг буюу хоёр хэсгийг эргүүлэх (толин тусгал хийх) тохиолдол их байдаг. Хайлтыг үр дүнтэй болгохын тулд та зургийг график засварлагчаар боловсруулж дахин хайлт хийж болно.

Алхам 4	Foto Forensics үйлчилгээ нь зурагт дижитал боловсруулалт хэрхэн хийгдсэнийг шалгах боломжийг олгодог. Энэ програм “зураг дээр нэмэгдсэн хэсэг”, хөдөлгөөн ороогүй болон засварласан хэсгүүдийг харуулдаг. Түүнчлэн өөрчилсөн хэсгийг зургийн дэвсгэр дээр тодруулан харуулна.
Алхам 5	Хуурамч зураг үүсгэх нэг арга бол жинхэнэ зурагт хуурамч тайлбар дагалдуулах явдал юм. Тиймээс зургийн тайлбарыг анхааралтай унших нь маш чухал, учир нь хоёр ижил зурагт өөр өөр тайлбар хийсэн байж болох юм.
Алхам 6	Зургийн эх сурвалжийг файлын URL хаягаас олж болно. Файлын нэр дээрх урт тооны дараалал нь зургийг олон нийтийн сүлжээнээс авсан байх магадлалтайг харуулдаг. Фэйсбүүк дэх зарим зургийн гарчигт нийтэлсэн хэрэглэгчийн ID агуулагдаж байдаг.
Алхам 7	Зураг дээрх дүрс мэдээлэл, тухайлбал замын тэмдэг, тэмдэглэгээ, машины тэмдэг, байшин барилга, хувцас, орчны элемент гэх мэт нь зургийг танихад тус болдог. Google Maps Street View эсвэл Wikimapia-д янз бүрийн газар орны зураг байдаг, тэдгээрийг өөрт байгаа зурагтай харьцуулах боломжтой. Geofeedia бол нийгмийн сүлжээн дэх нийтлэлийг газарзүйн байршлаар нь илрүүлэх боломж олгодог хайлтын систем юм. Энэхүү үйлчилгээ нь GPS ашиглан Twitter, Flickr, YouTube, Instagram, Picasa зэрэг сошиал сүлжээний нийтлэлтэй ажилладаг. Үр дүнг зургийн цуглуулга хэлбэрээр үзүүлдэг.

Дасгал 8

Хэрэглэгчийн акаунтын жинхэнэ эсэхийг шалгах алгоритм

Үе шат	Хийх зүйл
Алхам 1	Хүн үү, эсвэл бот уу гэдгийг тодорхойлох. Хувийн мэдээлэл, найз нөхдийнх нь пост, нийтлэлдээ тайлбар бичсэн байна уу эсвэл зүгээр л зураг оруулж байна уу гэдгийг анхаарч үзнэ. Хувь хүний өөрийн гэх агуулга байхгүй бол бид боттой харьцаж байна гэж үзэх үндэслэлтэй.
Алхам 2	Уг хаягаас хэдэн пост нийтэлсэн байна вэ? 2-3 бусдын пост хуваалцсан. Сэдвийн чиглэл нь өөр өөр бол үл итгэх шалтгаан болно.

Алхам 3	Хаягийг хэзээ үүсгэсэн бэ? Ихэвчлэн, тролл хийх зорилготой акаунтыг дайралтад өртөж буй пост нийгмийн сүлжээнд нийтлэгдмэгц шууд үүсгэдэг. Нэмж дурдахад, акаунт үүсээд удсан боловч тэнд зөвхөн 2-3 нийтлэл байгаа бол энэ нь үл итгэх шалтгаан болно.
Алхам 4	Профайл нь ажил, сургууль, оршин суух газар, сонирхлын хүрээтэй холбоотой байна уу?
Алхам 5	Энэ хэрэглэгч нийгмийн сүлжээн дэх ямар ямар хуудсыг дагадаг вэ, зочилсон группийн сэдэв нь түүний түгээж буй мэдээлэлтэй холбоотой байна уу?
Алхам 6	Профайл зургийн хайлтаар ямар үр дүн гарсан бэ?
Алхам 7	Хэрэглэгчийн нэрийн хайлтаар ямар үр дүн гарсан бэ?
Алхам 8	Дүгнэлт гаргана, шийдвэр гаргана..

Материал бичихдээ өөрийгөө шалгах хэрэгтэй. Учир нь хүмүүс сэдэвтээ хэт автах, тодорхой баримтад сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлэх, өөрийн үнэт зүйл, санаа бодлыг шингээх хандлагатай байдаг. Тиймээс, объектив байдлаа алдахгүйн тулд ажлын янз бүрийн үе шатанд өөрөөсөө дараах асуултыг асуух хэрэгтэй:

- Надад хувийн ашиг сонирхол байна уу?
- Би ямар үр дүнд хүрэхийг хүсэж байна вэ?
- Би баримтыг өөрийн таамаглалд нийцүүлэн тохируулж байна уу?

ТАЙЛБАР ТОЛЬ

Альтернатив баримт — нягтлах боломжгүй баримт (“Энэ бол баримт биш. Энэ бол худал зүйл” NBC-гийн хөтлөгч Чак Тоддын эшлэлээс).

Хэвлэл мэдээллийн хэрэглэгч – хэвлэл мэдээллийн тодорхой хэрэгслийг сонирхох сонирхлоороо нийтлэг уншигч, телевиз үзэгч, радио сонсогчдыг бүлэг.

Блог— 1. Интернэт дэх үйл явдлын тэмдэглэл, Интернэт дэх өдрийн тэмдэглэл, онлайн өдрийн тэмдэглэл. Үндсэн агуулга нь он цагийн урвуу дарааллаар толилуулсан текст, зураг эсвэл мультимедиа агуулсан тэмдэглэлийг тогтмол оруулдаг, гуравдагч этгээдийн нийтлэл, түүний холбоос дээр товч сэтгэгдэл, тайлбар зэргийг нийтэлдэг вэбсайт. Блог болон уламжлалт өдрийн тэмдэглэл хоорондын ялгаа нь ашиглаж буй технологитой холбоотой. Блог нь ихэвчлэн олон нийтэд нээлттэй бөгөөд хөндлөнгийн этгээд зохиогчтой олон нийтэд нээлттэйгээр мэтгэлцэх, санал солилцох боломжтой. 2. Блог эзэмшигчийн хувийн мэдээлэл, бичвэр, тэдгээрт хамаарах хэрэглэгчийн сэтгэгдэл бүхий хувийн вэбсайт.

Хувийн блог хөтлөгчийг блогчин хэмээн нэрлэдэг.

Бот - Интернэт хэрэглэгчтэй төстэй, зохиогч, бичигчийг нууцлах онцгой төрлийн компьютер програм

Шуурхай мэдээлэл (Англи хэлээр briefing; brief - товч танилцуулга;) - албан тушаалтнууд хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд тодорхой асуудлаар байр сууриа товч илэрхийлэх уулзалт. Мөн олон улсын хэлэлцээ, уулзалт, бага хуралд оролцогч талуудын тохиролцсон тодорхой асуудал, тэдгээрийн явцын талаарх мэдээлэл, талуудын саналын талаар мэдээлэх үйл явцыг хэлнэ.

Нөхцөл байдлын мэдээлэл (background) — шууд утгаараа “арын дэвсгэр” буюу үйл явдлын өмнөх нөхцөл байдал, шалтгааныг тайлбарлах, илүү ойлгомжтой болгох нэмэлт мэдээлэл. Энэ нь дуулиан шуугиан, шинэ мэдээ харин бичвэрийн бүтэц, найруулгад нөлөө бүхий нэмэлт мэдээлэл юм. Ихэнх тохиолдолд нөхцөл байдлын мэдээлэл нь өөрөө бие даасан өгүүлэмж бүхий, тодорхой үйл явдлыг тойрсон, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн агуулга байдаг.

Компьютерын бичиг үсэг буюу суурь мэдлэг - компьютер тоног төхөөрөмж, компьютерын шинжлэх ухаан, мэдээллийн технологийн суурь мэдлэг. Мэдээллийн суурь боловсрол, хэвлэл мэдээллийн чадамж, хэвлэл мэдээлэл бичиг үсэг зэрэг нэр томъёо, ойлголттой хавсран хэрэглэх нь бий.

Давхар нягтлах (cross checking)- мэргэжлийн хүмүүсээс давхар нягтлах аргачлал

Эцсийн хугацаа (deadline) (этгээд хэл: үхлийн шугам буюу 'death line') – материалыг хэвлэлд шилжүүлэх эцсийн хугацаа

Дижитал түрэмгийлэл - дижитал орчноос хүний сэтгэл зүйд үзүүлж буй дарамт. <...> Үүнд бүдүүлэг байдал, үл хүндэтгэл, хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг ойлголтыг зөрчих, хор хөнөөлтэй зан байдал, хор хөнөөл учруулах, дайрч довтлох бусдын орон зайд нэвтрэх заналхийлэх, шууд хүчирхийлэх зэрэг батгана.

Дата сэтгүүл зүй – Өгөгдөл боловсруулах, их хэмжээний тоон материалд суурилж сэтгүүл зүйн агуулга бүтээх сэтгүүл зүйн чиг хандлага, төрөл. Өгөгдөл нь тодорхой үйл явц, түүний эх сурвалжийг ил болгох боломжтой. Өгөгдлийн сэтгүүл зүй нь их хэмжээний мэдээллийг хадгалах, боловсруулах боломжийг олгодог технологийн хөгжил, мэдээллийн ил тод байдлын чиг хандлагатай холбоотой. Өгөгдлийн сэтгүүл зүй компьютерын шинжлэх ухаан, дизайн болон статистиктай холбоотой.

Сэтгэл хөдлөлөөр дамжуулах - сэтгэл хөдөлгөх аргаар агуулгыг хэрэглэгчдэд хүргэх арга, үйл явц. Жишээлбэл, Coca-Cola-гийн сурталчилгаанд аз жаргалтай, үзэсгэлэнтэй хүмүүсийг оролцуулах хэдий ч, бүтээгдэхүүний талаар ямар нэг зүйл өгүүлэхгүйгээр орхидог. Тухайн сурталчилгаа нь сайхан мэдрэмж, эерэг сэтгэл хөдлөлийг бий болгосноор хэрэглэгчид тэдгээр мэдрэмжийг бүтээгдэхүүнтэй холбож хүлээж авна. Энэ нь мэдээлэл харилцааны салбарт ашигладаг, бусдад нөлөөлөх хамгийн чухал бөгөөд түгээмэл арга юм.

Баримт - бодит байдлын талаар батлагдсан, найдвартай мэдлэг үйл явдал.

Фактоид - зөвхөн тодорхой хэсгийг нь нягталж баталгаажуулах боломжтой, үйл явдлыг хэсэгчлэн дүрсэлсэн мэдээлэл тэр төлөөлдөг зөвхөн зарим нь -ийн нь параметрууд -ийн юу болсон.

Баримт шалгах – нийтэд түгээсэн баримт мэдээлэл бодит баримттай нийцэж буй эсэхийг нягтлан шалгах үйл явц

Жендэрийн статистик - эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бодит амьдралыг тусгасан тоон мэдээллийг мэдээллийг тодорхойлох, бэлтгэх, түгээх үүрэг бүхий, уламжлалт статистикийн салшгүй хэсэг бөгөөд, эдгээр мэдээллийг жендэрийн бодлогыг боловсруулахад харгалзан үздэг.⁷⁸

⁷⁸ Development of gender statistics: a practical guide. United Nations, Geneva, 2010. x. 1.

Мэхлэл (Ноах) - огт байхгүй баримтаар хүмүүсийг төөрөгдүүлэх гэсэн санаатай оролдлого.

Дэгээ (Hook) (ижил утга: мэдээллийн үйл явдал) – хэсэг бүлэг хүнд тодорхой мэдээлэл түгээх, үзэл бодол төлөвшүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий, зохион байгуулалттай үйл явдал.

Хувь хүний мэдээллийн соёл - хүний ерөнхий соёлын бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг; уламжлалт болон шинэ мэдээллийн технологийг ашиглан хувь хүний мэдээллийн хэрэгцээг оновчтой хангах зорилготой бие даасан үйл ажиллагаа, мэдээллийн төлөв байдал, мэдлэг, ур чадварын тогтолцоо. Энэ нь мэргэжлийн болон мэргэжлийн бус үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх, түүнчлэн нийгэм дэх хувь хүний нийгмийн аюулгүй байдлын хамгийн чухал хүчин зүйл юм (Gendina, N. I. 2002).

Оруулга – үсгийн хэмжээ, хүрээ, өнгө, шугам зэрэг дүрсний элементээр анхаарал татах текст эсвэл эшлэлийг бие даасан текстийн блок болгож тодотгох. Оруулга нь текст дотор байрлах бөгөөд энэ нь урт, их хэмжээний текстийг сааруулах боломжийг олгодог. Бичвэрийг уншихад түлхэц өгөх үүрэгтэй.

Хэвлэл мэдээллийн нөлөөлөл - хэвлэл мэдээллийн агуулга хэрэглэгчдийн боловсрол, хүмүүжил, ухамсрын хөгжил, зан төлөв, хандлага, хариу үйлдэл, мэдээлэл түгээх зан зүйл зэрэгт нөлөөлж буй байдал.

Хэвлэл мэдээллийн соёл - хэвлэл мэдээллийн салбарын материаллаг болон оюуны үнэт зүйлсийн багц; тэдгээр үнэт зүйлс нийгэмд түгэн дэлгэрэх үйл ажиллагааны түүхэн тогтолцоо; Хэрэглэгчдийн хувьд «хэвлэл мэдээллийн соёл» ба «аудиовизуал соёл» нь хэвлэл мэдээллийн агуулгыг хүлээн авах, үнэлж дүгнэх, шинжлэх, хэвлэл мэдээллийн бүтээлч үйл ажиллагаанд оролцох, шинэ мэдлэгийг өөртөө шингээх чадвартай хэвлэл мэдээллийн салбар дахь хүний хөгжлийн түвшний тогтолцоо байж болно.

Медиа текст - хэвлэл мэдээллийн үйлдвэрлэлийн тодорхой үр дүн: мэдээлэл агуулсан, аль ч төрлийн мэдээллийн сувгаар (сонин, телевизийн шоу, видео клип, кино гэх мэт) түгээсэн байж болох утга санаа.

Хэвлэл мэдээллийн хэл —медиа текст үүсгэхэд ашигладаг илэрхийллийн хэрэгсэл, арга техникийн багц.

Хэвлэл мэдээллийн суурь боловсрол - орчин үеийн ертөнцөд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны нийгэм-соёл, улс төрийн нөхцөл байдлыг ойлгох, хэвлэл мэдээллийн эх бичвэрийг ойлгох, бүтээх, шинжлэх, үнэлэх чадвартай, хэвлэл мэдээллийн бичиг үсэгт тайлагдсан хүнийг бэлтгэх үйл явц юм; хэвлэл мэдээллийн агуулгыг янз бүрийн хэлбэрээр ашиглах, дүн шинжилгээ хийх,

үнэлэх, илгээх чадвар⁷⁹ Хэвлэл мэдээллийн суурь боловсролтой хүний нийгэм, дэлхий дээрх амьдрал иргэний хариуцлагатай холбоотой байдаг.

Хэвлэл мэдээллийн шүүмж - бол сэтгүүлзүйн тусгай салбар бөгөөд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны бодит байдал, чиг хандлагыг ойлгоход туслах зорилготой. Энэ нь зах зээлийн орчин дахь хэвлэл мэдээллээр түгээж буй өнгөц дүрслэл, олон нийтийн санаа бодлоос хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийгөө танин мэдэх өвөрмөц арга хэлбэр юм.⁸⁰

Хэвлэл мэдээллийн боловсрол (Media education) – мэдээллийн харилцааны (хэвлэл, телевиз, радио, кино, видео) чиг хандлагыг судлахыг дэмждэг сурган хүмүүжүүлэх чиглэл юм. Хэвлэл мэдээллийн боловсролын үндсэн зорилтууд: шинэ үеийг орчин үеийн мэдээллийн орчинд амьдрахад бэлтгэх, бодит мэдээллийг хүлээн авах, хүнийг ойлгоход сургах, түүний сэтгэцэд үзүүлэх нөлөөллийн үр дагаврыг ухамсарлах, хүнтэй харилцах арга зам, техникийн хэрэгслийг ашиглан аман бус харилцааны хэлбэрүүдийн эзэмших.

Хэвлэл мэдээллийн ойлголт (media perception) - хэвлэл мэдээллийн бодит байдлын талаарх ойлголт, хэвлэл мэдээллийн агуулгын талаарх мэдрэмж, бодол санаа.

Хэвлэл мэдээллийн нууцлаг байдал (media mystification) - мэдээллийн талбарт бүтээгдсэн зохиомол түүх (үйл явдал, үзэгдэл) бөгөөд энэ нь хэд хэдэн үнэмшилтэй баримтаар баталгаажсан, хэвлэл мэдээллийн хэрэгслийг зөвтгөх шалтгаан болгож ашигладаг.

Хэвлэл мэдээллийн хуурамч мэдээлэл - мэдээллийн хэрэгслээр худал мэдээлэл түгээх төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай үйл ажиллагаа.

Ташаа мэдээлэл (Misinformation) - үзэгчдэд бодит байдлын өрөөсгөл дүр зургийг бий болгох төрлийн мэдээлэл.

Mockumentary (Англи хэлээр шууд утгаар: элэглэл ба баримтат кино) нь бодит байдлыг хуурамчаар дуурайлган бэлтгэдэг баримтат кино.

Шоглогчид - ихэвчлэн нэрээ нууцалж утсаар ярьдаг, эсвэл интернэтэд хуурамч данс үүсгэн ашигладаг нууц хэрэглэгч.

Дахин бичих (Rewriting) - өөр өөр эх сурвалжийн бичвэр, агуулгыг ашиглах, бусад зохиогчдын материалыг дахин боловсруулах аргаар мэдээ, нийтлэл, өөрийн бичвэрийг бий болгох.

79 Kubey, R. Media Education: Portraits of an Evolving Field. In: Kubey, R. (Ed.) Media Literacy in the Information Age. — New Brunswick & London: Transaction Publishers, 1997, x.2

80 A. P. Korochenas "The Fifth Power?" Phenomenon of Media Criticism in the Context of the Information Market. <http://old.kpfu.ru>

Шинжлэх ухааны ид шид - хүмүүсийн амин чухал хэрэгцээг хангахад чиглэсэн ашиг хонжоо эрэлхийлэх зорилгоор шинжлэх ухааны нууцлагдмал шинж чанарыг товойлгосон нийтлэл.

“Зөөлөн” мэдээ - аливаа үйл явдлын эцсийн үр дүнд биш харин түүний нарийн ширийн зүйлийг онцолсон мэдээлэл

Нийгмийн мэдээллийн сүлжээ - онлайн үйлчилгээ, нийгмийн харилцаа холбоог бий болгох, холбоо тогтоох, мэдээлэл боловсруулах, түгээх боломжийг олгодог сайт. Нийгмийн мэдээллийн сүлжээний гол онцлог нь хамгийн олон төрлийн мэдээллийг хуваалцах бараг хязгааргүй боломж юм. Нийгмийн сүлжээний сайт нь хэрэглэгчдэдээ «найзууд»-ын хоорондох сүлжээг хянах, янз бүрийн бүлэгт нэгдэх, бүлгүүд үүсгэх, профайлын мэдээллээ бусдад нээлтэй болгох, эсвэл хаах, найз нөхдийнхөө нийтэлсэн контент дээр сэтгэгдэл бичих гэх мэт олон боломжийг олгодог.

Он цагийн товчоон (timeline) - тодорхой хэрэглэгчийн бүх нийтлэлийн түүх. Энэ нь сүлээн дэх бүх үйл явдлыг он цагийн дарааллаар харуулсан соронзон хальс мэт зүйл юм.⁸¹

Троллох (Trolling) - хэрэглэгчдийн дунд сөрөг хандлага, хариу үйлдэл өдөөх зорилгоор өдөөн хатгасан агуулга нийтлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа. Тэд хувь хүн хэсэг бүлэг хүнийг өдөж мөшгөдөг. Сүлжээний троллууд мөн бүлэг болж үйл ажиллагаа явуулж, зохицуулалттай эсвэл санамсаргүй сэтгэл зүйн дайралт хийж болно.⁸² Троллинг нь мессежийг дамжуулан түгээх зохион байгуулалттай систем бөгөөд тэднийг жинхэнэ хүмүүсийг хаягаар удирддаг.

Троллууд - сүлжээний хэрэглэгчид, дүрэм ёсоор, сүлжээний харилцан үйлчлэлийн ёс зүйг зөрчиж, зөрчилдөөнийг өдөөх янз бүрийн хэлбэрийн түрэмгий, доромжилсон үйлдлийг зохион байгуулдаг

Баталгаажуулах (Verification) - хүлээн авсан болон дамжуулсан мэдээллийн нийцтэй, зохистой байдлыг логик аргаар тодорхойлох.

81 IQ-coaching educational portal. <http://www.iq-coaching.ru>

82 What is digital aggression. Maxim Kornev, MediaToolbox.ru expert, <http://sdelano.media/project/stoptrolls/>

1. Riga Recommendations on Media and Information Literacy in a Shifting Media and Information Landscape.
2. Amzin A. A. News Internet journalism. M.: Aspect Press, 2012. 143p.
3. Bakanov R. P., Simkacheva M. V., Tumanov D. V., Journalism for beginners: A textbook for university students. — M.: “AspectPress”, 2018.
4. L. Vasilyeva. Making News! — M.: Aspect Press, 2003. 188 p.
5. Viren V., Frolova T. Information agencies. How news is made. — M.: Aspect Press, 2015. 176 p.
6. Gradyushko A. A. Fundamentals of journalism. The organisation of the media editorial. Minsk: Belorussian State University, 2005. 104 p.
7. Grizzle, A. (2018). Assessing Citizens' Responses to Media and Information Literacy Competencies through an online course: An Empirical Study and Critical Comparative Analysis of Experts' Views. Doctoral Dissertation. ISBN: 9788449084775: <http://hdl.handle.net/10803/666860>. Tesis Doctorals en Xarxa (TDX). Autonomous University of Barcelona, Spain.
8. Grizzle, A. (2014). Measuring Media and Information Literacy: Implications for the Sustainable Development Goal. In Singh, J., Grizzle, A., et al (2015). Media and Information Literacy for the Sustainable Development Goals. International Clearinghouse on Children, Youth and Media, NORDICOM, University of Gothenburg, Sweden.
9. Jelazny D. Speak in the language of diagrams: a guide for visual communication for managers / M.: Institute for Integrated Strategic Studies, 2004. - 220 p.
10. Media and Information Literacy in Knowledge Societies / Comp. Kuzmin E. I., Parshakova A. V. — Moscow: ICBC, 2013. — 384 p.
11. N. I. Gendina. The UNESCO Media and Information Literacy Curriculum for Teachers as an object for analysis and adaptation in Russia and Uzbekistan. // Media education. Media Education, 2017. No. 3. P. 27–44
12. Media and information literacy in knowledge societies / Comp. Kuzmin E. I., Parshakova A. V. — Moscow: ICBC, 2013. — 384 p.
13. N. I. Gendina. The UNESCO Media and Information Literacy Curriculum for Teachers as an object for analysis and adaptation in Russia and Uzbekistan. // Media education. Media Education, 2017. No. 3. P. 27–44.
14. N. I. Gendina. Formation of information and media literacy in the conditions of knowledge society: a new UNESCO initiative and the problems of Russian information education. // Pedagogy. Psychology. Issue #1 / 2012. P. 140–161
15. Julie Posetti, Alice Matthews. A Short Guide to the History of ‘Fake News’ and Disinformation. <https://www.icfj.org>
16. What is digital aggression. MediaToolbox.ru expert Maxim Kornev, <http://sde->

lano. media/project/stoptrolls/

17. Kozlovsky, B. Maximum repost: How social networks make us believe the fake news / Borislav Kozlovsky. — M.: Alpina Publisher.
18. Alcott, H. & Gentzcow, M. (2017). Social Media and Fake News in the 2016. Elections. *Journal of Economic Perspectives* 31(2),
19. IQ coaching educational portal. <http://www.iqcoaching.ru>
20. MILID Yearbook 2013: Media and Information Literacy and Intercultural Dialogue / Ed. Ulla Carlsson, Sherri Hope Culver, 2013. — 416 p.
21. Recommendations Addressed to the United Nations Educational Scientific and Cultural Organization / UNESCO // Education for the Media and the Digital Age. — Vienna: UNESCO, 1999. — P. 273–274.
22. The Second European Conference on Information Literacy (ECIL) / Abstracts // Editors: S. Spiranec, S. Kurbanoglu, R. Catts, E. Grassian, D. Mizrachi, M. Banek Zorica. — Zagreb, 2014. — 239 p.
23. Cyber Leninka: <https://cyberleninka.ru/article/n/sovremennye-tendentsii-razvitiya-mediai-informatsionnoy-gramotnosti-v-mire>
24. Online service <http://checklists.expert>
25. <https://www.poynter.org/channels/fact-checking>
26. UNESCO (2018) World Trends in Freedom of Expression and Media Development, Global Report 2017/2018. UNESCO (Paris). <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000261065>. Accessed on 22 July 2019.
27. White, A. (2008). To Tell You The Truth. The Ethical Journalism Initiative. Brussels, Belgium: International Federation of Journalists.

ХАВСРАЛТ 1

ХММСБ-ын талаарх зарим тайлбар бүхий хэрэгцээтэй материал

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол гэж юу вэ: Үзэл баримтлал, тодорхойлолт, арга барил, гол оролцогч талууд, хэрэгсэл?

ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан материалууд (бүгдийг ЮНЕСКО-гийн вэбсайтаас олж авч болно):

1. Ном, товхимол

Багш нарт зориулсан хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын сургалтын хөтөлбөр

Багш нар бол бичиг үсэгт тайлагдсан нийгэмд хүрэх гарц юм. Иймд энэхүү багш нарт зориулсан Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын сургалтын хөтөлбөр нь бүх төрлийн сурган хүмүүжүүлэгчдэд ХММСБ-ын үндсэн чадамжийг (мэдлэг, ур чадвар, хандлага) эзэмшүүлэх хэрэгсэл болох зорилготой юм. Уг гарын авлага нь багш нарт ХММСБ-ыг хичээлдээ нэвтрүүлэхэд шаардлагатай сурган хүмүүжүүлэх арга барилд анхаарлаа хандуулсан болно.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол: Бодлого, стратегийн удирдамж

ХММСБ-ын бодлого, стратегийн удирдамжийн энэхүү иж бүрэн эх сурвалж нь ХММСБ-ыг нийлмэл ойлголт гэж үзэж, мэдээллийн суурь боловсрол, хэвлэл мэдээллийн мэдлэгийг нэгтгэхээс гадна үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, МХХТ-ээр дамжуулан мэдээлэл авах эрхийг авч үзсэн анхдагч бүтээл юм. Эдгээр удирдамж нь уялдаа холбоотой хандлагыг санал болгосон. Ингэснээр оролцогч талууд ХММСБ-ыг дэмжих үйл явц, агуулгын аль алиныг нь харгалзаж үзсэн, илүү тогтвортой үндэсний ХММСБ-ын бодлого, стратегийг хөгжүүлэхэд тус болох юм.

Хэрэглэгчийн үүсгэсэн контент болон ХММСБ-ыг дэмжин дэлгэрүүлэх өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд зориулсан удирдамж

Өргөн нэвтрүүлэг эрхлэгчид хэрэглэгчийн үүсгэсэн контентыг дэмжих, хэвлэл мэдээлэл, мэдээллийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэрхэн зоригжуулах тухай удирдамжийг дэлхийд анх удаа нийтэллээ. Энэхүү удирдамж нь олон нийтийг хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь мэдлэг, боловсролтой болоход туслах зорилготой юм.

Хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан иргэний боловсрол: Сургалтын гарын авлага

ЮНЕСКО-оос хэвлэл мэдээллийн чиг үүрэг ба идэвхтэй иргэний харилцааны талаарх энэхүү сургалтын гарын авлагыг хөгжиж буй орнуудын хэвлэл мэдээллийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх сэтгүүл зүйн боловсролын цуврал арга хэмжээний хүрээнд хэвлүүлсэн байна. Уг эмхэтгэл нь ардчилал, хүний эрхийн үндсэн зарчмуудад суурилсан ардчилал, хөгжил, хэвлэл мэдээллийн үндсэн уялдаа холбоонд анхаарлаа хандуулсан болно.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол: Хүний эрхийг бэхжүүлэх, радикализм, хэт даврах үзэлтэй тэмцэхүй

Энэхүү ном нь хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын талаарх олон улсын үзэл баримтлал, туршлагын талаар мэдлэг олгоно. Уг ном Олон нийтийн эрх мэдэл ба тогтвортой хөгжил; Үзэн ядсан үг хэллэг, өдөөн хатгалга; Радикализм ба экстремизм; Хүний эрх ба жендэрийн тэгш байдал; болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр шашин хоорондын болон соёл хоорондын яриа хэлэлцээ өрнүүлэх тухай зэрэг бүлгүүдээс бүрдэж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол

2015 оны MILID эмхэтгэлд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг тогтвортой хөгжлийн нээлттэй, хүртээмжтэй хэрэглүүр болгон ашиглах тухай харуулсан. Уг эмхэтгэлийг судалгааны үр дүн, ХММСБ-ын онол, практик, тодорхойлсон сэдэвт анхаарлаа төвлөрүүлсэн бодит кэйс жишээнд тулгуурлан бүтээсэн байна.

Дижитал ертөнцөд дэлхийн иргэншил

MILID Yearbook 2014 нь дэлхийн өнцөг булан бүрээс дэлхийн иргэншлийн сэдвийг тодорхойлсон тойм нийтлэлүүдийн эмхэтгэл юм. Нийтлэлүүд нь судлаач, сэтгүүлчдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн мэдлэгийн талаарх зоримог шинэ стратегийг санал болгож, судалгааны үр дүн, шилдэг туршлага, байр суурь эргэцүүлэл зэргийг санал болгодог.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол, соёл хоорондын яриа хэлэлцээ

Энэхүү эмхэтгэлийг иргэний оролцоо, ардчилал, хөгжлийг дэмжихэд хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын гүйцэтгэх үүргийг ажиглах, түүнчлэн ХММСБ-ын талаарх соёл хоорондын болон хамтын ажиллагааны судалгааг сайжруулахад зориулж хэвлэсэн. 2013 оны эмхэтгэлийн редактороор Шерри Хоуп Калвер, Улла Карлссон, Катарина Бухт, Мария Эдстрём нар хамтран ажилласан.

Ойрхи Дорнод ба Хойд Африкт хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролыг дээшлүүлэх боломжууд

Энэхүү ном нь ХММСБ-ын ажлын ахиц дэвшлийн тухай одоо байгаа сургалт, судалгааны бүтээлийн цоорхойг нөхөх зорилготой. Тухайн бүс нутагт гэрэл гэгээ тусгах нь онцгой ач холбогдолтой хэмээн үзэж, уг номыг бэлтгэсэн аж. MENA-ийн бүс нутагт сүүлийн жилүүдэд залуу иргэдийн хэвлэл мэдээллийн хэрэглээний асуудалд анхаарал хандуулж, нийтэлж, нэвтрүүлэх нь түгээмэл болж, ХММСБ-ын чадамжийн талаарх мэдлэг ойлголт улам бүр газар авч байна.

ЮНЕСКО-гийн ХММСБ-ын үнэлгээний олон улсын аргачлал

ЮНЕСКО-гийн ХММСБ-ын үнэлгээний тогтолцоо нь улс орны ХММСБ-ын үндэсний үнэлгээ, ялангуяа багш нарын бэлэн байдал, чадамжийг үнэлэх арга зүйн удирдамж, практик хэрэгслийг санал болгодог.

Мэдээллийн суурь боловсролын тухай ойлголт: Праймер

Энэхүү нийтлэл нь «мэдээллийн суурь боловсрол» гэх ойлголтыг тайлбарласан, уншихад хялбар, техникийн бус тойм бөгөөд завгүй төрийн бодлого боловсруулагч, бизнесийн удирдлага, иргэний нийгмийн ажилтан, холбогдох мэргэжилтнүүдэд зориулагдсан болно.

Хэвлэл мэдээллийн боловсрол: Багш, сурагч, эцэг эх, мэргэжилтнүүдэд зориулсан багц

Энэхүү сургалтын иж бүрдэл нь уламжлалт болон шинэ хэвлэл мэдээллийн хэрэгслийг багтаасан, ХММСБ-ын тухай цогц ойлголтыг өгөх эмхэтгэл юм. Ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдийн улс төр, соёлын амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх шинэ арга замыг эрэлхийлсэн. Энэ нь тогтвортой хөгжлийн зорилгын үүднээс асуудалд хандаж, орчин үеийн нийгэмд тулгамдаж буй зарим сорилтуудыг, ялангуяа тоон мэдлэг ойлголтын ялгааны асуудлыг хөндсөнөөрөө онцлог юм.

Дэлхийн хэвлэл мэдээллийн боловсролын бодлогын зураглал: Алсын хараа, хөтөлбөр, сорилтууд

ЮНЕСКО, НҮБ-ын Соёл иргэншлийн холбоо, Европын Комисс, Grupo Comunicar хамтран гаргасан энэхүү хэвлэлд хэвлэл мэдээллийн боловсролд иж бүрэн, олон талт шинжилгээ, байр суурийг санал болгосон байна. Уг номд хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, боловсролын салбарын мэргэжилтнүүд, судлаачид, бодлого боловсруулагчдад зориулсан гол асуултуудын хариултыг өгөхийг зорьсон.

2. ХММСБ-ын онлайн мультимедиа сургалтын хэрэгсэл

<http://unesco.mil-for-teachers.unaoc.org/>

Энэхүү вэб сайт нь сурган хүмүүжүүлэгч, судлаач, хувь хүмүүст зориулсан олон улсын, мультимедиа, олон хэлээр хэвлэн нийтэлдэг мэдээллийн хэрэгсэл, ХММСБ-ыг дээшлүүлэх (MIL) сургалтын хэрэгсэлд хандах боломжийг олгодог. Уг хуудас албан болон албан бус боловсролын орчинд ашиглахаар санал болгож буй интерактив болон соёл хоорондын сургалтын эх сурвалжуудыг агуулдаг. Хэрэглэгчид уг сайтын агуулгыг өөрийн үзэмжээр хуваалцах, тохируулах, ашиглах, дахин байршуулах боломжтой. Эдгээр нь 9 хэл дээр нийтлэгдсэн бөгөөд ХММСБ-ын сургалтын хөтөлбөрийн бүтэц, загвараар зохион байгуулагдсан болно.

3. ХММСБ болон соёл хоорондын яриа хэлэлцээний онлайн сургалт

<http://www.unesco.org/new/en/communication-and-information/media-development/media-literacy/online-mil-and-intercultural-dialogue-courses/>

Интернэт дэх хувийн нууц, аюулгүй байдал, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл, хэвлэл мэдээлэл, технологийн ёс зүйн хэрэглээний сонголттой тулгарч буй эмэгтэй, эрэгтэй, охид, хөвгүүдэд шинэ төрлийн чадвар хэрэгтэй болоод байна. ХММСБ нь эдгээр чадварыг хөгжүүлдэг. Иймээс бүх нийтийн боловсролын агуулгад ХММСБ-ыг багтаах ёстой юм.

4. MIL CLICKS

MIL CLICKS нь хүмүүс Интернэт болон сошиал медиаг өдөр бүр тогтмол ашиглахдаа ХММСБ-ын ур чадвар эзэмшүүлэх, үзэх, тоглох, холбогдох, хуваалцах уур амьсгалд үе тэнгийнхний боловсрол олгох арга хэрэгсэл юм. Хэвлэл мэдээлэл болон бусад мэдээлэл нийлүүлэгчид нь ХММСБ-ыг олон нийтийн, иргэний боловсролын хөдөлгөөн болгоход гол үүрэг гүйцэтгэдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад мэдээлэл нийлүүлэгчдийн эрх чөлөө, хараат бус байдал, олон талт байдлыг хамгаалах ёстой ч тэд болон иргэний нийгмийн бүлгүүдийн хооронд үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх боломж бий.

<https://www.facebook.com/MILCLICKS/posts/>

5. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын клирингийн төв

Энэхүү клирингийн төв нь ХММСБ-ын талаарх мэдээлэл, нөөцийг олон хэлээр түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Уг төвөөс ХММСБ-ын сэдвүүдийг албан болон албан бус боловсролын орчинд нэвтрүүлж хөгжүүлэх боломжтой сурган хүмүүжүүлэгч нарт хандаж, шаардлагатай эх сурвалжийг санал болгодог.

<https://milunesco.unaoc.org/welcome/>

6. Сүлжээ

ХММСБ ба соёл хоорондын яриа хэлэлцээний их сургуулийн сүлжээ

ЮНЕСКО болон НҮБ-ын Соёл иргэншлийн холбоо (UNAOC) нь ХММСБ бүхий нийгмийг дэлхийн хэмжээнд сурталчлах зорилготойгоор ХММСБ, соёл хоорондын яриа хэлэлцээний олон улсын их сургуулийн анхны сүлжээг (ЮНЕСКО/UNAOC-) байгуулсан юм. (UNESCO/UNAOC-MILID).

ХММСБ-ын түншлэлийн дэлхийн холбоо (GAPMIL)

ХММСБ-ын түншлэлийн дэлхийн холбоо (GAPMIL) нь бүх иргэдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн чадамжтай болгоход чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэлэг хүчин чармайлт юм. Эдүгээ уг түншлэлд ная гаруй орны байгууллагууд хүчээ нэгтгэж, өөрчлөлтийн төлөө хамтран ажиллаж байна. Энэхүү анхдагч санаачилгыг 2013 оны 6-р сарын 26-аас 28-ны хооронд болсон ХММСБ-ын талаарх түншлэлийн дэлхийн форумын үеэр эхлүүлсэн байна.

Олон улсын түншлэгч байгууллагуудын эх сурвалжууд (Эдгээр байгууллагуудын вэбсайтаас илүү их материалтай танилцах боломжтой анхаарна уу):

IFLA

Олон улсын номын сан, байгууллагуудын холбоо (IFLA) нь номын сан, мэдээллийн үйлчилгээ, тэдгээрийн хэрэглэгчдийн эрх ашгийг төлөөлдөг олон улсын тэргүүлэх байгууллага юм. Уг байгууллага нь номын сан, мэдээллийн мэргэжлийн дэлхийн дуу хоолой юм.

<https://www.ifla.org/>

ERYICA

Европын Залуучуудын Мэдээлэл, Зөвлөх Агентлаг (ERYICA) нь үндэсний болон бүс нутгийн залуучуудын мэдээллийг зохицуулах байгууллага, сүлжээнээс бүрдсэн Европын бие даасан байгууллага юм. Залуучуудын мэдээллийн үйл ажиллагаа, үйлчилгээний салбарт Европын болон олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр ажилладаг. Залуучуудын мэдээллийн хэрэгцээг хангах, Европын Залуучуудын Мэдээллийн Хартийн зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгоор залуучуудын мэдээллийн чанартай ерөнхий бодлого, практикийг бүх түвшинд боловсруулж, дэмжиж, сурталчилдаг.

Тэдний сайн туршлагын товхимол нь шинэ төсөл, санааг сурч, урамшуулах, бий болгох, хөгжүүлэх зорилгоор эмхэтгэсэн амжилттай түүхүүдийн цуглуулга юм.

<https://www.eryica.org/tools-resources>

https://static1.squarespace.com/static/59ab1130ff7c50083fc9736c/t/5bd9654c-cd83666261ba9e53/1540973907525/Sheryica_2018_online2+%21f

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын төв

<https://centermil.org/resources/> Европын зөвлөл <https://www.coe.int/en/web/portal>

Европын комисс

https://ec.europa.eu/commission/index_en

Жей Смүүтийн Хэвлэл мэдээллийн боловсролын бэсрэг цуврал

1. Хэвлэл мэдээллийн боловсролын бэсрэг хичээлийн тойм
2. Хэвлэл мэдээллийн боловсролын удиртгал: Мэдээллийн мэдлэг олгох 1-р хэсэг
3. Хэвлэл мэдээллийн боловсролын түүх, Мэдээллийн мэдлэг олгох 2-р хэсэг:
4. Хэвлэл мэдээллийн боловсролын түүх, Мэдээллийн мэдлэг олгох 3-р хэсэг,
5. Хэвлэл мэдээлэл ба сэтгэлгээ, Мэдээллийн мэдлэг олгох 4-р хэсэг,
6. Хэвлэл мэдээлэл ба мөнгө, Мэдээллийн мэдлэг олгох 5-р хэсэг,
7. Нөлөөлөх ба ятгах: Мэдээллийн мэдлэг олгох 6-р хэсэг,
8. Онлайн сурталчилгаа: С Мэдээллийн мэдлэг олгох 7-р хэсэг
9. Медиа эзэмшил: Мэдээллийн мэдлэг олгох 8-р хэсэг
10. Хэвлэл мэдээллийн бодлого & Та: Мэдээллийн мэдлэг олгох 9-р хэсэг

<https://www.youtube.com/watch?v=sPwJ0obJya0&list=PL8dPuuaLjXtM6jSp-zb-5gMNsx9kdmqBfmY>

ХММСБ-ыг түгээн дэлгэрүүлж буй хэвлэл мэдээллийн практик жишээ

Долоон жилийн долоон түүх: Al Jazeera ran virtual reality workshops in Jordan's Za'atar refugee camp

<https://www.journalism.co.uk/video/telling-their-own-stories-al-jazeera-s-virtual-reality-workshops-in-jordan/s40/a719878/>

“Тэд бол зөвхөн үзэгчид биш, харин олон нийт»: <https://www.journalism.co.uk/>

news/-it-s-not-just-an-audience-it-s-a-community-how-the-economist-is-engage-with-young-people-on-instagram/ s2/a725173/

The Telegraph Snapchat Discover өсвөр насныханд хэрхэн хүрч байна вэ, <https://www.journalism.co.uk/news/how-the-telegraph-is-reaching-teenagers-with-news-stories-on-snapchat-discover /s2/a724198/>

Hashtag Our Stories нь иргэдийг илүү үр дүнтэй татан оролцуулах зорилгоор Snapchat линз ашиглаж байна, <https://www.journalism.co.uk/news/hashtag-our-stories-is-using-snapchat-lenses-to-turn-citizens-into -илүү-үр дүнтэй-түүх өгүүлэгчид/s2/ a733370/>

Сэтгүүлчид болон сургуулиуд ХММСБ-ын түгээн дэлгэрүүлэхэд хамтран ажилладаг, <https://en.ejo. ch/ethics-quality/journalists-schools-work-together-teach-media-literacy>

BBC интерактив тоглоомоор залуучуудад төөрөгдлийн экосистемийг илүү сайн ойлгоход тусалж байна.

ecosystem, <https://www.journalism.co.uk/news/with-an-interactive-game-the-bbc-is-helping-young-people-better-understand-the-disinformation-ecosystem-/ s2/a721168/>

Ёс сурахууны тухай түүх ярих: Сэтгүүл зүй ба ХММСБ, <https://ethicaljournalism- network.org/ethical-storytelling-journalism-media-literacy>

Зохиогч: Алтон Гриззл

Хянан тохиолдуулахад тусалсан: Денис Суреев Дизайн: Андрей Холматов

Лиценз: АИ №263 2014.12.31. Хэвлэ зөвшөөрөл 2019.12.01

Формат 70x100 1/16. Офсет хэвлэх. Фонт Myriad Pro

Хэвлэлийн газар «Бактрия пресс»

15/25, Ташкент хот

Утас/факс: + 998 (71) 233-23-84

Mega Basim-д хэвлэв

Baha Is Merkezi, Haramidere, Истанбул, Турк улс

www.mega.com.tr



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

Tashkent Office



British Embassy
Tashkent